



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ

# БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ

САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

## 2022-2023



УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ

# БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ

САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ  
2023 он

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам 2023 онд хэвлэв.

© БШУЯ

#### Хянасан:

П.Оюунаа	БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Т.Бат-Эрдэнэ	БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсийн дарга

#### Боловсруулсан:

Д.Анхзаяа	БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсийн шинжээч
П.Болормаа	БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсийн шинжээч

#### Хаяг:

Засгийн газрын III байр, Бага тойруу -44, Улаанбаатар -11 Монгол Улс

Цахим хаяг: <https://meds.gov.mn/>

И-мэйл: [Info@mecs.gov.mn](mailto:Info@mecs.gov.mn), [ankhzaya@mecs.gov.mn](mailto:ankhzaya@mecs.gov.mn)

Утас: 11-263600



## АГУУЛГА

01

БОЛОВСРОЛЫН  
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5

02

БОЛОВСРОЛЫН СУУРЬ  
ҮЗҮҮЛЭЛТ

19

03

СУРГУУЛИЙН  
ӨМНӨХ  
БОЛОВСРОЛ

41

04

БАГА, ДУНД  
БОЛОВСРОЛ

59

05

МЭРГЭЖЛИЙН  
БОЛОН ТЕХНИКИЙН  
БОЛОВСРОЛ

98

06

ДЭЭД  
БОЛОВСРОЛ

125

07

ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНОЛОГИЙН  
САЛБАР

143





## МЭНДЧИЛГЭЭ

Эрдэм ухааныг эрхэмлэн дээдлэгч Танд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьсан өөрчлөгдөж буй боловсролын салбарын ололт, амжилт, сорилт, сургамжийн өнөөгийн бодит байдал, цаашдын чиг хандлага болон нотолгоонд суурилсан бодлого, хэрэгжилтийн үр дүнг тоогоор илэрхийлсэн “Боловсролын салбарын статистикийн эмхэтгэл (2022-2023 оны хичээлийн жил)”-ийн хоёр дахь хэвлэлийг бэлтгэн та бүхэнд хүргэж байна. Аливаа ажлын үр дүнг хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэсэн хэлц үг байдаг.

Коронавируст халдварын цар тахлын нөлөөгөөр боловсролын салбарт урьдчилан тооцох боломжгүй эрсдэл, үр дагавар бий болсон хэдий ч хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн тасралтгүй үргэлжлүүлж, дижитал технологи ашиглан суралцах үр чадварт багш, суралцагчид хамтдаа суралцсан онцлог жилүүдийг бид тууллаа.

Өнгөрсөн хичээлийн жил боловсролын салбарт хууль эрх зүйн болон төсвийн шинэчлэлийн хүрээнд олон арга хэмжээ хэрэгжүүлсэн ололт, амжилт, сорилт ихтэй жил байлаа. Тухайлбал, цэцэрлэгийн “сугалаатай” бүртгэлийг халж, хүүхдийг анх удаа E-Монголиа цахим системээр бүртгэж, оршин суугаа хаягийн ойролцоо цэцэрлэгийн хуваарилалт хийлээ. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжсэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан, нийслэлийн түгжрэлийг буруулахад эерэг нөлөөлөл үзүүлсэн, хүнд суртал, авилгаас ангид, ил тод үйлчилгээ болж чадсан юм.

Цар тахлын үеэр цахим шилжилт илүү эрчимжиж, тодорхой үр дүнд хүрээд байна. Боловсролын салбарын цахим шилжилтийн туршлагаа олон улсад таниулж, 2022 оны 9 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын “Хувьсаж буй боловсрол” чуулганы үеэр Монгол Улс боловсролын цахим шилжилт, суралцагчдад тэгш боломж олгосон сайн туршлагаараа дэлхийн “Champion” орнуудын нэг болсныг НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас албан ёсоор зарлалаа.

Ирэх 2023-2024 оны хичээлийн жилд салбарын хөгжлийн үр дүнд хүрэхийн тулд тоон мэдээллийн анхан шатны бүртгэлийн чанарт анхаарч, хэрэгцээг хангахуйц чанартай, бодит мэдээллийг илүү дэлгэрэнгүйгээр боловсруулан хэрэглэгчдэд хүргэхэд онцгой анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

Хэрэглэгч Та бүхнийг энэхүү эмхэтгэлийг салбарын бодлого, төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах болон судалгаа, шинжилгээний ажилдаа өргөнөөр ашиглана гэдэгт итгэж байна. Эрхэм уншигч Та эмхэтгэлийн нүүрэнд байршуулсан QR кодыг уншуулж, цахим хэлбэрээр татан авах эсхүл холбоосыг цахим шуудандаа илгээх боломжтой.

Та бүхний эрдэм оюуны ажилд амжилт хүсье.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

**Л.ЭНХ-АМГАЛАН**



01

## БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

---

# 1.1 | МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

**Хүснэгт 1.1 Хүн амын боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэгийн үр дүнгийн харьцуулалт, 2010, 2020 он**

Үзүүлэлт	2010	2020	Өсөлт, бууралт, пункт
<b>10 ба түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хувь</b>			
<b>Боловсролгүй</b>	7.5	4.9	2.6 ▼
Эмэгтэй	6.9	4.6	2.3 ▼
Эрэгтэй	8.0	5.3	2.7 ▼
<b>Боловсролтой</b>	92.5	95.1	2.6 ▲
Эмэгтэй	93.1	95.4	2.3 ▲
Эрэгтэй	92.0	94.7	2.7 ▲
Бага	15.8	13.7	2.1 ▼
Суурь	17.9	17.1	0.8 ▼
Бүрэн дунд	32.0	29.2	2.8 ▼
Мэргэжлийн болон техникийн боловсролтой	2.8	3.9	1.1 ▲
Тусгай мэргэжлийн дунд боловсролтой	5.7	4.7	1.0 ▼
Дээд, түүнээс дээш боловсролтой	18.3	26.5	8.2 ▲
<b>15 ба түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувь</b>			
Бичиг үсэг мэддэг	98.3	98.7	0.4 ▲
Бичиг үсэг мэддэггүй	1.7	1.3	0.4 ▼
<b>6-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, хувь*</b>			
Сургуульд сурдаг	58.1	72.6	14.5 ▲
Сургуульд сурдаггүй	41.9	27.4	14.5 ▼
Хот	60.1	73.7	13.6 ▲
Хөдөө	53.8	70.6	16.8 ▲
<b>Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, хувь</b>	60.1	84.1	24.0 ▲

Тайлбар: \*Монгол Улсад оршин суугаа гадаадын харьяат болон харьяалалгүй иргэн ороогүй  
Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого-Нэгдсэн дүнгээс авав.




Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ. Үүнд:

- Хүний амьдрах (наслах) хугацааг тодорхойлох үзүүлэлтийг төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар;
- Боловсролын байдлыг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт болон бүх шатны боловсролд хамрагдалтын түвшингээр;
- Амьжиргааны зохистой түвшинг нэг хүнд ногдох ДНБ (худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн доллар)-ээр тус тус тооцно.


Эх үүсвэр: 1212.mn

Зураг 1.1 Монгол Улсын хүний хөгжлийн индекс, сонгосон оноор




Эх үүсвэр: www.1212.mn

Зураг 1.2 Хүний хөгжлийг хэмжих гол үзүүлэлтийн индекс, тэдгээрийн өөрчлөлт




Зураг 1.3 Хүний хөгжлийн индекс, аймаг, нийслэлээр, 2021 он






Зураг 1.4 Хүн амын боловсролын түвшний индекс, аймгаар, 2021 он



Зураг 1.5 Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт




Эх үүсвэр: IMD дэлхийн өрсөлдөх чадварын төв, МУ-ын эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Монгол Улс 2022 онд өрсөлдөх чадвараар **63 улсаас 61 дүгээрт эрэмбэлэгдэж**, өрсөлдөх чадварын ерөнхий оноогоор **36.2** болж өмнөх оноос буурчээ.



**Өрсөлдөх чадварыг** энгийнээр тайлбарлавал хүмүүсийнхээ боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанарыг хангахын тулд өөрийн нөөц бололцоо, чадамжаа хэрхэн уялдаатай ашиглаж байгааг харуулах үзүүлэлт юм.

Зураг 1.6 Монгол Улсын иргэдийн авьяас, ур чадварын түвшинг харуулах зарим үзүүлэлт



Эх үүсвэр: IMD дэлхийн өрсөлдөх чадварын төв, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

## 1.2 ХҮМҮҮН КАПИТАЛ


Хүмүүн капиталыг ерөнхийд нь хүмүүсийг бүтээмжтэй байхад нь тусалдаг мэдлэг, ур чадвар болон бусад хувийн шинж чанаруудын нөөц гэж тодорхойлж болно. Албан (сургуулийн өмнөх боловсрол, албан ёсны сургуулийн тогтолцоо, насанд хүрэгчдийн сургалт) болон албан бус боловсрол, ажлын байран дээр суралцах, ажлын туршлага хуримтлуулах нь хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийж буй хэрэг юм\*.

### ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ӨНДӨР Ч СУРАЛЦСАН ХУГАЦААГ СУРГАЛТЫН ЧАНАРТАЙ ДҮЙЦҮҮЛЭХЭД 3-4 ЖИЛЭЭР ХОЦОРЧ БАЙНА.


Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны хүн ам улам бүр боловсролтой болох хандлагатай байна. Монгол Улсын сургуульд сурсан дундаж жил (15 ба түүнээс дээш насны хүн амын) **9.1** байгаа нь Вьетнам, Тайланд, Казахстан зэрэг харьцуулсан орнуудынхаас өндөр байна. Гэсэн хэдий ч, дунджаар сургуульд суралцах тооцоолсон **13.2** жилээс сурлагаар дүйцүүлсэн сургуулийн жилийн тоо ердөө **9** байна. Энэ нь Монгол Улс хүний капиталын индексээр 51- д бичигдэж, орлогын түвшнээсээ (**92**) өндөр хэдий ч сурагч, оюутнууд сургуульд сурсан жилтэйгээ харьцуулахад дөрвөн жилээр хоцорч байна гэсэн үг.

Эх үүсвэр: Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлангаас, 2022 оны 6-р сар

\*Эх үүсвэр: <http://www.oecd.org/economy/human-capital/>




**Зураг 1.7 Хөдөлмөрийн насны хүн амын боловсролын түвшин, 2006-2020**




**Эх үүсвэр:** Ажиллах хүчний судалгаа (АХС) 2006–2020 болон Дэлхийн банк 2020а. Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлан, 2022 оны 6-р сар

Хүмүүн капиталын ашиглалтаар Монгол Улс харьцуулж буй орнуудаас доогуур түвшинд байна.

**Зураг 1.8 Сургуульд суралцах хугацаа ба шалгалтын оноо**



**Зураг 1.9 Нэг хүнд ногдох хүмүүн капиталыг зарим улс оронтой харьцуулбал: (2018 оны ам.доллар, тогтмол)**




**Эх сурвалж:** Үндэстнүүдийн баялгийг өөрчлөх нь (CWON) 2021 <https://www.worldbank.org/en/publication/changing-wealth-of-nations/data> Хүний капиталын баялгийн хэмжүүр нь өрхийн судалгааг ашиглаж хийсэн тооцоололд тулгуурладаг ба үр дүнгийн тохируулга нь ДНБ-д хөдөлмөрийн орлогын эзлэх хувьд суурилдаг. Энэхүү аргыг Дэлхийн банк (2021а)-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлан, 2022 оны 6-р сар



### Зураг 1.10 Ажил эрхлэлтийн байдлыг боловсролоор нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой иргэдийн дунд ажилгүйдэл хамгийн өндөр байна



**Эх үүсвэр:** 2010-2020 оны АХС-нд үндэслэн хийсэн Дэлхийн банкны тооцоолол. Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлан, 2022 оны 6-р сар

**Тайлбар:** Бүрэн дунд гэдэгт МСҮТ орсон.

#### ЗАЛУУЧУУД БОЛОН ДУНД БОЛОВСРОЛТОЙ ИРГЭДИЙН АЖИЛГҮЙДЭЛ ӨНДӨР БАЙНА.

Залуучуудын (15-24 насны) ажилгүйдлийн түвшин 2019 онд 25.3 хувь байсан бол 2020 онд 19.0 хувь болж буурчээ (Авдиенко ба бусад, 2022). Залуучуудын хувьд ажилгүйдэл өндөр байгаа нь олон улсын хандлагатай ерөнхийдөө ижил байна. Гэхдээ, Монгол Улсын залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын хэмжээний ажилгүйдлийн түвшнээс 2.5 дахин өндөр байгаа нь бусад улстай харьцуулахад арай өндөр талдаа байна. Нөгөөтэйгүүр, Монгол Улсын иргэдийн ажилгүйдлийн түвшинг боловсролын түвшнээр нь авч үзэхэд ердийн бус дүр зураг ажиглагдаж байна. Дунд боловсролтой, ялангуяа бүрэн дунд (техникийн болон мэргэжлийн боловсролыг оролцуулаад) боловсролтой иргэдийн ажилгүйдэл хамгийн өндөр байна. Энэ нь олон улсад ажиглагддаг боловсролын түвшин нэмэгдэх тусам ажилгүйдлийн түвшин буурдаг хандлагаас өөр байна (Бетчерман, Жалил нар, 2022).

**Эх үүсвэр:** Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлан, 2022 оны 6-р сар


#### ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО, ЯЛАНГУЯА БОЛОВСРОЛ БАГАТАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО БАГАСЧ БАЙНА.

Монголын эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин ДНБ-ийн хэмжээгээр ойролцоо бусад орнуудын дундаж түвшнээс дордохгүй байна. Гэсэн хэдий ч, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн оролцооны талаар сэтгэл зовних хэд хэдэн шалтгаан бий. Тэдний оролцооны түвшин жишиж харьцуулсан ойролцоо түвшний улс орнуудын эмэгтэйчүүдийнхээс доогуур, түүгээр ч зогсохгүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 15 нэгж хувийн зөрүүтэй, сүүлийн 10 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн оролцоо буурах хандлагатай байна. Ялангуяа, боловсрол багатай эмэгтэйчүүдийн оролцоо бага, гэхдээ боловсролын түвшин дээшлэх тусам эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байна. Залуу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ илүү боловсролтой болж байгаа тул цаашид эмэгтэйчүүдийн оролцоо аяндаа нэмэгдэнэ гэж бодож болох ч, эсрэгээрээ, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо боловсролын бүх түвшинд, тэр дундаа дээд боловсролтой эмэгтэйчүүдийн оролцоо буурсаар иржээ (2010-2020 оны хооронд жилд бараг 1 нэгж хувиар буурсан байна; Авдиенко болон бусад, 2022).

**Эх үүсвэр:** Дэлхийн банк групп, "Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ" нэгдсэн тайлангаас, 2022 оны 12-р сар



**Зураг 1.11 15 ба түүнээс дээш насны иргэдийн боловсролын түвшин, хүйсээр, 2010–2020 он**



Эх сурвалж: АХС-нд үндэслэн хийсэн Дэлхийн банкны тооцоолол

**Хүснэгт 1.2 Дэлхийн инновацийн индекс, орлогын түвшнээр**

Зэрэглэл	Дэлхийн инновацийн индекс 2021	Зэрэглэл	Дэлхийн инновацийн индекс 2021
<b>Өндөр орлоготой орнууд (Нийт 51 улс)</b>		<b>Дунджаас дээгүүр орлоготой орнууд (Нийт 34 улс)</b>	
1	Швейцарь (1)	1	Хятад (12)
2	Швед (2)	2	Болгар (35)
3	АНУ (3)	3	Малайз (36)
4	Британи (4)	4	Турк (41)
5	БНСУ (5)	5	Тайланд (43)
6	Нидерланд (6)	6	Орос (45)
7	Финланд (7)	7	Монтенегро (50)
8	Сингапур (8)	8	Серби (54)
9	Дани (9)	9	Мексик (55)
10	Герман (10)	10	Коста Рика (56)
<b>Дунджаас доогуур орлоготой орнууд (Нийт 34 улс)</b>		<b>Бага орлоготой орнууд (Нийт 13 улс)</b>	
1	Вьетнам (44)	1	Руанда (102)
2	Энэтхэг (46)	2	Тажикстан (103)
3	Украйн (49)	3	Малави (115)
4	Филиппин (51)	4	Мадагаскар (110)
5	<b>Монгол (58)</b>	5	Буркиа Фасо (115)
6	Молдав (64)	6	Уганда (119)
7	Тунис (71)	7	Мозамбик (122)
8	Марокко (77)	8	Мали (124)
9	Кени (85)	9	Того (125)
10	Узбекистан (86)	10	Этиоп (126)


Эх үүсвэр: УСХ, БШУЯ, "Инновац судалгаа хөгжүүлэлт", сэдэвчилсэн судалгааны тайлан, 2022 он

# 1.3 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ




Төсвийн шинэчлэлийг **"Хүртээмжээс-чанарт"** зорилгын хүрээнд боловсролын чанарыг хэмжиж, гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог цахим шилжилттэй хослуулан хэрэгжүүлж байна.

**Зураг 1.12 Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт төсөв, тэрбум төгрөг, 2018-2022 он**



**Тайлбар:** Боловсролын салбарын төсөвт боловсролын удирдлага, болон бусад байгууллагын төсвийг оруулан тооцсон болно.


**Зураг 1.13 Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2018-2022 он**



**Тайлбар:** Боловсролын салбарын төсөвт боловсролын удирдлага, болон бусад байгууллагын төсвийг оруулан тооцсон болно.

**Зураг 1.14 Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь, 2018-2022 он**

- Салбарын нийт төсвийн улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь
- Боловсролын салбарын төсвийн улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь
- Шинжлэх ухааны салбарын төсвийн улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь



**Тайлбар:** Боловсролын салбарын төсөвт боловсролын удирдлага, болон бусад байгууллагын төсвийг оруулан тооцсон болно.


**Хүснэгт 1.3 Боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт урсгал төсөв, тэрбум төгрөг, 2022 он**

	2022
<b>Нийт урсгал төсөв</b>	<b>1,964.3</b>
Сургуулийн өмнөх боловсрол	577.2
Ерөнхий боловсрол	1,145.2
Дээд боловсрол	43.2
Мэргэжлийн боловсрол	94.8
Шинжлэх ухаан, технологи	50.2
Насан туршийн боловсрол	2.9
Тусгай хэрэгцээт боловсрол	4.4
Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	36.1
Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	10.2

**Хүснэгт 1.4 Гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, мянган төгрөг, 2022 он**

Төслийн нэр	2022
Боловсролын чанарын шинэчлэл төсөл	6,901,157.2
Герман-Монголын ашигт малтмал, технологийн их сургуулийн өргөтгөл төсөл	720,000.0
Инженер технологийн дээд боловсрол төсөл	16,407,750.0
Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл	550,000.0
Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл	293,109.3
Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл	1,889,182.8
Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	34,217,961.0
<b>Нийт</b>	<b>60,979,160.3</b>

**Зураг 1.15 Нэг суралцагчид нэг жилд зарцуулдаг зардал, ам.доллараар, зарим улс орноор, 2019 он**



Эх үүсвэр: OECD (2023), Education spending (indicator). doi: 10.1787/ca274bac-en (Accessed on 08 April 2023)

# 1.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Боловсролын салбарт 2020-2024 онд **200** сургууль, **273** цэцэрлэг ашиглалтад оруулна.



**Хүснэгт 1.5 Боловсролын салбарт 2020-2024 онд ашиглалтад оруулсан сургууль, цэцэрлэгийн тоо, хүчин чадлын мэдээлэл**

Сургууль				
Он	Тоо, хүчин чадал	Эх үүсвэр		Бүгд
		Улсын төсөв	Гадаадын зээл тусламж	
2020	Тоо	32	5	37
	Хүчин чадал	12,840	4,120	16,960
2021	Тоо	19	6	25
	Хүчин чадал	6,260	3,800	10,060
2022	Тоо	34	2	36
	Хүчин чадал	19,798	1,280	21,078
2023	Тоо	76	4	80
	Хүчин чадал	32,850	2,020	34,870
2024	Тоо	17	5	22
	Хүчин чадал	9,600	1,280	10,880
<b>Нийт</b>	<b>Тоо</b>	<b>178</b>	<b>22</b>	<b>200</b>
	<b>Хүчин чадал</b>	<b>81,348</b>	<b>12,500</b>	<b>93,848</b>


  

Цэцэрлэг				
Он	Тоо, хүчин чадал	Эх үүсвэр		Бүгд
		Улсын төсөв	Гадаадын зээл тусламж	
2020	Тоо	54	7	61
	Хүчин чадал	7,435	740	8,175
2021	Тоо	35	4	39
	Хүчин чадал	5,535	300	5,835
2022	Тоо	39	2	41
	Хүчин чадал	7,070	250	7,320
2023	Тоо	117	8	125
	Хүчин чадал	18,180	1,420	19,600
2024	Тоо	7	4	11
	Хүчин чадал	1,475	550	2,025
<b>Нийт</b>	<b>Тоо</b>	<b>252</b>	<b>25</b>	<b>277</b>
	<b>Хүчин чадал</b>	<b>39,695</b>	<b>3,260</b>	<b>42,955</b>


Монгол Улсын төсвийн хөрөнгөөр (24,779.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий) дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын 4 байгууллагын хичээлийн байр, дотуур байрын барилга байгууламжийг 2022 онд хүлээн авч бүрэн ашиглалтад орууллаа.



Зураг 1.16 Хөрөнгө оруулалт, сая төгрөг, 2022 он



**Зураг 1.17 Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, сая төгрөг**




### АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг эхлүүлж, Монгол Улсын 330 гаруй сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нөхцөл байдалд судалгаа хийж, нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт” ТӨҮГ-тай хамтран нийт 819 объектын гадна нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгохоор 4 үе шат бүхий төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Улсын комисс ажиллуулах хүсэлт гаргасан 100 орчим байгууламж байна. 2022 онд 274 ариун цэврийн байгууламжийг хүлээн авч ашиглалтад оруулаад байна.



**Зураг 1.18 Сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төсөл (4-р ээлжийн ажилласан байдал) 2022 оны явц**






02

## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ


---




# 2.1 | МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ШИЛЖИЛТ



**Зураг 2.1 Бага, дунд боловсролын хамран сургалт, 2022/2023**




**Зураг 2.2 Ерөнхий боловсролын суралцагчдын анги дэвшилтийн хувь, 2022/2023**




## 2.2 | БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Зураг 2.3 Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, хичээлийн жилийн эхэнд




Зураг 2.4 Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар, 2022/2023



## 2.3 | БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СУРАЛЦАГЧ


Зураг 2.5 Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид, хичээлийн жилийн эхэнд




Зураг 2.6 Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид, хичээлийн жилийн эхэнд, хүйсээр



**Зураг 2.7 Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид, хүйсээр, 2022/2023**



**Зураг 2.8 Бүх шатны боловсролын байгууллагыг төгсөгчид, 2021/2022**



**Хүснэгт 2.1 Төгсөгчид ба шинэ элсэгчид**


	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой нийт төгсөгчид	43,690	45,916	53,619	-
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой төгсөгчдөөс 10-р ангид элсэгчдийн эзлэх хувь	-	78.0	79.4	72.7
Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролтой төгсөгчдөөс МБТБ-ын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	-	20.8	17.3	14.6
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой нийт төгсөгчид	29,644	35,850	32,908	-
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой төгсөгчдөөс МБТБ-ын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	-	7.1	4.4	4.1
Ерөнхий боловсролын сургуулийн бүрэн дунд боловсролтой төгсөгчдөөс дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн эзлэх хувь	-	65.0	70.4	60.3

## 2.4 | БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Хүснэгт 2.2 Нийт үндсэн багш, ажиллагчид, байгууллагын ангиллаар, мянган хүн

	Ажиллагчид				Үүнээс: Үндсэн багш			
	2019/ 2020	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023	2019/ 2020	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023
Нийт	95.4	101.3	103.3	106.2	49.9	52.2	52.1	53.0
Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага	11.3	12.0	12.2	32.5	8.1	8.8	8.8	9.4
Ерөнхий боловсролын сургууль	51.6	54.5	56.2	57.7	32.1	34.1	35.1	36.1
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага	4.4	4.1	3.9	4.1	2.4	2.2	2.1	2.3
Дээд боловсролын сургалтын байгууллага	28.1	30.7	31.0	11.9	7.3	7.1	6.1	5.2

Зураг 2.9 Нийт үндсэн багш, хүйс, өмчийн хэлбэр, боловсролын сургалтын байгууллагаар, 2022/2023



Нийт үндсэн багш 52,989		45,174	7,815	43,273	9,716
Дээд	5,169	3,366	1,803	3,169	2,000
МБТБ	2,252	1,806	446	1,460	792
ЕБС	36,118	31,880	4,238	29,546	6,572
СӨБ	9,450	8,122	1,328	9,098	352



## 2.5 | БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Хүснэгт 2.3 Сургуулийн өмнөх боловсролын шалгуур үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	Суурь түвшин /2019 он/	2020	2021	2022	Хүрэх түвшин 2025
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /2-5 нас/	хувь	<b>81.5</b>	79.2	76.9	86.5	➔ <b>89.4</b>
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /3-5 нас/	хувь	<b>86.6</b>	87.1	84.2	90.4	➔ <b>100.0</b>
5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь	<b>90.1</b>	92.1	91.3	93.4	➔ <b>100.0</b>
Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалтын хувь	хувь	<b>91.1</b>	94.3	97.2	93.3	➔ <b>100.0</b>
Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	<b>34.1</b>	29.7	29.0	30.6	➔ <b>25.0</b>
Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт /улсын дундаж/	тоо	<b>32.4</b>	29.1	28.2	30.0	➔ <b>25-30</b>

#### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРТЭЭМЖ, ХАМРАЛТ НЭМЭГДЭЖ БАЙНА.


2022-2023 оны хичээлийн жилд цэцэрлэгийн “сугалаатай” бүртгэлийг халж, хүүхдийг анх удаа **Е-Монголиа** цахим системээр харьяаллын дагуу **100% бүртгэж**, нэг ч хүүхдийг орхилгүй цэцэрлэгт хамруулах бодлогын үр дүнд хамран сургалт эрс нэмэгдсэн.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дэргэд салбар бүлэг байгуулж, ачаалалтай дүүргийн хувийн цэцэрлэгт хувьсах болон хоолны зардлыг нэмэгдүүлэн олгов. Мөн байгууллагын, түрээсийн, цомцог гэр зэргээр цэцэрлэгийн олон хэлбэрийг бий болголоо.


Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах “Сугалаагүй цэцэрлэг” бодлогыг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 86.5 болж, 2019 оны түвшнээс 5.0 пунктээр нэмэгдлээ.



Зураг 2.10 Сургуулийн өмнөх боловсролын 2-5 насны хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, дүүрэг, аймгаар, 2022/2023




Зураг 2.11 5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, дүүрэг, аймгаар, 2022/2023






Зураг 2.12 Сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт, дүүрэг, аймгаар, 2022/2023




Зураг 2.13 Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн тоо, 2022/2023



Тайлбар: УСХ-ны 2021 оны суурин хүн амыг нас дэвшүүлэх аргачлалаар тооцов.


Зураг 2.14 Сургуулийн өмнөх боловсролын жендерийн тэнцвэрт байдлын индекс, 2022/2023




## Хүснэгт 2.4 Бага, дунд боловсролын салбарын шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2019 он/	2020	2021	2022	Хүрэх түвшин 2025
Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин /1-9/	хувь	<b>94.9</b>	95.1	95.0	95.5	➔ <b>95.9</b>
Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо (улсын дундаж)	тоо	<b>31.1</b>	32.1	31.4	32.5	➔ <b>25</b>
Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо (хотод)	тоо	<b>34.6</b>	36.3	34.9	36.8	➔ <b>30</b>
Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо (орон нутагт)	тоо	<b>28.5</b>	29	28.7	29.2	➔ <b>25</b>
ЕБС - анги дүүргэлт (улсын дундаж)	тоо	<b>29.4</b>	28.7	29.2	30.2	➔ <b>25-30</b>
ЕБС - анги дүүргэлт (хотод)	тоо	<b>35.0</b>	32.9	33.1	33.4	➔ <b>25-30</b>
ЕБС - анги дүүргэлт (орон нутагт)	тоо	<b>28.0</b>	27.3	27.4	27.6	➔ <b>25-30</b>
Бага ангийн бүлэг дүүргэлт (улсын дундаж)	тоо	<b>31.7</b>	31.9	32.0	32.0	➔ <b>25-30</b>


## Зураг 2.15 Хамран сургалтын цэвэр жин




## Зураг 2.16 Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, 2022/2023



**Зураг 2.17 Монгол Улсын 2-24 настай хүн амын боловсрол, сургалтад хамрагдалт, нийт дүнд эзлэх хувь, 2022/2023**




**Тайлбар:** Сургуульд огт ороогүй, сургуульд ороод завсардсан хүүхдийн тоог салбарын 2022/2023 оны хичээлийн жилийн захиргааны статистикийн мэдээллээр цуглууллагдсан мэдээнээс авсан.



Жендерийн тэнцвэрт байдлын индекс нь тухайн шатны боловсролыг эзэмшиж буй 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэй сурагчийн тоог харуулна.

Бага, дунд боловсролын жендерийн тэнцвэрт байдал (ЖТБ)-ын индекс буюу ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд бага боловсролд 95, суурь боловсролд 97, бүрэн дунд боловсролд 119 байгаа нь жендерийн тэнцвэрт байдал боловсролын түвшин ахих тусам алдагдаж буйг харуулж байна.

**Зураг 2.18 Бага, дунд боловсролын жендерийн тэнцвэрт байдлын индекс, аймгаар, 2022/2023**




## Хүснэгт 2.5 Бага ангийн сурах бичгийн хангалтын хувь, 2022/2023


	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
Бэлтгэл хичээл	96.1				
Монгол хэл	95.0	91.2	92.2	92.2	91.6
Математик	94.8	90.6	91.8	91.6	90.7
Англи хэл					90.6
Хүн-нийгэм				90.4	90.4
Хүн байгаль				90.6	90.8
Хүн орчин	94.7	90.4	91.3		
Эрүүл мэнд				87.8	88.5
Дүрслэх урлаг, технологи	94.4	90.1	91.1	90.5	90.6
Хөгжим	93.3	89.2	90.3	88.7	89.3
Казак сурах бичгүүд	89.6	84.5	83.6	82.5	81.1
Монгол ёс, хүмүүжил	92.4	88.1	88.4	87.6	88.6




Зураг 2.19 Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь



Зураг 2.20 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хангалтын хувь



**Зураг 2.21 Ерөнхий боловсролын сургуулийн зарим онцлох чанарын үзүүлэлт**




**Эх үүсвэр:** Боловсролын үнэлгээний төв

**Хүснэгт 2.6 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын зарим онцлох хичээлийн гүйцэтгэлийн дундаж хувь, аймгаар, 2022/2023**

ҮЗҮҮЛЭЛТ	Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	Унших суурь чадвар эзэмшсэн 9-р ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9-р ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж
Улаанбаатар	62.6	62.0	61.3	36.8	513.4
Архангай	55.1	57.1	62.4	35.1	506.9
Баян-Өлгий	48.2	51.9	49.5	29.0	495.9
Баянхонгор	47.8	45.9	56.7	28.6	519.2
Булган	52.0	52.2	57.7	30.1	497.6
Говь-Алтай	54.9	55.6	63.0	36.2	499.9
Говьсүмбэр	48.1	49.4	56.3	28.1	508.7
Дархан-Уул	57.7	57.6	60.5	28.9	530.5
Дорноговь	47.6	47.9	55.7	27.2	515.4
Дорнод	59.6	58.7	57.9	36.9	527.1
Дундговь	49.9	54.1	57.7	29.4	500.2
Завхан	56.3	53.5	60.5	32.2	500.8
Орхон	60.5	59.9	60.2	36.5	513.2
Өвөрхангай	50.6	51.1	58.0	33.6	525.4
Өмнөговь	50.4	53.6	58.7	30.6	485.8
Сүхбаатар	51.0	51.7	57.6	28.2	512.6
Сэлэнгэ	54.8	53.6	59.8	32.3	504.8
Төв	54.5	54.9	62.5	34.1	504.0
Увс	57.7	53.9	61.0	34.4	519.8
Ховд	55.8	53.7	59.9	31.7	509.0
Хөвсгөл	60.3	62.2	58.4	32.7	501.0
Хэнтий	55.8	57.2	60.4	32.6	509.6

**Эх үүсвэр:** Боловсролын үнэлгээний төв

Зураг 2.22 Боловсролын чанарын үнэлгээний үр дүн, 2021/2022




Хүснэгт 2.7 Боловсролын чанарын үнэлгээний үр дүн, аймаг, дүүргээр, 2021/2022

Аймаг	Аймгийн дундаж	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Мэргэжлийн сургалтын байгууллага	Асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл	Мэдээлэлтэй ажиллах чадварын гүйцэтгэл	Хамтран суралцах
Архангай	34.90	36.43	41.63	35.54	24.09	30.67	50.67	60.04
Баян-Өлгий	25.15	20.04	31.13	28.11	19.16	21.43	43.46	50.30
Баянхонгор	33.35	32.69	41.01	33.05	26.87	28.49	52.82	58.40
Булган	34.45	33.30	41.23	34.62	24.08	30.22	54.21	53.53
Говь-Алтай	39.55	41.95	45.84	40.01	27.92	35.04	55.98	61.19
Говьсүмбэр	37.04	38.50	42.96	36.57	25.46	32.76	54.50	60.83
Дархан-Уул	37.09	34.83	46.75	40.06	29.52	31.84	57.49	59.81
Дорноговь	37.41	36.36	42.98	38.64	29.29	32.36	59.33	58.38
Дорнод	37.49	39.55	47.03	36.71	26.94	32.92	54.55	59.50
Дундговь	35.12	33.63	41.34	36.59	25.02	30.20	54.85	57.96
Завхан	36.63	37.69	41.75	40.91	26.46	32.49	52.01	56.43
Орхон	39.42	38.98	45.48	38.05	31.98	34.80	59.20	60.24
Өвөрхангай	40.44	42.31	47.49	39.91	27.57	35.65	58.80	61.71
Өмнөговь	37.56	34.63	43.71	40.57	31.20	32.67	59.34	59.70
Сүхбаатар	36.85	36.25	41.41	40.94	25.40	33.06	53.72	60.14
Сэлэнгэ	38.55	43.01	43.22	41.75	27.64	33.60	55.16	59.92
Төв	38.28	36.56	45.07	44.58	27.22	33.66	57.89	59.75
Увс	41.37	42.46	47.51	40.41	30.91	37.44	56.10	60.72
Ховд	33.42	33.38	40.33	33.67	26.38	28.83	51.62	52.89
Хөвсгөл	41.39	43.38	45.78	43.78	27.04	37.38	56.28	61.84
Хэнтий	35.75	30.65	44.73	35.18	29.07	31.19	57.54	57.83

Дүүрэг	Дүүргийн дундаж	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол	Мэргэжлийн сургалтын байгууллага	Асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл	Мэдээлэлтэй ажиллах чадварын гүйцэтгэл	Хамтран суралцах
Багануур	41.02	39.74	47.12	42.24	24.78	36.14	63.06	57.89
Багахангай	32.57	25.96	42.67	42.28		29.56	62.72	62.59
Баянгол	37.07	39.50	46.77	33.29	27.61	32.29	54.48	57.55
Баянзүрх	41.63	46.66	52.57	35.14	28.48	37.06	57.02	58.43
Налайх	33.81	32.02	44.76	33.21	26.82	28.81	54.21	56.96
Сонгинохайрхан	33.49	28.80	43.13	31.72	29.33	29.04	57.62	55.94
Сүхбаатар	39.98	37.14	48.85	33.45		35.49	61.50	56.78
Хан-Уул	37.15	38.49	44.87	32.34	29.68	32.27	56.05	58.24
Чингэлтэй	37.05	34.65	44.42	33.58	29.49	32.54	59.08	58.27

**Зураг 2.23 ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн (суралцагчдын бичгийн шалгалтын үр дүн), 2021/2022**



**Зураг 2.24 СӨБ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн (хүүхдийн хөгжлийн үнэлгээний үр дүн), 2021/2022**




### Хүснэгт 2.8 Сурагчдын зарим онцлох ерөнхий ур чадварын үнэлгээний гүйцэтгэл, хувиар, 2022/2023

Боловсролын түвшин	Асуудал шийдвэрлэх	Мэдээлэлтэй ажиллах	Хамтарч асуудал шийдвэрлэх
Бага	36.6		55.1
Суурь	36.9	68.2	60.9
Бүрэн дунд	29.3	52.0	60.7
Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	21.6	43.0	57.2

Эх үүсвэр: Боловсролын үнэлгээний төв

### Зураг 2.25 Ерөнхий боловсролын сургуулийн багш, багш бус ажиллагчдын харьцаа, нийт ажиллагчдын дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр, 2022/2023



**Тайлбар:** Бусад гэдэгт БНСУ дахь Монгол сургууль, Кембрижийн хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургуулиудыг хамруулав.





**Хүснэгт 2.9 Улсын хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн багшийн нийт хэрэгцээ, 2020-2050**

Он	Бага ангийн багшийн хэрэгцээ	Дунд ангийн багшийн хэрэгцээ	Ахлах ангийн багшийн хэрэгцээ
2020	15,847	15,740	7,482
2021	16,531	16,850	7,841
2022	17,308	18,037	8,252
2023	17,903	19,235	8,686
2024	18,289	20,361	9,157
2025	18,442	21,335	9,673
2026	18,332	22,098	10,199
2027	18,397	22,617	10,689
2028	18,443	22,866	11,099
2029	18,512	22,829	11,395
2030	18,704	22,489	11,558
2031	18,803	21,825	11,746
2032	18,586	21,438	11,790
2033	18,386	21,197	11,681
2034	18,216	21,105	11,413
2035	18,092	21,262	10,971
2036	18,024	21,004	10,851
2037	18,025	20,766	10,853
2038	18,131	20,556	10,976
2039	18,350	20,386	10,840
2040	18,678	20,269	10,709
2041	19,108	20,220	10,596
2042	19,631	20,267	10,499
2043	20,196	20,445	10,424
2044	20,784	20,761	10,379
2045	21,375	21,209	10,380
2046	21,942	21,771	10,436
2047	22,469	22,400	10,570
2048	22,962	23,067	10,779
2049	23,408	23,746	11,054
2050	23,799	24,412	11,368


**Эх үүсвэр:** ҮСХ, БШУЯ, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод суурилсан "Боловсролын салбарын хэтийн тооцоо 2020-2050 он" тайлангаас

**Тайлбар:**

Тооцоололд ашиглагдсан нөхцөл: Алсын хараа 2050

- Нэг багш 7 хоногт 19 цагийн хичээл заана
- Бүлэг дүүргэлтийн тоо 25 байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний 1 цаг буюу хичээл заасан 40 минутыг ажлын нэг цагаар тооцно. Энэ хугацаа бага сургуулийн нэг ба хоёрдугаар ангид 35 минут байна.
- 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана.
- Хичээлийн жилд 32 долоо хоног хичээллэнэ.
- "Багш зохицуулах цаг"-ийг хичээлийн цагт тооцно.

**Зураг 2.26 Мэргэжлийн болон техникийн боловсролын шалгуур үзүүлэлтүүд**



**Зураг 2.27 Дээд боловсролын шалгуур үзүүлэлтүүд**



Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн тойм судалгааны үр дүнгээс харахад, 2020-2021 оны хичээлийн жилд их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийг 50,895 иргэн төгссөнөөс 40,154 (78.9%) төгсөгч нь хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдагчдын 70.2 хувь ажил, хөдөлмөр эрхэлж байна.

**Эх үүсвэр:** БШУЯ-ны Цахим бодлого, статистикийн хэлтсээс албан хэрэгцээнд зориулан Дээд боловсролын 47 байгууллага, Мэргэжлийн болон техникийн боловсролын 73 байгууллагын хүрээнд хийсэн судалгааны үр дүнгээс авсан.

Дээд боловсролын хувьд удирдлага мэдээллийн системээр дамжуулан судалгаа ирүүлсэн сургуулиудын мэдээллийг нэгтгэн авсан.


Мэргэжлийн болон техникийн боловсролын хувьд 2022 оны 10 дугаар сард хийсэн тойм судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан.




## Хүснэгт 2.10 Төгсөгчид ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн матриц

Төгсөгч-2021/2022		"Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны 3-р улирал"		Төгсөгч-2021/2022	
<b>Их, дээд сургууль, коллеж</b>	<b>32,925</b>	<b>Ажлын байрны захиалга</b>	<b>32,972</b>	<b>Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага</b>	<b>22,251</b>
Боловсрол	6,001	Боловсрол	2,256	Боловсрол	8
Бизнес, удирдлага, эрхзүй	10,506	Бөөний болон жижиглэн худалдаа	1,267	Санхүү, бизнес, худалдаа	606
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй	1,901	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	316		
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	882	Мэдээлэл холбоо	375	Мэдээллийн технологи	1,245
				Шуудан, харилцаа холбоо	85
Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	4,225	Барилга	2,826	Барилга	4,182
		Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	329	Тээвэр	2,754
		Уул уурхай, олборлолт	3,818	Уул уурхай	1,553
		Боловсруулах үйлдвэрлэл	1,688	Аж үйлдвэр	7,291
		Цахилгаан, хий, уур, агааржуулалт	182		
		Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	340		
		Зочид буудал, байр нийтийн хоолны үйлчилгээ	484		
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй	348	ХАА, ойн загас барилт, ан агнуур	3,175	Хөдөө аж ахуй	1,248
Үйлчилгээ	1,685	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11,154	Үйлчилгээ	1,291
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	4,293	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	995	Эрүүл мэнд	196
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	767	Бусад үйл ажиллагаа	3,767	Хот байгуулалт, тохижуулалт	107
Урлаг, хүмүүнлэг, соёл урлаг	2,317			Соёл, урлаг	789
				Байгаль орчин, аялал жуулчлал	748
				Эрчим хүч	148

**Эх үүсвэр:** Хөдөлмөрийн зах зээлийн тойм судалгааны үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрхлэн гаргасан "Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал"-ын 23, 24 дүгээр нүүр хуудаснаас

**Зураг 2.28 Ажил олгогчдын чухалчилдаг зөөлөн ур чадварын шаардлага, ач холбогдлын эрэмбээр**

Ажил олгогчид ажил мэргэжлийн ур чадвараас илүүтэй зөөлөн гэж нэрлэгддэг хувь хүний үндсэн зан чанарт суурилсан ур чадварыг чухалчилдаг хэвээр байна. Хувь хүний үндсэн өгөгдөлт зан чанар, суурь хүмүүжил, ерөнхий хандлага, ес зүйг хамгийн чухал үзүүлэлт хэмээн үзсээр байгаа нь энэ удаа ч давтагдсан үзүүлэлт хэмээн үзсээр байна.

**Зураг 2.29 Ажил олгогчдын чухалчилдаг мэргэжлийн ур чадварын шаардлага, ач холбогдлын эрэмбээр**


Мэргэжлийн ур чадварын шаардлагын хувьд ажлын ёс зүй, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, түүнтэй холбоотой чадвар нь онцгойлон авч үзэх ур чадвар тул ажил олгогчид мэргэжлийн ур чадваруудаас хамгийн чухал ач холбогдолтой ур чадварын нэгээр нэрлэсэн байна.

**Эх үүсвэр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа 2021"

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2022 оны III улиралд ирсэн ажлын байрны захиалгын **11.1** мянга нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, **3.8** мянган нь уул уурхай, олборлолт, **2.8** мянган нь барилгын салбараас ирсэн байгаа бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд их дээд сургууль, коллежийг **32,925**, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг **22,251** суралцагч мэргэжил, ур чадвар эзэмшин төгссөн байна.



**Зураг 2.30 Нийт ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны III улирлын байдлаар**



\*Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрхлэн гаргасан "Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал" 23, 24 дүгээр нүүр хуудас



2022 оны III улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын **88** улсын **7,034** иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байгаагийн **40.8** хувь нь Улаанбаатар хотод, **33.7** хувь нь Төвийн бүсэд, **15.8** хувь нь Зүүн бүсэд, **5.7** хувь нь Баруун бүсэд, **4.1** хувь нь Хангайн бүсэд оршин сууж байна.

**Тодорхойлолт:**

- Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.
- Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

**Эх үүсвэр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрхлэн гаргасан "Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал" 37 дугаар нүүр хуудас HZZT-III-Mon.pdf (institute.gov.mn)



03

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

---



### САЛБАРЫН ОНЦЛОГ: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Улс орны хөгжлийг “хүний хөгжил”-ийн үзүүлэлтээр тодорхойлох болсон энэ цаг үед дэлхийн улс, үндэстэн бүр оюуны хязгааргүй нөөцөд суурилсан хүний хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд амьдрах чадамжтай иргэдийг бэлтгэхэд онцгой анхаарал хандуулж байна.

Хүний амьдралын эхний 1000 хоног буюу ураг бүрэлдэх үеэс 3 хүртэлх насанд хүүхдийн тархи, бие махбод, сэтгэл хөдлөл эрчимтэй хөгжих чухал үе бөгөөд 6 хүртэлх насны хүүхдийн хөгжил, амьдралын туршлага нь түүний амжилттай суралцах, ирээдүйд чанартай амьдрах эх үндэс болдог.

Бага насны хүүхдийн хөгжлийн эрт үед хөрөнгө оруулж, хөгжлийг дэмжих нь хувь хүний төдийгүй улс орны эдийн засгийн хөгжилд бүхэлд нь өндөр үр ашиг өгдөг болохыг нотолсон эрдэмтдийн судалгааны дүнд үндэслэн хүүхдийн эрт үеийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхийг чухалчилж байна.



## Хүснэгт 3.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн үзүүлэлт, 2022/2023

Үзүүлэлт	Бүгд	Хот	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
<b>Цэцэрлэгийн тоо</b>	<b>1,413</b>	<b>649</b>	<b>764</b>	<b>985</b>	<b>428</b>
Ердийн	1,405	644	761	982	423
Тусгай	6	4	2	2	4
Сувиллын	2	1	1	1	1
<b>Бүлгийн тоо</b>	<b>8,871</b>	<b>4,196</b>	<b>4,675</b>	<b>7,448</b>	<b>1,423</b>
Үндсэн	8,415	4,196	4,219	6,992	1,423
Хувилбарт	456	-	456	456	-
<b>Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид</b>	<b>266,024</b>	<b>127,278</b>	<b>138,746</b>	<b>231,583</b>	<b>34,441</b>
Үүнээс: Эмэгтэй	129,875	62,265	67,610	113,060	16,815
Эрэгтэй	136,149	65,013	71,136	118,523	17,626
<b>Цэцэрлэгт</b>	<b>250,457</b>	<b>127,278</b>	<b>123,179</b>	<b>216,016</b>	<b>34,441</b>
Үүнээс: Эмэгтэй	122,811	62,265	60,546	105,996	16,815
Эрэгтэй	127,646	65,013	62,633	110,020	17,626
<b>Хувилбарт</b>	<b>15,567</b>	<b>-</b>	<b>15,567</b>	<b>15,567</b>	<b>-</b>
Үүнээс: Эмэгтэй	7,064	-	7,064	7,064	-
Эрэгтэй	8,503	-	8,503	8,503	-
<b>Халамжид буй хүүхэд</b>	<b>3,460</b>	<b>1,543</b>	<b>1,917</b>	<b>3,086</b>	<b>374</b>
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд</b>	<b>1,498</b>	<b>839</b>	<b>659</b>	<b>1,224</b>	<b>274</b>
<b>Малчдын хүүхэд</b>	<b>33,657</b>	<b>1,146</b>	<b>32,511</b>	<b>33,151</b>	<b>506</b>
<b>Нийт багш, ажиллагчид</b>	<b>32,509</b>	<b>14,949</b>	<b>17,560</b>	<b>28,450</b>	<b>4,059</b>
Үүнээс: Эмэгтэй	27,752	13,055	14,697	23,946	3,806
Эрэгтэй	4,757	1,894	2,863	4,504	253
<b>Үндсэн багшийн тоо</b>	<b>9,450</b>	<b>4,584</b>	<b>4,866</b>	<b>8,122</b>	<b>1,328</b>
Үүнээс: Эмэгтэй	9,098	4,374	4,724	7,792	1,306
Эрэгтэй	352	210	142	330	22
<b>Туслах багшийн тоо</b>	<b>8,277</b>	<b>4,024</b>	<b>4,253</b>	<b>7,022</b>	<b>1,255</b>
Үүнээс: Эмэгтэй	8,266	4,019	4,247	7,016	1,250
Эрэгтэй	11	5	6	6	5
<b>Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт /Улсын дундаж/</b>	<b>30.0</b>	<b>30.3</b>	<b>29.7</b>	<b>31.1</b>	<b>24.2</b>
<b>Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /2-5 нас/</b>	<b>86.5</b>	<b>89.5</b>	<b>83.7</b>	<b>-</b>	<b>-</b>

Жич: Туслах багшийн тоонд ээлжийн багшийг оруулсан болно.




# 3.1 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт **1,413 цэцэрлэгт 266,024 хүүхэд** сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, **32,509 багш**, ажиллагчид ажиллаж байна.



**Зураг 3.1 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, түүнд хамрагдагчид**





Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт **1,413 хүүхдийн цэцэрлэг** үйл ажиллагаа явуулж байгаагийн **985 нь төрийн өмчийн, 428 нь хувийн өмчийн** цэцэрлэг байна.



**“Хүүхдийн цэцэрлэг”** гэж /цаашид “цэцэрлэг” гэх/ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг ойлгоно.


**Тайлбар:** Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 болон А/525 тоот тушаалаар “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг баталсан. Тус журмын хэрэгжилттэй холбоотойгоор 2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын салбарын элсэлтийн үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан. Энэхүү танилцуулгад 2021-2022 оны хаврын улиралд нэмэлтээр зохион байгуулсан элсэлтийн бүртгэлд үндэслэн нэгтгэсэн захиргааны статистикийн мэдээний үр дүнг оруулсан болно.

## Сургуулийн өмнөх боловсролд зориулсан хөрөнгө оруулалт:




Нийслэл болон орон нутагт цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020-2022 онд нийт **7,035** ор бүхий **39** цэцэрлэгийн барилгыг барьж ашиглалтад оруулсан.


**Зураг 3.2 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар**



**Зураг 3.3 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэр, байршлаар, 2022/2023**



**Зураг 3.4 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, сургалтын хэлбэрээр**



"Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт" (цаашид "хувилбарт сургалт" гэх) гэж оршин суудаг газар болон хөгжлийн бэрхшээлийн улмаас цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалтад тогтмол хамрагдах боломжгүй сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг ойлгоно.


## 3.2 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮЛЭГ

**Хүснэгт 3.2 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, өмчийн хэлбэрээр**

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
			Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2019/2020	8,122	6,451	5,774	677	1,671	1,671	0
2020/2021	8,499	6,871	6,240	631	1,628	1,628	0
2021/2022	8,419	6,965	6,481	484	1,454	1,454	0
2022/2023	8,871	7,448	6,992	456	1,423	1,423	0


“Бүлэг дүүргэлт” гэж нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

**Зураг 3.5 Бүлэг дүүргэлт, улсын хэмжээнд**



Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт дунджаар **30.0** болж 2019-2020 оны хичээлийн жилээс **2.4** пунктээр буурсан байна.

**Зураг 3.6 Бүлэг дүүргэлт, анги, өмчийн хэлбэр, байршил, сургалтын хэлбэр**



Улсын хэмжээнд цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт **29.8** байна. Харин төрийн өмчийн цэцэрлэгийн бүлэг дүүргэлт **31.1** байгаа нь хувийн цэцэрлэгээс **6.9** пунктээр дээгүүр байна.

## 3.3 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАГЧИД

Хүснэгт 3.3 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид, өмчийн болон сургалтын хэлбээр


Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үндсэн сургалт	Хувилбарт сургалт	Төрийн өмчийн цэцэрлэгт	Хувилбарт сургалт		Хувийн өмчийн цэцэрлэгт
					Үндсэн	Хувилбарт	
2019/2020	263,333	242,623	20,710	224,975	204,265	20,710	38,358
2020/2021	247,040	229,899	17,141	211,748	194,607	17,141	35,292
2021/2022	237,231	222,517	14,714	204,639	189,925	14,714	32,592
2022/2023	266,024	250,457	15,567	231,583	216,016	15,567	34,441

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт **266,024 хүүхэд** хамрагдаж байгаа нь өмнөх оноос **28,793 (12.1%) хүүхдээр** өссөн байна.

Монгол Улсын **Засгийн газрын 2022 оны "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 218 дугаар тогтоолын дагуу** цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг 2022-2023 оны хичээлийн жилээс авч хэрэгжүүлж байна.



Зураг 3.7 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхэд, бүлгээр, 2022/2023



Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/224 дугаар тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг баталсан.

"Нүүдлийн бүлгийн" гэж хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх зорилгоор тогтоосон хугацаанд төвлөрүүлэн зохион байгуулах танхимын сургалт, үйл ажиллагааг ойлгоно.


"Гэр бүлд суурилсан" гэж хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгт тулгуурлан багшийн чиглүүлэг, зөвлөмжөөр хэрэгжүүлэх /явуулын/ зайн сургалтыг ойлгоно.

### САЛБАРЫН ОНЦЛОГ: СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх **3-5 насны хүүхдийн** хамран сургалт **90.4** хувьтай байна. 2022/2023 оны хичээлийн жилд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд цаашид улсын хэмжээнд хэрэгжүүлж, сургуулийн өмнөх насны хүүхэд бүрийг үйлчилгээнд хамруулах зорилт тавин ажиллаж байна.




**Зураг 3.8 Монгол Улсын 2-5 насны хүн амын өсөлтийн урьдчилсан төлөв байдал**




**Тайлбар:** 2022 оны хүн амыг УСХ-ны 2021 оны суурин хүн амыг нас дэвшүүлж тооцон гаргасан.  
**Эх үүсвэр:** 2023-2050 оны хэтийн тооцоог БШУЯ, УСХ-ны "Боловсролын хэтийн тооцоо 2020-2050 он" тайлангаас авсан.

**Зураг 3.9 Хувийн өмчийн цэцэрлэгийн тоо, түүнд хамрагдсан хүүхдийн тоо**



## 5 НАСТАЙ ХҮҮХДИЙН ХАМРАН СУРГАЛТ

Зураг 3.10 Таван настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт



**Тайлбар:** 2022 оны 5 настай хүүхдийн тоог УСХ-ны 2021 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцсон.

**5 настай хүүхдийн** хамран сургалтын цэвэр жин 2022-2023 оны хичээлийн жилд **93.4** байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс **2.2 пунктээр өссөн байна.**




### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАГДАЛТ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО:

Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна.

Цэцэрлэгийн “сугалаатай” бүртгэлийг халж, хүүхдийг анх удаа E-Монголиа цахим системээр бүртгэж, оршин суугаа хаягийн ойролцоо цэцэрлэгт элсэн суралцах боломжтой боллоо.

Үр дүнд нь цэцэрлэгт хамрагдахыг хүссэн хүүхэд бүр аюулгүй ээлтэй хамгаалагдсан орчинд суралцах, эцэг эх, асран хамгаалагчид ажил хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлөөр хангагдсан.


**Зураг 3.11 Таван настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, аймгаар, 2022/2023**



**Зураг 3.12 Таван настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин, дүүргээр, 2022/2023**






**Зураг 3.13 Таван настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан тоо, сургалтын хэлбэр, 2022/2023**



## 3.4 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ

Зураг 3.14 2-5 настай нийт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байдал




Монгол Улсын Засгийн газраас санаачлан цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн бөгөөд цаашид улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Үүний үр дүнд 2022-2023 оны хичээлийн жилд 3-5 насны хүүхдийн **90.4** хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.




**Зураг 3.15 2-5 настай хүүхдийн хамран сургалтын цэвэр жин ба ажилгүйдэл, ядуурлын түвшний харьцуулалт, бүсээр, хувиар**




Эх үүсвэр: Ядуурлын үр дүнг УСХ-ны ӨНЭЗС-ны 2020 оны үр дүнгээс авсан. Ажилгүйдлийн түвшинг УСХ-ны 2021 оны АХС-ны жилийн эцсийн тайлангийн үр дүнгээс авсан.

**Зураг 3.16 2-5 насны нийт хүүхдийн дүнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан болон хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь, аймгаар, 2022/2023**




**Зураг 3.17 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо**






**Зураг 3.18 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2022/2023**



**Зураг 3.19 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй малчдын хүүхэд, аймгаар, 2022/2023**



## 3.5 БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ - ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 4.2.1




ТХЗ 4.2.1-д заасан шалгуурыг "Бага насны хүүхдийн хөгжлийн индекс"-ээр дараах үзүүлэлтийн хүрээнд хэмждэг. 3-4 насны хүүхдийн хөгжлийн дөрвөн айн хүрээнд дараах 10 асуултаар хөгжлийн явцыг үнэлсэн. Үүнд:


- **Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадамж:** Цагаан толгойн үсгээс хамгийн багадаа 10 үсэг таньдаг/нэрлэж чаддаг, наад зах нь дөрвөн энгийн түгээмэл үг уншиж чаддаг, 1-10 хүртэлх цифрийг нэрлэж, таньж чаддаг эсэхээр хүүхэд хөгжлийн зохих түвшинд байгааг үнэлдэг. Хэрэв хүүхэд эдгээрээс наад зах нь хоёрыг хийж чадаж байвал тус чадамж нь зохих түвшиндээ байна гэж үздэг.
- **Бие бялдрын хөгжил:** Хүүхэд хоёр хуруугаараа нарийн саваа, жижиг чулуу гэх мэт зүйлсийг газраас авч чаддаг, эх/асран хамгаалагч нь хүүхдээ заримдаа тоглохоос дургүйцэж, бие нь тавгүйрхэж сурддаггүй гэж хариулсан тохиолдолд тухайн хүүхдийн бие бялдрын хөгжил нь зохих түвшиндээ байна гэж үздэг.
- **Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадамж:** Хэрэв хүүхэд бусад хүүхдүүдтэй эвтэй найртай харилцдаг, бусад хүүхдийг өшиглөж, хазаж, цохидоггүй, анхаарал нь өөр юманд амархан сарнидаггүй бол нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадамж нь зохих түвшиндээ байна гэж үздэг.
- **Суралцах чадамж:** Хүүхэд энгийн зааврын дагуу ямар нэгэн зүйлийг зөв хийж, мөн хийлгэх гэж өгсөн зүйлийг зөв бөгөөд бие даан хийж, гүйцэтгэж байвал суралцах чадамж нь зохих түвшиндээ байна гэж үздэг.

Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

Зураг 3.20 Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, ТХЗ 4.2.1



Зураг 3.21 Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, (МУ-ын тодорхойлолтоор)



Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он




Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт цагаан толгойн үсэг нэрлэх, энгийн үгсийг унших зэрэг чадварыг багтаадаггүй тул өөрийн улс орны онцлогийг тусгасан зарим асуултыг асуулгад нэмж оруулж тооцсон.


Бага насны хүүхдийн хөгжлийн индекс 2010 оноос хойш буурах хандлагатай байна.



**Зураг 3.22** Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, хөгжлийн чадварууд нь зохих түвшинд байгаа 3-4 настай хүүхдийн хувь, үнэлгээний үзүүлэлтээр, СӨБ-д хамрагдсан байдлаар, 2018 он




**Зураг 3.23** Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, хөгжлийн чадварууд нь зохих түвшинд байгаа 3-4 настай хүүхдийн хувь, үнэлгээний үзүүлэлт, хүйсээр, 2018 он




Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

## 3.6 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД


Зураг 3.24 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, өмчийн хэлбэрээр



Зураг 3.25 Төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, байршлаар




Зураг 3.26 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа үндсэн болон туслах багшийн (багшийн туслах) тоо, 2022/2023




**Хүснэгт 3.4 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа нийт үндсэн багшийн боловсролын түвшин**

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Боловсролын түвшин:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2019/2020	91.1	-	549	6,182	621	716
2020/2021	94.3	2	626	7,108	588	503
2021/2022	97.2	-	794	7,240	545	245
2022/2023	93.3	-	1,118	7,263	433	636

**Зураг 3.27 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн насны бүлэг, ажилласан жил, 2022/2023**




Зураг 3.28 СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэл, дүүргээр, 2022/2023



Сургуулийн өмнөх боловсролын нэг үндсэн багшид **28.2 хүүхэд ногдож** байна. Нэг багшид ногдох хүүхдийн тоогоор хамгийн бага нь Дорноговь (**23.6**), хамгийн өндөр нь Увс (**37.6**), Өвөрхангай (**36.5**) аймаг байна.

Нийслэлийн хувьд сургуулийн өмнөх боловсролын нэг үндсэн багшид ногдох хүүхдийн тоогоор хамгийн өндөр нь Баянзүрх дүүрэг (**31.3**), хамгийн бага нь Багануур дүүрэг (**20.8**) байна.







**04**

## **БАГА, ДУНД БОЛОВСРОЛ**

---






### САЛБАРЫН ОНЦЛОГ: БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Боловсрол түүний дотор бага, дунд боловсролын салбарт тулгамдаж буй асуудлуудын нэг нь хот, хөдөөгийн болон төрийн, хувийн өмчийн сургуулийн сургалтын чанарын ялгаа юм.

Энэ ялгааг арилгах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна.

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийг төрийн өмчийн сургуулийн зарим хичээлүүдэд хэрэгжүүлж эхэлсэн.
- Англи хэл, математик, бага ангийн байгалийн ухаан, мэдээллийн технологийн хичээлүүдэд олон улсын хөтөлбөрийг сургалтыг туршилтаар эхлүүлсэн.
- Суралцагчдад хоцрогдлоо нөхөх, сургалтын тэгш боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр MEDLE, SURAAD, MN гэх мэт цахим хичээлийн санг үнэ төлбөргүй ажиллуулж байна. Энэ сангууд нь багшид ажлын ачаалал нэмэлгүйгээр суралцагчид хаанаас ч, өөрийн боломжтой цагаараа ашиглаж хоцрогдлын түвшингээ илрүүлж, нөхөх боломжийг олгож байна.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын санаачилгаар 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн сургуулиудад сэтгэл зүйч ажиллаж эхэлсэн. Одоо төрийн өмчийн гурван сургууль тутмын нэгд сэтгэл зүйч ажиллаж байна.



### ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Суралцагчийн тооноос шалтгаалан ээлжийн коэффициент өндөр байгаа ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар ачааллыг бууруулах, нэг багшид ногдох суралцагчийн тоог багасгах, суралцагч хичээлээс гадуур сургуулийн орчинд хөгжих, дугуйлан, бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ахлах ангийн суралцагчдад сонирхсон мэргэжлээр суралцах, ажил мэргэжлийн чиг баримжаатай болоход чиглүүлэх зорилгоор төрөлжсөн ахлах сургуулийг байгуулах бэлтгэлийг хангаж байна.




## Хүснэгт 4.1 Бага, дунд боловсролын үндсэн үзүүлэлт, 2022/2023

Үзүүлэлт	Бүгд	Хот	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
<b>Сургууль</b>	<b>859</b>	<b>297</b>	<b>562</b>	<b>688</b>	<b>171</b>
Ердийн	753	228	525	632	121
Төрөлжсөн	17	7	10	15	2
Гүнзгийрүүлсэн	70	44	26	31	39
Тусгай	6	6	-	6	-
Олон улсын хөтөлбөрийн сургалттай	13	12	1	4	9
<b>3 ээлжтэй сургуулийн тоо</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>-</b>
3 дугаар ээлжинд хичээллэдэг бүлэг	34	22	12	34	-
3 дугаар ээлжинд хичээллэж буй суралцагчид	1,451	1,047	404	1,451	-
Бага анги	1,399	1,047	352	1,399	-
Дунд анги				-	-
Ахлах анги	52	-	52	52	-
<b>Бүлгийн тоо</b>	<b>24,750</b>	<b>10,908</b>	<b>13,842</b>	<b>21,871</b>	<b>2,879</b>
Бага анги	11,937	5,324	6,613	10,531	1,406
Дунд анги	8,481	3,678	4,803	7,581	900
Ахлах анги	4,332	1,906	2,426	3,759	573
<b>Суралцагчид</b>	<b>751,513</b>	<b>365,641</b>	<b>385,872</b>	<b>687,275</b>	<b>64,238</b>
Үүнээс: Эмэгтэй	372,808	190,812	181,996	341,448	31,360
Эрэгтэй	378,705	174,829	203,876	345,827	32,878
<b>Суралцагч /өдөр/</b>	<b>746,405</b>	<b>364,793</b>	<b>381,612</b>	<b>683,708</b>	<b>62,697</b>
Үүнээс: Эмэгтэй	371,533	190,537	180,996	340,669	30,864
Эрэгтэй	374,872	174,256	200,616	343,039	31,833
<b>Суралцагч /орой, эчнээ/</b>	<b>127</b>	<b>-</b>	<b>127</b>	<b>127</b>	<b>-</b>
Үүнээс: Эмэгтэй	47	-	47	47	-
Эрэгтэй	80	-	80	80	-
<b>Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч</b>	<b>4,981</b>	<b>848</b>	<b>4,133</b>	<b>3,440</b>	<b>1,541</b>
Үүнээс: Эмэгтэй	1,228	275	953	732	496
Эрэгтэй	3,753	573	3,180	2,708	1,045
<b>Нэгдүгээр ангид шинээр элсэгч</b>	<b>78,728</b>	<b>39,018</b>	<b>39,710</b>	<b>71,273</b>	<b>7,455</b>
Үүнээс: Эмэгтэй	38,009	18,887	19,122	34,381	3,628
Эрэгтэй	40,719	20,131	20,588	36,892	3,827
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд</b>	<b>5,673</b>	<b>2,723</b>	<b>2,950</b>	<b>5,595</b>	<b>78</b>
Үүнээс: Эмэгтэй	2,307	1,035	1,272	2,289	18
Эрэгтэй	3,366	1,688	1,678	3,306	60
<b>Малчдын хүүхэд</b>	<b>132,635</b>	<b>9,304</b>	<b>123,331</b>	<b>131,798</b>	<b>837</b>
Үүнээс: Эмэгтэй	67,079	4,845	62,234	66,710	369
Эрэгтэй	65,556	4,459	61,097	65,088	468
<b>Дотуур байртай сургуулийн тоо</b>	<b>419</b>	<b>16</b>	<b>403</b>	<b>407</b>	<b>12</b>
<b>Дотуур байрны тоо</b>	<b>532</b>	<b>18</b>	<b>514</b>	<b>519</b>	<b>13</b>
<b>Дотуур байранд амьдарч буй хүүхэд</b>	<b>35,077</b>	<b>1,553</b>	<b>33,524</b>	<b>34,088</b>	<b>989</b>
Үүнээс: Эмэгтэй	17,920	587	17,333	17,500	420
Эрэгтэй	17,157	966	16,191	16,588	569
<b>Нийт багш, ажиллагчид</b>	<b>57,737</b>	<b>23,095</b>	<b>34,642</b>	<b>51,066</b>	<b>6,671</b>
Үүнээс: Эмэгтэй	45,061	18,439	26,622	39,927	5,134
Эрэгтэй	12,676	4,656	8,020	11,139	1,537
<b>Үндсэн багшийн тоо</b>	<b>36,118</b>	<b>15,925</b>	<b>20,193</b>	<b>31,880</b>	<b>4,238</b>
Үүнээс: Эмэгтэй	29,546	13,311	16,235	26,185	3,361
Эрэгтэй	6,572	2,614	3,958	5,695	877


## 4.1 | БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Зураг 4.1 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, өмчийн хэлбэрээр



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт **859** ерөнхий боловсролын сургуулийн **24,750** бүлэгт **746.4** мянган суралцагчид (өдрөөр) суралцаж, нийт **57.7** мянган багш, ажиллагчид ажиллаж байна.

Зураг 4.2 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ангиллаар




Зураг 4.3 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ангиллаар, 2022/2023



#### 4. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Төрийн өмчийн сургуулиудын **51 (7.4%)** нь бага сургууль, **108 (15.7%)** нь дунд сургууль, **488 (70.9%)** нь ахлах сургууль, **41 (6.0%)** нь цогцолбор сургууль байна.

#### Зураг 4.4 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршлаар



#### Хүснэгт 4.2 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хэв шинжээр


	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
<b>Нийт сургуулийн тоо</b>	<b>820</b>	<b>839</b>	<b>848</b>	<b>859</b>
Ердийн	721	735	741	753
Мэргэжлийн	15	15	16	17
Гүнзгийрүүлсэн	70	72	73	70
Тусгай	6	6	6	6
Олон улсын хөтөлбөртэй	8	11	12	13

#### Хүснэгт 4.3 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, ангилал, байршлаар, 2022/2023

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн			
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	Бага	Дунд	Ахлах
Баг	45	30	7	8	45	30	7	8
Сум	346	6	97	243	340	3	97	240
Аймаг	171	7	1	163	144	5	1	138
Нийслэл	297	31	4	262	159	13	3	143
<b>Нийт</b>	<b>859</b>	<b>74</b>	<b>109</b>	<b>676</b>	<b>688</b>	<b>51</b>	<b>108</b>	<b>529</b>

Төрийн өмчийн сургуулиудын **45 (6.5%)** нь багт, **340 (49.5%)** нь суманд, **144 (20.9%)** нь аймагт, **159 (23.1%)** нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

#### Зураг 4.5 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хичээллэж байгаа ээлжээр, 2022/2023




Нийт **859** сургуулийн **351 (40.9%)** нь 1 ээлжээр, **502 (58.4%)** нь 2 ээлжээр, **6 (0.7%)** нь 3 ээлжээр хичээллэж байна.



**Зураг 4.6 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, байршил, ангиллаар, 2022/2023**



**Зураг 4.7 Ерөнхий боловсролын сургуулийн тоо, аймгаар, 2022/2023**




**Хүснэгт 4.4 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооны тархалт, 2022/2023**




Суралцагчийн тооны тархалт	Багийн төв	Сумын төв	Аймгийн төв	Нийслэл	Сургуулийн тоо
0-499	43	195	51	125	414
500-699	1	72	13	29	115
700-999		40	25	23	88
1000-1499	1	32	32	21	86
1500-1999		6	18	24	48
2000-2999		1	26	43	70
3000-4499			5	24	29
4500+			1	8	9
<b>Нийт сургуулийн тоо</b>	<b>45</b>	<b>346</b>	<b>171</b>	<b>297</b>	<b>859</b>

**Зураг 4.8 100 ба түүнээс доош суралцагчтай сургуулийн тоо, байршлаар, 2022/2023**



## 4.2 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БҮЛЭГ


Зураг 4.9 Ерөнхий боловсролын сургуулийн өдрийн ангийн бүлгийн тоо



Ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлэг 2022-2023 оны хичээлийн жилд **24,750** байгаагийн **70.4** хувь нь нэг ээлжээр, **29.5** хувь нь хоёр ээлжээр, **0.1** хувь нь гурван ээлжээр хичээллэж байна.



Зураг 4.10 Ерөнхий боловсролын сургуулийн өдрийн ангийн бүлгийн тоо, ээлжээр



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилийн эхэнд **6** сургуулийн **34** бүлэгт **1,451** хүүхэд гурван ээлжээр хичээллэж байна.

### Нийслэлд:

- Нийслэлийн ерөнхий боловсролын 84-р сургууль
  - Тус сургуулийн хувьд хичээлийн жилийн эхэнд хичээлийн байрны тохижилтын ажилтай холбоотойгоор 3 ээлжээр хичээллэж эхэлсэн хэдий ч 2 дугаар улирлаас эхлэн 2 ээлжид шилжсэн.
- Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12-р сургууль
- Нийслэлийн ерөнхий боловсролын 124-р сургууль

### Орон нутагт:


- Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хантайшир-эрдэм цогцолбор сургууль
- Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын шинэ хөгжил цогцолбор сургууль
- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Авьяас ерөнхий боловсролын сургууль

**Зураг 4.11 Хот, орон нутагт гурван ээлжээр хичээллэж буй бүлгийн тоо, ангиар, 2022/2023**



Гурван ээлжээр хичээллэж буй бүлгийн **94.1** хувь нь бага ангийн, **5.9** хувь нь ахлах ангийн бүлэг байна.

**Зураг 4.12 Бүлэг дүүргэлт**




Төрийн өмчийн сургуулийн бүлэг дүүргэлт **31.3** байгаа нь хувийн өмчийн сургуулиас **9.5** пунктээр өндөр байна.

Хотод бүлэг дүүргэлт **33.4** байгаа нь орон нутгийн бүлэг дүүргэлтээс **5.8** пунктээр өндөр байна.

“Бүлэг дүүргэлт” гэж нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.




**Зураг 4.13 Бүлэг дүүргэлт, аймаг, нийслэл, дүүргээр, 2022/2023**



Чингэлтэй	34.5	Баянзүрх	33.8	Багануур	33.4	Баянгол	32.7		
Сонгинохайрхан	36.1	Хан-Уул	32.5	Налайх	31.8	Сүхбаатар	31.7	Багахангай	23.8



**Зураг 4.14 Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэтэрсэн сургуулийн тоо, 2022/2023**



**Зураг 4.15 Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэтэрсэн (нэг ангид 45 ба түүнээс дээш бүлэг дүүргэлттэй) зарим дүүргийн ерөнхий боловсролын сургууль**



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэт их (нэг ангид **45** ба түүнээс дээш бүлэг дүүргэлттэй) ерөнхий боловсролын сургууль **6** байгаа нь өмнөх хичээлийн жилээс **5** сургуулиар буурсан байна. Бүлэг дүүргэлт өндөр **6** сургуулийн **5** нь төрийн өмчийн сургууль, нэг нь хувийн өмчийн Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль байна.

## 4.3 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИД

**Хүснэгт 4.5 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, сургалтын хөтөлбөрөөр**


Хичээлийн жил	Нийт	Өдөр	Орой	Эчнээ	Дүйцсэн
2022/2023	751,513	746,405	33	94	4,981
2021/2022	717,451	712,353	33	102	4,963
2020/2021	686,321	680,837	51	93	5,340
2019/2020	646,839	640,449	88	123	6,179

### Хүснэгт 4.6 Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, боловсролын түвшин, өмчийн хэлбэрээр



	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
Нийт суралцагчид	640,449	680,837	712,353	746,405
Төрийн	593,438	632,499	658,634	683,708
Хувийн	47,011	48,338	53,719	62,697
Бага	342,634	356,904	371,480	382,002
Дунд	200,806	222,153	238,348	251,347
Ахлах	97,009	101,780	102,525	113,056

Зураг 4.16 Сум болон багийн ерөнхий боловсролын сургуулийн өдрийн ангийн суралцагчид




### Хүснэгт 4.7 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, байршил, өмчийн хэлбэрээр 2022/2023

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн			
	Нийт суралцагчид	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Нийт суралцагчид	Бага анги	дунд анги	Ахлах анги
Баг	6,477	3,956	1,886	635	6,477	3,956	1,886	635
Сум	180,836	92,033	64,750	24,053	180,233	91,667	64,631	23,935
Аймаг	194,299	95,505	65,186	33,608	186,113	92,274	62,147	31,692
Нийслэл	364,793	190,508	119,525	54,760	310,885	162,153	103,357	45,375
Нийт	746,405	382,002	251,347	113,056	683,708	350,050	232,021	101,637


Төрийн өмчийн сургуульд суралцаж буй нийт **683.7** мянган суралцагчийн **0.9** хувь нь багийн төвийн сургуульд, **26.4** хувь нь сумын сургуульд, **27.2** хувь нь аймгийн төвийн сургуульд, **45.5** хувь нь нийслэлд суралцаж байна.



**Зураг 4.17 Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, хичээллэж буй ээлжээр, дүнд эзлэх хувиар, 2022/2023**



**Зураг 4.18 Ерөнхий боловсролын сургуулийн нийт өдрөөр суралцагчдын дүнд зарим онцлох ангиллын эзлэх хувь, 2022/2023**



**Хүснэгт 4.8 Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын нийгмийн байдал, харьяалал, аймаг, дүүргээр, 2022/2023**

Аймаг	Малчдын хүүхэд	Гадаадын харьяат	Асрамжлах хүнгүй	Хөгжлийн бэрхшээлтэй бүгд	Бүтэн өнчин
<b>Улсын хэмжээнд</b>	<b>132,633</b>	<b>620</b>	<b>4</b>	<b>5,673</b>	<b>1,613</b>
<b>Аймаг</b>					
Архангай	10,610	0	0	151	30
Баян-Өлгий	8,561	54	0	250	84
Баянхонгор	8,470	2	0	101	32
Булган	4,759	0	0	75	14
Говь-Алтай	5,599	0	0	100	32
Дорноговь	3,139	2	0	111	29
Дорнод	4,092	2	0	181	46
Дундговь	4,032	0	0	70	19
Завхан	6,354	0	0	111	31
Өвөрхангай	9,968	1	0	186	55
Өмнөговь	3,442	0	0	123	18
Сүхбаатар	6,293	1	0	100	25
Сэлэнгэ	3,130	7	0	132	48
Төв	6,155	0	0	72	29
Увс	7,566	0	0	148	21
Ховд	7,745	3	0	160	33
Хөвсгөл	12,594	1	0	363	54
Хэнтий	6,054	0	0	123	35
Дархан-Уул	1,952	13	1	190	54
Орхон	1,989	4	0	165	41
Говь-Сүмбэр	827	0	0	38	11
<b>Дүүрэг</b>					
<b>Улаанбаатар</b>	<b>9,302</b>	<b>530</b>	<b>3</b>	<b>2,723</b>	<b>872</b>
Багануур	923	2	0	65	11
Баянгол	1,024	42	1	522	90
Баянзүрх	1,993	177	0	654	264
Налайх	510	2	0	41	37
Сонгинохайрхан	2,405	17	2	217	193
Сүхбаатар	622	139	0	630	83
Хан-Уул	1,180	138	0	449	120
Чингэлтэй	563	13	0	137	70
Багахангай	82	0	0	8	4


### БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн шинэчлэлийг "Хүртээмжээс-чанарт" зорилгын хүрээнд боловсролын чанарыг хэмжиж, гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог цахим шилжилттэй хослуулан хэрэгжүүлж байна.


Сургалтын чанарыг сайжруулах, тэгш хамран сургах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор багшийн цахим хэрэглээний зардал, хичээл практикийн зардлыг нийт хувьсах зардлын тодорхой хувиар тооцож олгох **үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, малчин өрхийн хүүхдэд** итгэлцүүрээр тооцож нэмэгдүүлж олгох зохицуулалтыг хувьсах зардалд тусгалаа.



**Зураг 4.19 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо**



**Зураг 4.20 Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бэрхшээлийн төрлөөр, 2022/2023**




Боловсролын шинэчлэн найруулж байгаа хуулийн төсөлд зарим онцлог шинэчлэл, өөрчлөлтүүдийг тусгасны нэг нь **"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд бусад үе тэнгийнхэнтэй хамтдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлэх"** чиглэлээр шинэ заалтуудыг тусгалаа.

Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй хүүхэд залуучуудын сургалтын хэл дохионы хэл байх, тохирох орчин, сурах бичгээр хангахтай холбоотой зохицуулалт одоогийн хуульд байхгүй байсныг харгалзан зарим шинэ заалтуудыг нэмсэн хуулийн төслийг боловсруулсан.



## 4.4 | НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭГЧИД

Зураг 4.21 Нэгдүгээр ангид элсэн суралцагчид, өмчийн хэлбэрээр




Зураг 4.22 Нэгдүгээр ангид элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элсэгчдийн **86.7** хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нь өмнөх хичээлийн жилээс **1.8** пунктээр буурсан байгаа бол нийт элсэгчдийн **13.3** хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна. Энэ нь өнгөрсөн жилүүдэд дэлхий нийтээр тархсан цар тахлаас шалтгаалан хичээл сургалтын үйл ажиллагааг онлайн/цахимаар явуулсантай холбоотой байх талтай юм.



**Зураг 4.23 Нэгдүгээр ангид элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, аймгаар, 2022/2023**



**Зураг 4.24 Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин**




"Цэвэр жин" гэдэг нь тухайн шатанд хамрагдвал зохих насны хүүхдийн хэдэн хувь нь хамрагдсаныг илэрхийлнэ.

Нэгдүгээр элсэгчдийн элсэлтийн цэвэр жин 2022-2023 оны хичээлийн жилд **92.4** хувь

болж өмнөх хичээлийн жилээс **2.4** пунктээр өссөн байна.

**Зураг 4.25 Нэгдүгээр ангид элсэгчдийн элсэлтийн цэвэр жин, аймаг, дүүргээр, 2022/2023**



**Дүүргээр:**

Чингэлтэй 78.7

Багахангай 82.5

Сонгино хайрхан 82.5

Налайх 97.9

Баянгол 98.3

Багануур 98.8

Баянзүрх 99.6


Хан-Уул 112.4

Сүхбаатар 119.2

**Тайлбар:** 2022-2023 оны хичээлийн жилийн хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо ҮСХ-ны 2021 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцсон.

# 4.5 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХАМРАН СУРГАЛТ

**Зураг 4.26** Хамран сургалтын цэвэр жин, ангиар




**Тайлбар:** 2022-2023 оны хичээлийн жилийн хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо ҮСХ-ны 2021 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог нас дэвшүүлэн тооцсон.

Бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2022-2023 оны хичээлийн жилд **96.5** хувь болж өмнөх оны хичээлийн жилээс **0.8** пунктээр өссөн байна.

Дунд ангийн (6-9-р ангийн) хамран сургалтын цэвэр жин **94.0** хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс **0.2** пунктээр өссөн байна.




**Зураг 4.27** Бага болон дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, аймаг, дүүргээр, 2022/2023



Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт боловсролын аль ч түвшинд хамран сургалт **100** хувиас илүү байгаа нь хүн амын нягтрал их, шилжилт хөдөлгөөний урсгал илүү төвлөрсөнтэй холбоотой байж болох юм.

### Зураг 4.28 Суурь болон бүрэн дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, аймаг, дүүргээр, 2022/2023



## 4.6 | ЭЭЛЖИЙН КОЭФФИЦИЕНТ

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тоот тушаалын хавсралтад анги дүүргэлтийг бага ангид **30-35** хүүхэдтэй, дунд, ахлах ангид **32-35** хүүхэдтэй байх нормативыг баталсан.



### Хүснэгт 4.9 Ээлжийн коэффициент ба бүлэг дүүргэлтийн харьцуулалт, 2022/2023

Ээлжийн коэффициент	Бүлэг дүүргэлт ба сургуулийн тоо				Нийт сургуулийн тоо
	30 хүртэлх хүүхэдтэй	30-40 хүртэлх	40-50 хүртэлх	50+	
0-0.5 хүртэлх	79				79
0.5-1 хүртэлх	234	7		1	242
1-1.5 хүртэлх	269	69	7		345
1.5-2 хүртэлх	36	52	5		93
2+	17	57	25	1	100
<b>Бүгд</b>	<b>635</b>	<b>185</b>	<b>37</b>	<b>2</b>	<b>859</b>



Бага, дунд боловсролын хүртээмжтэй холбоотой тулгамдсан асуудлын нэг нь 2030 он хүртэлх бага, дунд боловсрол эзэмших хүүхдийн тооны өсөлт юм. Хүн ам зүйн энэхүү өөрчлөлт нь бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициентыг улам нэмэгдүүлэхээр байгаа ба цаашлаад сургалтын чанарт ч нөлөөлөх талтай юм.\*


Иймд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр суралцагчийн тооноос шалтгаалан ээлжийн коэффициент өндөр байгаа ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар ачааллыг бууруулах, нэг багшид ногдох суралцагчийн тоог багасгах, суралцагч хичээлээс гадуур сургуулийн орчинд хөгжих, дугуйлан, бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

\* Эх үүсвэр: БШУЯ, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021-2030 он.



## 4.7 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙР

Зураг 4.29 Дотуур байртай сургуулийн тоо, дотуур байрны тоо, 2022/2023



Зураг 4.30 Дотуур байрны хүчин чадал, түүнд амьдарч буй хүүхдийн тоо, 2022/2023




Зураг 4.31 Дотуур байрны тоо, тэдгээрийн стандарт хангалт, 2022/2023




Хүснэгт 4.10 Дотуур байрны хангалтын хувь

	Суралцагчид			Малчдын хүүхэд			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	
2022/2023	35,616	35,077	98.5	27,240	26,870	98.6	376
2021/2022	34,546	32,576	94.3	26,458	25,169	95.1	430
2020/2021	38,071	35,000	91.9	29,023	26,866	92.6	486
2019/2020	38,698	35,757	92.4	29,029	27,136	93.5	557

Зураг 4.32 Дотуур байранд амьдарч буй суралцагчид, ангиар, 2022/2023



Зураг 4.33 Дотуур байранд ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын тоо



# 4.8 ХҮҮХДИЙН СУРАХ СУУРЬ ЧАДВАР

Энгийн эхийг уншиж ойлгох чадвар бол хүүхдийн сурвал зохих суурь чадваруудын нэг юм. Хүүхэд бага ангидаа тоог унших, бичих, нэмэх, хасах, үржүүлэх, хуваах аргад сайтар суралцах нь цаашдаа математикт амжилт гаргах чухал нөхцөл юм. 2018 оны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны үр дүнгээс харахад, 7-14 насны нийт хүүхдүүдийн **61.6** хувь нь унших суурь чадвар эзэмшсэн, **51.5** хувь нь тоо бодох суурь чадвар эзэмшсэн байна. Унших чадвар баруун бүсэд **37.4** хувь, тоо бодох суурь чадвар Улаанбаатар хотод **43.9** хувь гарсан нь хамгийн бага байна. Баруун бүсэд унших суурь чадвар бага үзүүлэлттэй байгаа нь Баян-Өлгий аймагт **10.0** хувь гарснаас шалтгаалжээ.




**Хүснэгт 4.11 Суурь чадвар эзэмшсэн суралцагчдын эзлэх хувь, 2018**

Үзүүлэлт	Унших суурь чадвар эзэмшсэн суралцагчдын эзлэх хувь			Тоо бодох суурь чадвар эзэмшсэн суралцагчдын эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Улсын дүн</b>	<b>61.6</b>	<b>61.2</b>	<b>62.1</b>	<b>51.5</b>	<b>49.9</b>	<b>53.2</b>
<b>Бүс</b>						
Баруун	37.4	37.0	37.8	47.7	44.8	50.2
Хангай	73.6	70.4	76.3	53.8	51.9	55.5
Төв	70.4	69.7	71.3	64.6	64.1	65.2
Зүүн	57.1	55.6	58.8	61.0	59.7	62.3
Улаанбаатар	60.8	61.3	60.1	43.9	41.5	46.3
<b>Зорилтот аймаг, дүүрэг</b>						
Баян-Өлгий аймаг	10.0	9.8	10.3	50.1	47.8	52.5
Баянхонгор аймаг	54.9	55.0	54.7	43.9	41.5	46.3
Говь-Алтай аймаг	55.9	51.9	60.1	60.8	59.1	62.3
Завхан аймаг	49.4	44.5	54.4	54.2	53.7	54.7
Өмнөговь аймаг	70.7	70.6	70.8	55.0	56.8	53.0
Хөвсгөл аймаг	70.0	66.9	73.6	53.6	51.5	55.8
Баянзүрх дүүрэг	64.3	67.7	61.3	-	-	-
Налайх дүүрэг	70.2	66.7	73.4	25.1	-19.1	-33.6
<b>Байршил</b>						
Нийслэл	60.8	61.3	60.1	43.9	41.5	46.3
Аймгийн төв	65.8	64.2	67.4	60.8	59.1	62.3
Сумын төв	63.7	61.3	66.4	55.0	56.8	53.0
Хөдөөгийн баг	57.7	57.9	57.5	53.6	51.5	55.8

**Эх үүсвэр:** УСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он

## СУРАХ СУУРЬ ЧАДВАР, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 4.1.1

**Зураг 4.34 Унших болон тоо бодох суурь чадвартай 2-3 ангийн хүүхдийн хувь, хүйсээр, 2018**




**Эх үүсвэр:** УСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он



Унших суурь чадварын үзүүлэлтүүдээс харахад хүүхдүүд эхийг уншиж байгаа ч ойлгож, асуултад хариулах чадвар нь харьцангуй доогуур байна. Тоо бодох чадварын хувьд нэмэх үйлдэл болон зүй тогтлыг зөв тодорхойлох дасгалуудыг харьцангуй тааруу хийсэн байна.

Унших болон тоо бодох суурь чадварын хувьд 4 дүгээр анги хүртэл өсөж байгаа хэдий ч түүнээс төдийлөн ахихгүй байгаа нь анхаарал татаж байна.

**Зураг 4.35 Унших болон тоо бодох суурь чадвартай хүүхдийн хувь, ангиар, 2018**



Эх үүсвэр: УСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он

**ГЭРТЭЭ СУРАЛЦАХ, ХИЧЭЭЛ ДАВТАХ ОРЧИН НӨХЦӨЛ**

**Зураг 4.36 Гэртээ 3, түүнээс олон унших номтой, ном уншдаг эсвэл уншиж өгдөг 7-14 насны хүүхдийн хувь, 2018**




Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот	Хөдөө
78.8	74.3	83.4	79.5	77.4
49.6	46.0	53.5	56.6	36.8

● Гэртээ 3, түүнээс олон унших номтой хүүхдийн хувь  
 ● Гэртээ ном уншдаг эсвэл ном уншиж өгдөг хүүхдийн хувь

**СУРАЛЦАГЧДЫН МЭДЛЭГ, ЧАДВАРЫН АХИЦ, АМЖИЛТЫН ТҮВШИН**

**Зураг 4.37 Есдүгээр ангид суралцагчдын Математик, Монгол хэлний хичээлийн улсын шалгалтын үнэлгээний хувь, 2021/2022**



# 4.9 | БОЛОВСРОЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ (ПАРИТЕТ)-ЫН ИНДЕКС



Боловсролын түвшнээр тооцсон "Тэнцвэрт байдал (паритет)-ын индекс"-ийг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны 2018 оны үр дүнд тулгуурлан хүйс, өрхийн аж байдлын түвшин, байршлаар тооцоолон харьцуулж харуулав.

**Зураг 4.38 Боловсролын тэнцвэрт байдлын индекс**


Охидын хамран сургалтын цэвэр жин (засварласан) болон хөвгүүдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



Доогуур аж байдалтай (хамгийн доод 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жинг (засварласан) болон дээгүүр аж байдалтай (хамгийн дээд 20%) өрхөд амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



Хөдөө амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жин болон (засварласан) хотод амьдарч байгаа хүүхдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа



● Бага анги    ● Дунд анги    ● Ахлах анги


**Эх үүсвэр:** УСХ-ны "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа"-ны нэгдсэн тайлан, 2018 он

Бага болон дунд ангид суралцагчдын хувьд хүйс, өрхийн аж байдал, байршлаар тооцсон боловсролын тэгш байдлын индекс харьцангуй жигд 0.97-1.03 байна. Харин ахлах ангийн хувьд хамран сургалтын цэвэр жингээр тооцсон тэгш байдлын индексийг харахад хөдөөгийн, доогуур аж байдалтай өрхийн хөвгүүд суурь боловсрол эзэмшээд цааш үргэлжлүүлэн ахлах ангид суралцах нь бага байгааг харж болохоор байна.




# 4.10 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД

**Зураг 4.39 Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид**




**Зураг 4.40 Ерөнхий боловсролын сургуулийг өдрөөр төгсөгчид, боловсролын түвшнээр, 2021/2022**



2021-2022 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт **84.7** мянган хүүхэд (9-р ангийг **52.8** мянга, 12-р ангийг **31.9** мянга) өдрөөр суралцан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс **5.0 (6.3)** мянгаар өссөн байна.

**Зураг 4.41 Ерөнхий боловсролын сургуулийн 9 болон 12 дугаар ангийг өдрөөр суралцан төгсөгчид, аймгаар, 2021/2022**




**Тайлбар:** Бусад гэдэгт БНСУ дахь Монгол сургууль, Кембрижийн хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургуулиудыг хамруулав.



Улсын хэмжээнд 2021-2022 ны хичээлийн жилд бага анги төгсөгчдийн бохир жин **96.5** байна.

**Зураг 4.42 Бага анги төгсөгчдийн (өдөр) бохир жин, аймгаар, 2021/2022 оны хичээлийн жилд**



## 4.11 ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

### ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫГ ЖИЛД ХОЁР УДАА ЗОХИОН БАЙГУУЛДАГ ТОГТОЛЦООНД ШИЛЖЛЭЭ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/47 тоот тушаалд “Оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд хоёр удаа зохион байгуулах нэмэлт өөрчлөлтийг тусгасан.

Энэ нь шалгуулагч өмнөх шалгалтын дүн оноогоо ахиулах замаар их, дээд сургуульд суралцах боломжийг дэмжиж байгаагаараа онцлогтой.

2023 онд аймгуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд туссан онцлог ажлын нэг нь “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, хамгаалал болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авах улсын шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичиг, элсэлтийн ерөнхий шалгалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” тухай заалтыг тусгасан байна.

**Зураг 4.43 Элсэлтийн ерөнхий шалгалтад орсон хүний тоо, 2022 он**



**Хүснэгт 4.12 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн байршлаар, 2022 он**

Шалгалтын нэр	Улаанбаатар (970 сургууль)			Аймгийн төв (627 сургууль)		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	9,172	28.2	510.02	5,831	29.5	520.36
Монгол хэл	3,834	52	503.52	2,376	56.1	531.93
Нийгмийн ухаан	8,136	51.2	506.39	4,672	54.8	526.9
Англи хэл	10,180	38.3	518.03	4,702	34.6	504.27
Орос хэл	402	81.4	670.15	197	81.1	668.04
Газарзүй	236	52.5	526.26	147	59.6	555.19
Физик	3,370	31.6	507.05	2,184	35.1	528.41
Биологи	1,975	44.7	513.85	1,850	48.3	533.03
Хими	2,004	28.2	514.45	1,880	29.6	525.06
Монгол Улсын түүх	476	46.1	521.1	112	59.8	587.13
Монгол хэл бичиг	-	-	-	-	-	-

Шалгалтын нэр	Сумын төв (690 сургууль)			Багийн төв (124 сургууль)		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	3,782	25.2	493.81	191	29.3	517.3
Монгол хэл	2,283	53.8	515.58	114	52.8	508.39
Нийгмийн ухаан	3,512	50.7	502.04	179	54.3	524.02
Англи хэл	2,629	28.5	475.27	185	32.7	499.09
Орос хэл	161	62.8	539.52	6	56.5	495.5
Газарзүй	147	52.3	521.95	8	45.5	494.75
Физик	1,567	29	493.74	87	35.3	526.83
Биологи	1,535	41.7	496.93	71	41.5	493.41
Хими	1,528	24.9	490.71	63	28.1	511.52
Монгол Улсын түүх	134	53.5	553.85	10	46.8	515.8
Монгол хэл бичиг	-	-	-	-	-	-

**Хүснэгт 4.13 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн өмчийн хэлбэрээр, 2022 он**

Шалгалтын нэр	Төрийн өмчит сургууль (1779)			Хувийн өмчит сургууль (632)		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	17,252	27.3	505.86	1,724	35.4	551.84
Монгол хэл	8,238	53.5	513.71	369	56.6	535.02
Нийгмийн ухаан	15,400	51.8	509.02	1,099	57.9	545.62
Англи хэл	15,893	33.6	498.57	1,803	54.7	589.38
Орос хэл	579	72.6	608.55	187	91.5	740.59
Газарзүй	483	53.7	529.6	55	60.1	558.11
Физик	6,592	31.3	506.85	616	41.2	553.84
Биологи	5,086	44.4	512.05	345	53.9	563.68
Хими	5,118	27.1	507.58	357	36.9	566.74
Монгол Улсын түүх	638	48.7	532.87	94	54.8	565.99
Монгол хэл бичиг	-	-	-	-	-	-

**Хүснэгт 4.14 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, хүйсээр, 2022 он**

Шалгалтын нэр	Эрэгтэй			Эмэгтэй		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Математик	9,618	27.6	505.67	9,358	28.4	514.54
Монгол хэл	2,673	48.3	477.32	5,934	56	531.43
Нийгмийн ухаан	6,515	47.5	483.04	9,984	55.2	530.01
Англи хэл	7,689	35.5	504.16	10,007	36	510.64
Орос хэл	235	79.1	654.31	531	76.4	634.8
Газарзүй	291	53.9	530.15	247	54.9	535.3
Физик	5,251	31.4	506.13	1,957	34	523.56
Биологи	1,157	42.4	501.23	4,274	45.7	519.15
Хими	1,209	26.9	505.25	4,266	27.9	513.19
Монгол Улсын түүх	349	49.4	536.06	383	49.6	538.09
Монгол хэл бичиг	-	-	-	-	-	-

**Эх үүсвэр:** Боловсролын үнэлгээний төвийн статистикийн тайлангийн систем, 2022 он

**Тайлбар:** 2022 оноос өмнө төгсөгчдийн мэдээлэл хасагдсан болно.

Ш.Тоо - Шалгуулагчийн тоо, А.О.Д - Анхны онооны дундаж, Х.О.Д - Хэмжээст онооны дундаж



**Хүснэгт 4.15 Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан шалуулагчид, шалгалтын төрлөөр, 2022 он**

ШАЛГАЛТЫН НЭР	Нийт шалгуулагчийн тоо	800 оноо авсан шалгуулагчийн тоо	Дүнд эзлэх хувь
Математик	18,976	31	0.16
Монгол хэл	8,607	15	0.17
Нийгмийн ухаан	16,499	33	0.2
Англи хэл	17,696	24	0.14
Орос хэл	766	65	8.49
Газарзүй	538	1	0.19
Физик	7,208	14	0.19
Биологи	5,431	10	0.18
Хими	5,475	10	0.18
Монгол Улсын түүх	732	2	0.27
Монгол хэлбичиг	0	0	0



**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН БОДЛОГЫН ҮР ДҮН**


Сургалтын чанарыг сайжруулах, тэгш хамран сургах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэлийг хийснээр сургалтын чанарт бодитой ахиц гарч, ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны суралцагчийн сурлагын амжилтыг 2021 оны 9 дүгээр сарын амжилттай харьцуулахад **30** хүртэлх хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна.

## 4.12 АЖИЛЛАГЧИД БОЛОН ҮНДСЭН БАГШ


**Зураг 4.44 Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид, өмчийн хэлбэрээр**



Зураг 4.45 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, өмчийн хэлбэрээр



Зураг 4.46 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, ангиллаар




**ХИЧЭЭЛ, СУРЛАГЫН ЧАНАРТ АХИЦ ГАРАХЫН ЗЭРЭГЦЭЭ БАГШ НАРЫН “ХАЛААСНААС” ГАРДАГ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ЗАРДЛЫГ АРИЛГАЖ, БОДИТ ОРЛОГЫГ НЬ ХАМГААЛАХ БАЙДЛААР ХУВЬСАХ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЧМЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО.**

Ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлын нормативын бүрэлдэхүүнд:

- Багшийн хөгжил, танхимаас гадуурх сургалт, судлагдахуун тус бүрээр тооцсон хичээл практикийн зардал,
- Ажил олгогчоос хариуцах эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал,
- Цахим хэрэглээний зардал зэргийг нэмэлтээр тооцож, санхүүжүүлсэн.

Зураг 4.47 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, сургуулийн хэв шинжээр, 2022/2023



**Хүснэгт 4.16 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, байршил, өмчийн хэлбэрээр, 2022/2023**

Байршил	Улсын хэмжээнд				Төрийн өмчийн сургууль			
	Нийт багш	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Нийт багш	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Аймгийн төв	9,210	2,811	4,036	2,363	8,614	2,656	3,740	2,218
Багийн төв	530	279	185	66	530	279	185	66
Нийслэл	16,040	5,461	7,324	3,255	12,442	4,142	5,837	2,463
Сумын төв	10,338	3,556	4,563	2,219	10,294	3,539	4,551	2,204
<b>Нийт</b>	<b>36,118</b>	<b>12,107</b>	<b>16,108</b>	<b>7,903</b>	<b>31,880</b>	<b>10,616</b>	<b>14,313</b>	<b>6,951</b>


**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ-БАГШИД ЭЭЛТЭЙ БОДЛОГО**

Багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах, ажлын ачааллыг гүйцэтгэлд тооцох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахын тулд хувьсах зардлын бүрэлдэхүүнд ангийн хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдлийг шинээр тусгаж, багшийн хөгжлийн зардлыг багш бүрээр тооцон олгодог болсон.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн эрт илрүүлгийн шинжилгээний багцад ороогүй, багшийн ажлын онцлогоос хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг баталж хэрэгжүүлснээр өнөөдрийн байдлаар 40,000 орчим багш хамрагдаад байна.




**Зураг 4.48 Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь**





Мэргэжлийн багшийн хангалт 2022-2023 оны хичээлийн жилд **97.7** хувь болж өмнөх оны хичээлийн жилээс **1.8** пунктээр буурсан байна.

**Зураг 4.49 Мэргэжлийн багшийн хангалтын хувь, аймгаар, 2022/2023**



**БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИЛ, АЖЛЫН АЧААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны шинэчлэлийг хэрэгжүүлж байна.
- Багшийн хөгжилд багш бэлтгэх их, дээд сургууль, ахмад багш нар, багш нарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага гэх мэт олон талын оролцоог хангаж байна.
- Багш нар мэргэжлийн хөгжлийн зардлаа хэрэгцээндээ нийцүүлэн өөрөө зарцуулдаг, сонгож суралцдаг боллоо. 2022-2023 оны хичээлийн жилд хувьсах зардлын **0.6** хувийг мэргэжлийн хөгжилд зориулан зарцуулах боломжтой боллоо.
- Багш үндсэн сургалтаас гадна өөрийн хэрэгцээнд нийцүүлэн модуль сургалтад хамрагдах, ажлын байрандаа мэдлэг, туршлагатай багшаас суралцах, өөрийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжоор хангагдаж байна.
- Багшийн ажлын ачааллыг бууруулах, нормыг шинэчлэх хүрээнд багшийн ажил мэргэжлийн стандарт боловсруулж, ажил үүргийн шинжилгээ, ачааллын судалгааг хийлээ.

**Зураг 4.50 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувь, 2022/2023****Зураг 4.51 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн насны бүлэг, 2022/2023****Зураг 4.52 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн ажилласан жил, 2022/2023**


#### 4. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл - Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллыг олгож эхлээд байна.


Багш нарын цалингийн зэрэглэл, шатлалд өөрчлөлт орууллаа./ Засгийн газрын 2022 оны 107 тоот тогтоол батлагдсан/

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс хамаарч 10-25 хувийн урамшуулалт цалинг сар бүр авах боломжийг бүрдүүлээ.
- Үндсэн цалинг багш нарын ажилласан жилээс үл хамаарахаар тогтоосноор суурь цалин дунджаар 20-34 хувиар нэмэгдэх, багш мэргэжлийн нэр хүндийг өсгөх, нийгмийн баталгааг нь хангах нөхцөл бүрдэж байна.

**Зураг 4.53 Нэг багшид ногдох хүүхдийн тоо, 2022/2023**




**Зураг 4.54 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо**



2023 оны 4-6 сард сургууль, цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.

**Зураг 4.55 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймгаар, 2022/2023**




**Эх үүсвэр:** Ерөнхий боловсролын сургуулийн 2018-2021 оны захиргааны статистик мэдээ, 2022-2023 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн үдийн хоолны үйлчилгээний зохион байгуулалтын мэдээлэл, 2022 оны 10 сарын байдлаар, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

## 4.13 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

"Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" болгох зорилгоор Улсын Их Хурлаас 2019 онд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг баталж, 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох үдийн хоолны зардлыг 2021 онд **1,500** төгрөг болгон нэмэгдүүлэв.

**Зураг 4.56 Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж буй 1-5 дугаар ангийн нийт суралцагчийн тоо**



2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн **382,596** суралцагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилээс **11,116** суралцагчаар өссөн байна.

**Зураг 4.57 Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны хүртээмж, сургуулийн тоо**




2021-2022 хичээлийн жилд судалгаанд хамрагдсан нийт **748** сургуулийн **545 (72.9%)** нь 5 өдөр халуун хоолоор, **158 (21.1%)** нь долоо хоногийн 1-2 өдөр бэлэн бүтээгдэхүүн бусад өдөр халуун хоол, **45 (6.0%)** нь 5 өдөр бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байсан бол 2022-2023 оны хичээлийн жилд төрийн болон хувийн өмчийн нийт **848** ерөнхий боловсролын сургуулийн **836 (98.5%)** нь 5 өдөр халуун хоолоор, **12 (1.4%)** нь бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилж байна.



**Эх үүсвэр:** ЕБС-ийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийн судалгаа, 2021-2022 оны хичээлийн жил, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

**Зураг 4.58 Ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдсан төрийн өмчийн сургуулийн тоо**



2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын **682** сургууль үйл ажиллагаа явуулж байсны **103 (15.1%)** нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байсан бол 2022-2023 оны хичээлийн жилд **688** сургуулийн **228 (33.4%)** нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

**Зураг 4.59 Үдийн хоол үйлдвэрлэлийн байрны нөхцөл байдал, сургуулийн тоогоор**



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн нийт **682** ерөнхий боловсролын сургуульд **821** хоолны газар байна. Нийт хоолны газрын **597 (72.6%)** нь зориулалтын гал тогоотой, **224 (27.2%)** нь зориулалтын бус /анги танхимыг өргөтгөн засварласан, технологи урсгал буруу, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй, зай талбай бага/, хүчин чадал хүрэлцээгүй гал тогоотой байгаа бол **9 (1.1%)** сургууль нь зориулалтын хоолны газаргүй байна.

**Зураг 4.60 Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэр**



2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын **672** сургуулийн **158 (23.5%)** нь сургуулийн гал тогоог аж ахуйн нэгжид түрээслэх хэлбэрээр үдийн хоолны үйлчилгээг хүргэж байсан бол 2021-2022 оны хичээлийн жилд нийт **682** сургуулийн **165 (24.2%)** нь түрээсийн хэлбэрээр ажиллуулж байна.

**Эх үүсвэр:** ЕБС-ийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийн судалгаа, 2021-2022 оны хичээлийн жил, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

## Зураг 4.61 Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалт



2021-2022 оны хичээлийн жилд **183** сургуульд иж бүрэн болон нэмэлт тоног төхөөрөмж олгосноор нийт төрийн өмчийн сургуулийн **53.3** хувь нь хоол үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаад байна.


## Зураг 4.62 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж буй ажилтны тоо



2022 оны 10 сарын байдлаар **75** хоол зүйч, **1,276** тогооч, **464** туслах тогооч, туслах ажилтан ажиллаж байгаа нь өмнөх хичээлийн жилээс хоол зүйч **15** дахин, тогооч **14.9** хувиар, туслах тогооч, туслах ажилтан **53.1** хувиар тус тус нэмэгдсэн байна.

## 4.14 ДҮЙЦСЭН ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧИД

## Зураг 4.63 Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдийн тоо





**Зураг 4.64 Дүйцсэн хөтөлбөрөөр төгсөгчид, 2021/2022**



**Хүснэгт 4.17 Дүйцсэн хөтөлбөрөөр төгсөгчид, аймгаар, боловсролын түвшнээр, 2021/2022**

Аймаг	Дүйцсэн хөтөлбөрөөр төгсөгчид	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Архангай	124	2	58	64
Баян-Өлгий	107	8	38	61
Баянхонгор	126	1	61	64
Булган	64	1	51	12
Говь-Алтай	145	19	46	80
Дорноговь	7		7	
Дорнод	19	2	5	12
Дундговь	16	3	9	4
Завхан	84	4	41	39
Өвөрхангай	131	11	55	65
Өмнөговь	8	1	7	
Сүхбаатар	58	8	50	
Сэлэнгэ	47	4	18	25
Төв	115	3	50	62
Увс	108	14	53	41
Ховд	178	26	65	87
Хөвсгөл	106	9	49	48
Хэнтий	19	2	8	9
Дархан-Уул	29	8	13	8
Улаанбаатар	426	93	135	198
Орхон	44	9	11	24
Говьсүмбэр	39		14	25



# 4.15 | БОЛОВСРОЛЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ\*

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2022 оны 9 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын “Хувьсаж буй боловсрол” чуулган дээр **“Монгол Улс боловсролын цахим шилжилт, суралцагчдад тэгш боломж олгосон сайн туршлагаараа дэлхийн “CHAMPION” орнуудын нэг болсон”-ыг албан ёсоор зарласан.**



## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ ОНЦЛОГ АЖЛУУД:

- Багшийн дата хэрэглээний зардал
- Сургуулийн болон суралцахуйн удирдлагын систем (LMS, SMS)
- Сургалтын нэгдсэн платформын хөгжүүлэлт (eSchool)
- Google, GIGA түншлэл
- PEARSON мэдээллийн технологийн цахим сургалтын систем 6-12 анги
- PEARSON англи хэлний цахим сургалтын систем 5-9 анги
- Цахим сурах бичгийн нэгдсэн системийн хөгжүүлэлт
- Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага мэдээллийн систем
- Мэргэжлийн боловсрол, сургалт, дээд боловсролын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг мөшгих систем


**Зураг 4.65 Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн тоо, 2021/2022**



**Зураг 4.66 Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн барилгын тоо, 2021/2022**




\*Тайлбар: Энэ бүлгийн мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2022 оны жилийн эцсийн тайлангаас бэлтгэв.



**ХҮН БҮРД БОЛОВСРОЛЫГ ЦАХИМААР**

Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий **MEDLE.MN** сургалтын нэгдсэн платформыг 2021 оноос хойш боловсруулан хөгжүүлж байна.

2022 оны 9 дүгээр сарын байдлаар MEDLE.MN сургалтын нэгдсэн платформд **5,017** багш холбогдож, **3,642** контент боловсруулах санал ирүүлснээс **1,780** хичээл боловсруулалтын үе шатанд байгаа бол **1,862** хичээлийг шалгаруулан байршуулсан ба нэг сая гаруй хэрэглэгч хандсан байна.



2023 оноос ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөрөөр байгаль шинжлэл, англи хэл, математик, мэдээллийн технологи гэх мэт хичээлүүдийн цахим сургалтыг хэрэгжүүлнэ.

Цахим сургалт нь багшийн ажлын ачааллыг бууруулах, суралцагчид өөрийн түвшинд тохируулан суралцах, суралцахуйн ахиц дэвшлийг хянах, дэмжин туслах, хоцрогдлыг нөхөх, илүү сонирхолтойгоор суралцах боломжийг бүрдүүлнэ.

### МОНГОЛЫН АНХНЫ ЦАХИМ СУРГУУЛЬ-MEDLE.MN



Дэлхий нийтээр технологийн дэвшлийг ашиглаж буйтай холбоотойгоор сургалтын байгууллагын хэв шинж өөрчлөгдөж байна. Монгол Улсад анх удаа ерөнхий боловсролын цахим сургуулийг хөгжүүлэх эхлэлийг тавилаа. Энэ бол **"Medle"** цахим сургууль юм.

Хот, хөдөөгийн 10 дугаар ангид суралцаж буй **15,000** орчим суралцагчдад ирээдүйд эзэмших ажил, мэргэжлийн дагуу хичээлээ сонгон цахимаар судлах боломжийг бүрдүүллээ.

## Зураг 4.67 “Medle” цахим сургуульд:



“MEDLE” цахим сургууль нээгдсэнээр Монгол Улс боловсролын салбарын цахим шилжилтээрээ дахин нэг алхам урагшилж байна.

2023-2024 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын 10, 11 дүгээр ангийн сонгон судлах хичээлийг үндэсний хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байна.

## Зураг 4.68 “Medle” цахим сургуулийн хичээл сонголт



**ХҮСНЭГТ 4.18 “MEDLE” цахим сургуулийн суралцагчийн тоо, байршлаар**

Нийслэл	Аймгийн төв	Сум	Баг
5,915	3,182	5,187	268

**Зураг 4.69 MEDLE.MN – Сургалтын платформ**



**MEDLE.MN ҮНДЭСНИЙ ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ**

**Medle.mn** бол Монголын шилдэг багш, мэргэжилтнүүд үндэсний сургалтын хөтөлбөрт нийцүүлэн, эх хэл дээрээ боловсруулсан хичээлийн **13,000** гаруй цахим контентын сан бүхий нээлттэй платформ юм.

**Medle.mn цахим сургалтын онцлог болон давуу тал:**

- Интернет холболт бүхий аль ч газраас хандах боломжтой,
- Веб болон мобайл аппликэйшн хэлбэрээр хүлээн авах боломжтой
- Хичээлийн контентуудыг суралцагч биед даан судлах, давтан үзэх болон багш, эцэг эхийн дэмжлэгтэйгээр суралцах, мэдлэгээ бататгах боломжийг олгодог,
- Хичээл, контентуудыг үзэхэд дата хязгааргүй /үнэ төлбөргүй/ зэрэг онцлогтой.

**2022-2023 оны хичээлийн жилд ЕБС-ийн хичээлийн контентын санд бүртгэгдсэн хичээл:**


- Ээлжит хичээлийн цахим контент - **4780 +**
- Интерактив дасгал ажлын хуудас – **3358 +**
- Сурах бичгийн цахим хувилбар – **147 +**
- Теле хичээл – **4140 +**
- Интерактив хичээл – **229 +**
- Виртуал лабораторийн туршилт – **805+**
- Насан туршийн боловсрол, цахим ур чадварын хичээл – **413 +**



**Зураг 4.70 ЕБС-ийн хичээлийн контентын санд нийт байршуулсан судлагдахууны тоо, нэр төрлөөр, 2022 оны 12 сарын байдлаар**



**Зураг 4.71 ЕБС-ийн хичээлийн контентийн сан бүрдүүлэлт болон ашиглалт**







05

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН  
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ**

---



### МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ОНЦЛОГ

**“Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд улс, орон нутгийн эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалттай уялдуулан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий зөв хандлага, төлөвшилтэй мэргэжилтэй ажилтныг бэлтгэнэ.

Мэргэжлийн ур чадвар бүхий зөв хандлага, төлөвшилтэй мэргэжилтэй ажилтныг бэлтгэхийн тулд анхаарах үндсэн асуудлууд:

- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, засаглалын тогтолцоог оновчтой болгох;
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн бодлоготой уялдуулан мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлэн хөгжүүлэх замаар хосмог сургалтын байгууллагын хэв шинжийг бий болгох;
- Мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтын хугацааг 3 жил болгох /ингэснээр суралцагч төгсөхдөө 18 насанд хүрч хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх бүрэн боломжтой болно./;
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зардлыг сургалтын чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлэх тогтолцоонд шилжих ажлыг эхлүүлэх, эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилтийг нэвтрүүлэх;
- Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрийг ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран бүх насны хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх, хэрэгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах;
- Ажил олгогчтой хамтран хосмог сургалтын хэлбэрийг үе шаттай нэвтрүүлэх;
- Салбарын багш, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, цалин, нэмэгдэл, урамшууллын тогтолцоог холбогдох хууль журмын хүрээнд сайжруулах;
- Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт дүйцүүлэх, суралцагч багц цаг тооцуулан дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах боломжийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг онцолж байна.






## Хүснэгт 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын үндсэн үзүүлэлт, 2022/2023

Үзүүлэлт	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
<b>СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА</b>			
Тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллага	79	49	30
Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага	77	48	29
Үүнээс: Нийслэлд	37	13	24
Орон нутагт	40	35	5
Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв	41	20	21
Политехник коллеж	33	25	8
Бусад <sup>1</sup>	3	3	-
<b>СУРАЛЦАГЧ</b>			
<b>Нийт суралцагчид</b>	<b>38,034</b>	<b>27,400</b>	<b>10,634</b>
Үүнээс: Эрэгтэй	23,760	17,931	5,829
Эмэгтэй	14,274	9,469	4,805
Үүнээс: Нийслэлд	19,115	9,618	9,497
Орон нутагт	18,919	17,782	1,137
Техникийн боловсрол	4,753	3,667	1,086
Мэргэжлийн боловсрол	33,027	23,504	9,523
Мэргэжлийн сургалт	254	229	25
Малчин өрхөөс суралцагч	9,109	7,716	1,393
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	643	427	216
Үүнээс: Эрэгтэй	352	223	129
Эмэгтэй	291	204	87
Төгсөх ангид суралцагч	20,721	14,574	6,147
Үүнээс: Эрэгтэй	12,108	8,943	3,165
Эмэгтэй	8,613	5,631	2,982
<b>ШИНЭЭР ЭЛСЭГЧ</b>			
<b>Шинээр элсэгчид</b>	<b>19,256</b>	<b>13,391</b>	<b>5,865</b>
Үүнээс: Эрэгтэй	11,477	8,480	2,997
Эмэгтэй	7,779	4,911	2,868
Үүнээс: Нийслэлд	9,006	4,208	4,798
Орон нутагт	10,250	9,183	1,067
Техникийн боловсрол	1,413	1,080	333
Мэргэжлийн боловсрол	17,589	12,082	5,507
Мэргэжлийн сургалт	254	229	25
Малчин өрхөөс шинээр элсэгч	3,919	3,106	813
<b>БАГШ, АЖИЛТАН</b>			
<b>Нийт багш, ажилтан</b>	<b>4,094</b>	<b>3,334</b>	<b>760</b>
Үүнээс: Эрэгтэй	1,414	1,163	251
Эмэгтэй	2,680	2,171	509
Үүнээс: Нийслэлд	1,451	795	656
Орон нутагт	2,643	2,539	104
Үндсэн багш	2,252	1,806	446
Үүнээс: Эрэгтэй	792	650	142
Эмэгтэй	1,460	1,156	304
Үүнээс: Нийслэлд	898	513	385
Орон нутагт	1,354	1,293	61

<sup>1</sup> Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургууль, Монгол Улсын консерватор, Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж


# 5.1 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА



Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын түвшинд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй **79** сургалтын байгууллага байгаагаас сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа **77<sup>2</sup>** байгууллага байна.

Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын **48** буюу **62.3** хувь нь төрийн өмчийн, **29** буюу **37.7** хувь нь хувийн өмчийнх байна.

**Зураг 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, дүнд эзлэх хувь**



Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас төрийн өмчийн /БШУЯ-ны харьяа/ **37**, төрийн өмчийн их, дээд сургуулийн харьяа **8**, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа **1**, "УБТЗ ХНН"-ийн харьяа **1**, ШШГЕГ-ын харьяа **1**, хувийн өмчийн **29** сургалтын байгууллага 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.


**Хүснэгт 5.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, хэв шинж, байршлаар**

Үзүүлэлт	2021/2022 оны хичээлийн жил			2022/2023 оны хичээлийн жил			
	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага	75	43	32	77	48	29	
Хэв шинж	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв	44	19	25	41	20	21
	Политехник коллеж	30	23	7	33	25	8
	Бусад	1	1		3	3	-
Байршил	Үүнээс: Нийслэлд	36	10	26	37	13	24
	Орон нутагт	39	33	6	40	35	5

<sup>2</sup> 2022-2023 оны хичээлийн жилд Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, "Майн Тек" мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас **41** буюу **53.2** хувь нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, **33** буюу **42.9** хувь нь политехник коллеж, **3** буюу **3.9** хувь нь бусад хэв шинж бүхий сургалтын байгууллага байна.

**Зураг 5.2 Нийслэл, орон нутаг дахь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо**




Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын **40** буюу **51.9** хувь нь орон нутагт, **37** нь буюу **48.1** хувь нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор их, дээд сургуулийн харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын 5 байгууллага байгуулагдаж Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/335 дугаар тушаалаар сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Үүнд:

1. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв
2. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв
3. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн харьяа Цэргийн хөгжмийн политехник коллеж
4. Орхон аймгийн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа "Эрдэнэт политехник коллеж"
5. Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж


## 5.2 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧ

Зураг 5.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагч, өмчийн хэлбэр, хувиар



Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын **77** байгууллагад 2022-2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилийн байдлаар **38,034** суралцагч суралцаж байгаагаас **27,400** буюу **72.0** хувь нь төрийн өмчийн, **10,634** буюу **28.0** хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна.

Зураг 5.4 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, хүйсээр




Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын **14,274** буюу **37.5** хувийг эмэгтэй, **23,760** буюу **62.5** хувийг эрэгтэй суралцагч эзэлж байна.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй суралцагч тутамд ногдох эмэгтэй суралцагчийн тоо **60** болж өмнөх хичээлийн жилээс **7** пунктээр буурсан байна.





**Зураг 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлын индекс, хувиар**



● Нийт суралцагчдад эмэгтэй суралцагчийн эзлэх хувь ● Хүйсийн тэнцвэрт байдлын индекс

**Зураг 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын тоо, нутаг дэвсгэрийн байршлаар**



Нийт суралцагчийн **19,115** буюу **50.3** хувь нь Улаанбаатар хотын **37** сургалтын байгууллагад, **18,919** буюу **49.7** хувь нь орон нутгийн **40** сургалтын байгууллагад суралцаж байна. Аймагаар авч үзвэл, 2022-2023 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай нь Дархан-Уул аймгийн сургалтын **3** байгууллагад **2,260**, хамгийн цөөн суралцагчтай нь Сүхбаатар аймгийн сургалтын **1** байгууллагад **387** суралцагч суралцаж байна.

Зураг 5.7 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагчид, сургалтын хэв шинжээр



Хүснэгт 5.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, мэргэжлийн салбараар, 2022/2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд

Д/д	Салбар	Мэргэжлийн тоо	Нийт суралцагчид	Үүнээс:			Хувь
				Техникийн боловсрол	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт	
1	Боловсрол	2	64	44	20	-	0.2%
2	Соёл, урлаг	28	2,935	586	2,335	14	7.7%
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	15	94	-	94	-	0.2%
4	Санхүү, бизнес, худалдааны	5	511	87	424	-	1.3%
5	Мэдээллийн технологи	13	2,359	211	2,148	-	6.2%
6	Шуудан, харилцаа холбоо	2	124	-	124	-	0.3%
7	Байгаль орчин, аялал жуулчлал	7	1,127	11	1,116	-	3.0%
8	Барилга	28	7,601	782	6,800	19	20.0%
9	Тээвэр	22	4,826	1,055	3,729	42	12.7%
10	Эрчим хүч	7	194	52	142	-	0.5%
11	Уул уурхай	18	2,091	307	1,761	23	5.5%
12	Хөдөө аж ахуй	16	1,468	266	1,202	-	3.9%
13	Аж үйлдвэр	38	11,828	1,255	10,435	138	31.1%
14	Хот байгуулалт, тохижуулалт	2	114	-	114	-	0.3%
15	Үйлчилгээ	7	2,400	97	2,303	-	6.3%
16	Эрүүл мэнд	2	298	-	280	18	0.8%
<b>Дүн</b>		<b>212</b>	<b>38,034</b>	<b>4,753</b>	<b>33,027</b>	<b>254</b>	<b>100.0%</b>


**Зураг 5.8 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, мэргэжлийн салбараар, хүйсээр, 2022/2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд**



Нийт суралцагчдыг мэргэжлийн салбараар авч үзвэл, 2022-2023 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай мэргэжлийн салбаруудаас аж үйлдвэрийн салбарын **38** мэргэжлийг нийт суралцагчдын **31.1** хувь нь, барилгын салбарын **28** мэргэжлийг нийт суралцагчдын **20.0** хувь нь тус тус сонгон суралцаж байгаа бол хамгийн цөөн суралцагчтай нь боловсролын салбарын **2** мэргэжлийг нийт суралцагчдын **0.2** хувь нь сонгон суралцаж байна.




**Зураг 5.9 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, насаар, 2022/2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд**



Нийт суралцагчдын 14,141 буюу 37.2 хувийг 14-16, 13,017 буюу 34.2 хувийг 17-20, 2,708 буюу 7.1 хувийг 30-34, 2,254 буюу 5.9 хувийг 25-29, 2,144 буюу 5.6 хувийг 21-24, 1,993 буюу 5.2 хувийг 35-39, 1,352 буюу 3.6 хувийг 40-45, 389 буюу 1.0 хувийг 46 ба түүнээс дээш насныхан, 36 суралцагч 0.1 хувийг 14 наснаас доош насныхан эзэлж байна.

Нийт **38,034** суралцагчдаас **18** хүртэлх насны суралцагчид **20,834** байна. **18** хүртэлх насны суралцагчдаас хагас өнчин **2,293** буюу нийт суралцагчдын **6.0** хувийг, бүтэн өнчин **259** буюу нийт суралцагчдын **0.7** хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй **643** суралцагч сурч байгаа нь нийт суралцагчдын **1.7** хувийг эзэлж байна.

**Зураг 5.10 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, тэдгээрийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2022/2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд**




**Шинээр элсэгч.** Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2022-2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд **19,256** суралцагч шинээр элссэн байна. Нийт шинээр элсэгчдийн **7,779** буюу **40.4** хувь нь эмэгтэй, **11,477** буюу **59.6** хувь нь эрэгтэй байна. Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй шинээр элсэгч тутамд ногдох эмэгтэй шинээр элсэгчийн тоо **67** байна.

**Хүснэгт 5.4 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчдийн тоо**

Үзүүлэлт	2018/ 2019	2019/ 2020	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023
<b>Нийт шинээр элсэгч</b>	<b>24,999</b>	<b>24,853</b>	<b>24,628</b>	<b>25,264</b>	<b>19,256</b>
Үүнэс: Эмэгтэй	9,485	10,396	10,613	11,087	7,779
Эрэгтэй	15,514	14,457	14,015	14,177	11,477
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 9-р анги төгсөгчийн тоо	7,521	8,435	9,095	7,966	7,827
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12-р анги төгсөгчийн тоо	4,905	2,892	2,112	1,575	1,356
Ажиллагчдаас	5,571	3,756	2,363	2,179	1,700
Ажилгүй иргэдээс	6,238	8,829	8,905	11,282	6,677
Бусад	764	941	2,153	2,262	1,696



**Зураг 5.11 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчид, хүйсээр**



Шинээр элсэгчдийн **7,827** буюу **40.6** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын 9 дүгээр ангийг төгссөн суурь боловсрол эзэмшигчээс, **1,356** буюу **7.0** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын 12 дугаар анги төгссөн бүрэн дунд боловсрол эзэмшигчээс, **6,677** буюу **34.7** хувь нь ажилгүй иргэдээс, **1,700** буюу **8.8** хувь нь ажиллагчдаас, **1,696** буюу **8.8** хувь нь бусад хүрээнээс элссэн байна.

2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нийт төгсөгчдөөс:

- Суурь боловсрол эзэмшсэн нийт **53,619** төгсөгчдийн **7,827** буюу **14.6** хувь нь:
- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн нийт **32,908** төгсөгчдийн **1,356** буюу **4.1** хувь нь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, ур чадвар эзэмшихээр элссэн байна.



**Хүснэгт 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын шинээр элсэгч, суралцагч, төгсөх ангид суралцагчид, мэргэжлийн салбараар, хүйсээр, 2022/2023 оны хичээлийн жилийн эхний хагас жилд**

№	Салбар	Шинээр элсэгчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	17	10	17	10	-	-	-	-
2	Соёл, урлаг	1,178	551	212	102	952	449	14	-
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	94	-	-	-	94	-	-	-
4	Санхүү, бизнес, худалдаа	448	334	24	24	424	310	-	-
5	Мэдээллийн технологи	1,172	715	57	14	1,115	701	-	-
6	Шуудан, харилцаа холбоо	66	29	-	-	66	29	-	-
7	Байгаль орчин, аялал жуулчлал	874	480	-	-	874	480	-	-
8	Барилга	3,366	549	171	33	3,176	516	19	-
9	Тээвэр	2,360	511	460	132	1,858	368	42	11
10	Эрчим хүч	85	10	-	-	85	10	-	-
11	Уул уурхай	1,193	215	57	25	1,113	189	23	1
12	Хөдөө аж ахуй	1,024	438	119	40	905	398	-	-
13	Аж үйлдвэр	5,750	2,611	281	118	5,331	2,436	138	57
14	Хот байгуулалт, тохижилт	114	63	-	-	114	63	-	-
15	Үйлчилгээ	1,219	1,011	15	14	1,204	997	-	-
16	Эрүүл мэнд	296	252	-	-	278	238	18	14
<b>Дүн</b>		<b>19,256</b>	<b>7,779</b>	<b>1,413</b>	<b>512</b>	<b>17,589</b>	<b>7,184</b>	<b>254</b>	<b>83</b>

№	Салбар	Суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	64	51	44	31	20	20	-	-
2	Соёл, урлаг	2,935	1,518	586	355	2,335	1,163	14	-
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	94	-	-	-	94	-	-	-
4	Санхүү, бизнес, худалдаа	511	386	87	76	424	310	-	-
5	Мэдээллийн технологи	2,359	1,395	211	81	2,148	1,314	-	-
6	Шуудан, харилцаа холбоо	124	46	-	-	124	46	-	-
7	Байгаль орчин, аялал жуулчлал	1,127	642	11	8	1,116	634	-	-
8	Барилга	7,601	1,103	782	148	6,800	955	19	-
9	Тээвэр	4,826	666	1,055	275	3,729	380	42	11
10	Эрчим хүч	194	22	52	9	142	13	-	-
11	Уул уурхай	2,091	293	307	77	1,761	215	23	1
12	Хөдөө аж ахуй	1,468	547	266	87	1,202	460	-	-
13	Аж үйлдвэр	11,828	5,255	1,255	641	10,435	4,557	138	57
14	Хот байгуулалт, тохижилт	114	63	-	-	114	63	-	-
15	Үйлчилгээ	2,400	2,034	97	89	2,303	1,945	-	-
16	Эрүүл мэнд	298	253	-	-	280	239	18	14
<b>Дүн</b>		<b>38,034</b>	<b>14,274</b>	<b>4,753</b>	<b>1,877</b>	<b>33,027</b>	<b>12,314</b>	<b>254</b>	<b>83</b>

№	Салбар	Төгсөх ангид суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	10	10	10	10	-	-	-	-
2	Соёл, урлаг	1,040	551	209	139	817	412	14	-
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	94	-	-	-	94	-	-	-
4	Санхүү, бизнес, худалдаа	477	352	53	42	424	310	-	-
5	Мэдээллийн технологи	1,266	819	117	52	1,149	767	-	-
6	Шуудан, харилцаа холбоо	62	24	-	-	62	24	-	-
7	Байгаль орчин, аялал жуулчлал	913	489	11	8	902	481	-	-
8	Барилга	3,956	655	540	104	3,397	551	19	-
9	Тээвэр	2,365	483	427	105	1,896	367	42	11
10	Эрчим хүч	134	20	52	9	82	11	-	-
11	Уул уурхай	1,340	226	170	31	1,147	194	23	1
12	Хөдөө аж ахуй	1,087	455	89	23	998	432	-	-
13	Аж үйлдвэр	6,256	3,122	825	442	5,293	2,623	138	57
14	Хот байгуулалт, тохижилт	114	63	-	-	114	63	-	-
15	Үйлчилгээ	1,325	1,093	82	75	1,243	1,018	-	-
16	Эрүүл мэнд	282	251	-	-	264	237	18	14
<b>Дүн</b>		<b>20,721</b>	<b>8,613</b>	<b>2,585</b>	<b>1,040</b>	<b>17,882</b>	<b>7,490</b>	<b>254</b>	<b>83</b>

## 5.3 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧИД

2020-2021 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын **75** байгууллагыг **19,734** суралцагч **16** салбарын **195** мэргэжлээр ур чадвар эзэмшин төгссөн. Төгсөгчдийн **45.5%** буюу **8,987** нь төгсөнгүүтээ шууд ажлын байртай, **6.2%** буюу **1,217** нь дараагийн шатны боловсролын түвшинд дэвшин суралцсан статистик мэдээ гарсан байна.




Төгсөгчдийн статистик мэдээллийг 2021 оны 07 дугаар сард захиргааны статистик мэдээллээр гарган түүнээс хойш тухайн оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар мөшгөх судалгаа хийгдээгүй бөгөөд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хэрхэн өөрчлөгдсөн талаарх тоон мэдээллийг цуглуулах шаардлага бий болсон.

Иймд төгсөгчдөөс мэргэжлээрээ ажиллаж байгаа, эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа, өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа, гадаадад ажил хөдөлмөр эрхэлж байгаа зэрэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г салбарын бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зорилгоор 2022 оны 10 дугаар сард зохион байгуулан үр дүнг нэгтгэн дор харууллаа.

Судалгаанд 2020-2021 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын **75** байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 2022 оны 10 дугаар сарын байдлаар дээрх сургалтын байгууллагуудаас **2** байгууллага сургалтын үйл ажиллагаагаа зогсоож судалгаанд нийт **73** сургалтын байгууллагын **19,290** төгсөгчийг хамруулсны **10,668** буюу **55.3** хувь нь эрэгтэй, **8,622** буюу **44.7** хувь нь эмэгтэй төгсөгч байна.

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн **14,366** нь хөдөлмөр эрхлэх буюу дараагийн боловсролын түвшинд суралцаж **4,924** нь бусад шалтгаантай /цэрэгт явсан, хүүхдээ хараад гэртээ байгаа, ямар нэгэн тодорхой шалтгаантай, холбоо барих боломжгүй, ажилгүй зэрэг/ байна. Өөрөөр хэлбэл 2021 оны нийт төгсөгчдийн **97.7** хувь нь энэхүү судалгаанд хамрагдсан байна.

**Зураг 5.12 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчид, судалгаанд оролцогчдын тоо**



2021 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нь 1 жилийн дараа буюу 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт төгсөгчдийн **67.1** хувь нь хөдөлмөр эрхэлж, **7.4** хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна. Ийнхүү 2021 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өмнөх жилээс **21.6** хувиар өссөн байна.

**Зураг 5.13 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч /хувиар/**



Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 1 жилийн дараа нэмэгдэх болсон гол шалтгаан нь 2020, 2021 онд цар тахлын халдвар хамгааллын дэглэм, хөл хорионы улмаас аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа зогсож, нэлээдгүй иргэд ажилгүй болж байсан үе байсан. Цар тахлын хөл хорио үе шаттайгаар суларч, цуцлагдсаны дараа аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч, хэвийн горимд шилжсэнээр ажиллагчдын тоо цар тахлын өмнөх түвшинд хүрч нэмэгдсэн байна.

**Эх үүсвэр:** ХНХЯ, Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал

Судалгаанд оролцогч нийт **19,290** төгсөгчөөс **6,899** буюу **35.8** хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа, **4,192** буюу **21.7** хувь нь эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа, **1,729** буюу **9.0** хувь нь өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа, **122** буюу **0.6** хувь нь гадаадад ажил хөдөлмөр эрхэлж байгаа, **827** буюу **4.3** хувь нь дээд боловсролд, **493** буюу **2.6** хувь нь техникийн боловсролд, **104** буюу **0.5** хувь нь гадаадад боловсрол эзэмшин суралцаж байна.




### Хүснэгт 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр, 2022 оны 10 дугаар сарын байдлаар

Үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллага	Судалгаанд хамрагдсан төгсөгчийн тоо	Ажлын байртай болсон төгсөгч					Дараагийн боловсролын түвшинд элссэн төгсөгч			
		Бүгд	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч	Эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч	Өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч	Гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч	Бүгд	Дээд боловсрол	Техникийн боловсрол	Гадаадын улсад суралцаж байгаа төгсөгч
<b>Бүгд-73</b>	<b>19,290</b>	<b>12,942</b>	<b>6,899</b>	<b>4,192</b>	<b>1,729</b>	<b>122</b>	<b>1,424</b>	<b>827</b>	<b>493</b>	<b>104</b>
Төрийн өмчийн МСҮТ дүн-15	3,456	2,081	996	816	262	7	95	60	25	10
Төрийн өмчийн политехник коллеж дүн-22	7,884	5,113	2,697	1,939	450	27	727	399	291	37
Төрийн их сургууль, байгууллагын харъяа дүн-9	1,732	1,153	750	176	222	5	99	70	12	17
Хувийн өмчийн МСҮТ дүн-20	3,475	2,520	1,120	775	588	37	139	110	14	15
Хувийн өмчийн политехник коллеж дүн-7	2,743	2,075	1,336	486	207	46	364	188	151	25

### Зураг 5.14 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч, хувиар



**Зураг 5.15 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн салбараар, тоогоор**



**Хүснэгт 5.7 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, бүсээр, аймаг, нийслэлээр, 2022 оны 10 дугаар сарын байдлаар**

Аймаг, нийслэл	Сургалтын байгууллагын тоо	Судалгаанд хамрагдсан төгсөгч			Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч			
		Бүгд	Эр	Эм	Хувь	Бүгд	Эр	Эм
<b>Бүгд</b>	<b>67.1</b>	<b>19,290</b>	<b>10,668</b>	<b>8,622</b>	<b>67</b>	<b>12,942</b>	<b>7,421</b>	<b>5,521</b>
<b>Баруун бүс</b>	<b>64.2</b>	<b>2,078</b>	<b>1,001</b>	<b>1,077</b>	<b>64</b>	<b>1,335</b>	<b>603</b>	<b>732</b>
Баян-Өлгий	51.1	405	212	193	51	207	110	97
Говь-Алтай	65.7	172	86	86	66	113	65	48
Завхан	62.8	430	164	266	63	270	95	175
Увс	69.1	469	251	218	69	324	172	152
Ховд	69.9	602	288	314	70	421	161	260
<b>Хангайн бүс</b>	<b>64.9</b>	<b>3,542</b>	<b>1,541</b>	<b>2,001</b>	<b>65</b>	<b>2,299</b>	<b>1,031</b>	<b>1,268</b>
Архангай	56.0	1,099	498	601	56	615	291	324
Баянхонгор	78.0	737	311	426	78	575	238	337
Булган	77.3	418	160	258	77	323	126	197
Орхон	53.2	504	276	228	53	268	149	119
Өвөрхангай	63.4	584	190	394	63	370	159	211
Хөвсгөл	74.0	200	106	94	74	148	68	80
<b>Төвийн бүс</b>	<b>61.8</b>	<b>3,386</b>	<b>2,093</b>	<b>1,293</b>	<b>62</b>	<b>2,091</b>	<b>1,335</b>	<b>756</b>
Говьсүмбэр	55.5	274	199	75	55	152	98	54
Дархан-Уул	57.7	951	641	310	58	549	381	168
Дорноговь	76.5	349	219	130	77	267	172	95
Дундговь	72.0	279	139	140	72	201	112	89
Өмнөговь	42.5	261	186	75	43	111	82	29
Сэлэнгэ	60.2	389	188	201	60	234	119	115
Төв	65.3	883	521	362	65	577	371	206
<b>Зүүн бүс</b>	<b>65.5</b>	<b>1,148</b>	<b>619</b>	<b>529</b>	<b>66</b>	<b>752</b>	<b>438</b>	<b>314</b>
Дорнод	61.4	583	330	253	61	358	203	155
Сүхбаатар	73.1	186	97	89	73	136	93	43
Хэнтий	68.1	379	192	187	68	258	142	116
<b>Улаанбаатар</b>	<b>70.8</b>	<b>9,136</b>	<b>5,414</b>	<b>3,722</b>	<b>71</b>	<b>6,465</b>	<b>4,014</b>	<b>2,451</b>
Багануур	99.5	194	76	118	99	193	75	118
Баянгол	74.9	2,393	1,696	697	75	1,792	1,341	451
Баянзүрх	71.3	2,232	1,278	954	71	1,592	910	682
Налайх дүүрэг	62.3	265	149	116	62	165	105	60
Сонгинохайрхан	69.5	715	469	246	70	497	348	149
Сүхбаатар	64.4	1,497	564	933	64	964	371	593
Чингэлтэй	79.1	187	71	116	79	148	60	88
Хан-Уул	67.4	1,653	1,111	542	67	1,114	804	310



Аймаг, нийслэл	Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч							
	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч				Эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч			
	Хувь	Бүгд	Эр	Эм	Хувь	Бүгд	Эр	Эм
<b>Бүгд</b>	<b>35.8</b>	<b>6,899</b>	<b>4,351</b>	<b>2,548</b>	<b>21.7</b>	<b>4,192</b>	<b>2,169</b>	<b>2,023</b>
<b>Баруун бүс</b>	<b>28.8</b>	<b>598</b>	<b>274</b>	<b>324</b>	<b>28.6</b>	<b>595</b>	<b>277</b>	<b>318</b>
Баян-Өлгий	19.0	77	46	31	27.2	110	56	54
Говь-Алтай	15.7	27	18	9	36.6	63	37	26
Завхан	30.9	133	51	82	23.3	100	36	64
Увс	28.1	132	76	56	33.7	158	82	76
Ховд	38.0	229	83	146	27.2	164	66	98
<b>Хангайн бүс</b>	<b>26.7</b>	<b>947</b>	<b>506</b>	<b>441</b>	<b>21.4</b>	<b>759</b>	<b>303</b>	<b>456</b>
Архангай	21.7	238	121	117	15.7	173	75	98
Баянхонгор	23.1	170	84	86	20.6	152	73	79
Булган	28.9	121	56	65	40.9	171	62	109
Орхон	33.3	168	95	73	19.0	96	51	45
Өвөрхангай	28.4	166	102	64	21.1	123	29	94
Хөвсгөл	42.0	84	48	36	22.0	44	13	31
<b>Төвийн бүс</b>	<b>34.3</b>	<b>1,163</b>	<b>816</b>	<b>347</b>	<b>23.2</b>	<b>787</b>	<b>456</b>	<b>331</b>
Говьсүмбэр	19.3	53	39	14	30.3	83	47	36
Дархан-Уул	30.7	292	222	70	23.7	225	136	89
Дорноговь	35.2	123	93	30	33.8	118	72	46
Дундговь	30.8	86	55	31	41.2	115	57	58
Өмнөговь	21.5	56	42	14	19.9	52	40	12
Сэлэнгэ	26.5	103	64	39	22.6	88	42	46
Төв	51.0	450	301	149	12.0	106	62	44
<b>Зүүн бүс</b>	<b>29.9</b>	<b>343</b>	<b>222</b>	<b>121</b>	<b>27.1</b>	<b>311</b>	<b>161</b>	<b>150</b>
Дорнод	29.3	171	111	60	24.2	141	75	66
Сүхбаатар	21.0	39	31	8	31.2	58	31	27
Хэнтий	35.1	133	80	53	29.6	112	55	57
<b>Улаанбаатар</b>	<b>42.1</b>	<b>3,848</b>	<b>2,533</b>	<b>1,315</b>	<b>19.0</b>	<b>1,740</b>	<b>972</b>	<b>768</b>
Багануур	43.3	84	49	35	35.6	69	8	61
Баянгол	39.7	951	738	213	19.7	471	333	138
Баянзүрх	48.3	1,079	699	380	14.0	312	138	174
Налайх дүүрэг	35.5	94	67	27	15.8	42	20	22
Сонгинохайрхан	44.6	319	243	76	16.4	117	68	49
Сүхбаатар	32.1	481	169	312	24.6	369	155	214
Чингэлтэй	54.5	102	37	65	18.7	35	16	19
Хан-Уул	44.6	738	531	207	19.7	325	234	91

Аймаг, нийслэл	Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч							
	Өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч				Гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч			
	Хувь	Бүгд	Эр	Эм	Хувь	Бүгд	Эр	Эм
<b>Бүгд</b>	<b>9.0</b>	<b>1,729</b>	<b>824</b>	<b>905</b>	<b>0.6</b>	<b>122</b>	<b>77</b>	<b>45</b>
<b>Баруун бүс</b>	<b>6.5</b>	<b>136</b>	<b>50</b>	<b>86</b>	<b>0.3</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>
Баян-Өлгий	4.9	20	8	12	0.0	0	0	0
Говь-Алтай	12.8	22	9	13	0.6	1	1	0
Завхан	7.4	32	7	25	1.2	5	1	4
Увс	7.2	34	14	20	0.0	0	0	0
Ховд	4.7	28	12	16	0.0	0	0	0
<b>Хангайн бүс</b>	<b>16.7</b>	<b>591</b>	<b>221</b>	<b>370</b>	<b>0.1</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>
Архангай	18.5	203	94	109	0.1	1	1	0
Баянхонгор	34.3	253	81	172	0.0	0	0	0
Булган	7.2	30	8	22	0.2	1	0	1
Орхон	0.8	4	3	1	0.0	0	0	0
Өвөрхангай	13.9	81	28	53	0.0	0	0	0
Хөвсгөл	10.0	20	7	13	0.0	0	0	0
<b>Төвийн бүс</b>	<b>3.9</b>	<b>131</b>	<b>58</b>	<b>73</b>	<b>0.3</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>5</b>
Говьсүмбэр	5.8	16	12	4	0.0	0	0	0
Дархан-Уул	2.6	25	18	7	0.7	7	5	2
Дорноговь	7.4	26	7	19	0.0	0	0	0
Дундговь	0.0	0	0	0	0.0	0	0	0
Өмнөговь	1.1	3	0	3	0.0	0	0	0
Сэлэнгэ	11.1	43	13	30	0.0	0	0	0
Төв	2.0	18	8	10	0.3	3	0	3
<b>Зүүн бүс</b>	<b>8.3</b>	<b>95</b>	<b>55</b>	<b>40</b>	<b>0.3</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>3</b>
Дорнод	7.5	44	17	27	0.3	2	0	2
Сүхбаатар	21.0	39	31	8	0.0	0	0	0
Хэнтий	3.2	12	7	5	0.3	1	0	1
<b>Улаанбаатар</b>	<b>8.5</b>	<b>776</b>	<b>440</b>	<b>336</b>	<b>1.1</b>	<b>101</b>	<b>69</b>	<b>32</b>
Багануур	16.0	31	13	18	4.6	9	5	4
Баянгол	14.4	344	253	91	1.1	26	17	9
Баянзүрх	8.6	192	69	123	0.4	9	4	5
Налайх дүүрэг	10.2	27	16	11	0.8	2	2	0
Сонгинохайрхан	6.4	46	28	18	2.1	15	9	6
Сүхбаатар	6.9	103	37	66	0.7	11	10	1
Чингэлтэй	0.0	0	0	0	5.9	11	7	4
Хан-Уул	2.0	33	24	9	1.1	18	15	3

**Хүснэгт 5.8 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн ажил эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч, мэргэжлийн салбараар, 2022 оны 10 дугаар сарын байдлаар**

Салбар, мэргэжлээр	2020-2021 оны төгсөгчийн статистик тоон мэдээлэл	Судалгаанд хамрагдсан төгсөгч	Нийт ажлын байртай болсон болон дараагийн түвшинд суралцаж байгаа төгсөгч	Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч		
				Бүгд	Эр	Эм
<b>БҮГД-196 мэргэжил</b>	<b>19,290</b>	<b>19,290</b>	<b>14,366</b>	<b>12,942</b>	<b>7,421</b>	<b>5,521</b>
Боловсролын салбар-1 мэргэжил	8	8	8	8	3	5
Соёл, урлагийн салбар-25 мэргэжил	888	888	683	516	251	265
Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбар-19 мэргэжил	151	151	151	151	151	0
Санхүү, бизнес, худалдааны салбар-4 мэргэжил	425	425	336	302	56	246
Мэдээллийн технологийн салбар-13 мэргэжил	947	947	664	533	179	354
Шуудан, харилцаа холбооны салбар-1 мэргэжил	72	72	70	63	35	28
Байгаль орчин, аялал жуулчлалын салбар-6 мэргэжил	611	611	421	384	161	223
Барилгын салбар-23 мэргэжил	3726	3726	2,720	2,427	1,927	500
Тээврийн салбар-22 мэргэжил	2116	2116	1,670	1,553	1,286	267
Эрчим хүчний салбар-6 мэргэжил	176	176	124	122	90	32
Уул уурхайн салбар-19 мэргэжил	1532	1532	1,110	1,036	844	192
Хөдөө аж ахуйн салбар-17 мэргэжил	1320	1320	998	976	484	492
Аж үйлдвэрийн салбар-30 мэргэжил	5801	5801	4,358	3,934	1,790	2,144
Хот байгуулалт, тохижилтын салбар-1 мэргэжил	91	91	78	75	34	41
Үйлчилгээний салбар-7 мэргэжил	1271	1271	867	771	120	651
Эрүүл мэндийн салбар-2 мэргэжил	155	155	108	91	10	81

Салбар, мэргэжлээр	Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч											
	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч			Эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч			Өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч			Гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
<b>БҮГД-196 мэргэжил</b>	<b>6,899</b>	<b>4,351</b>	<b>2,548</b>	<b>4,192</b>	<b>2,169</b>	<b>2,023</b>	<b>1,729</b>	<b>824</b>	<b>905</b>	<b>122</b>	<b>77</b>	<b>45</b>
Боловсролын салбар-1 мэргэжил	8	3	5	0	0	0	0	0	0	0	0	0
Соёл, урлагийн салбар-25 мэргэжил	248	122	126	174	83	90	91	44	45	3	2	1
Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбар-19 мэргэжил	151	151	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүү, бизнес, худалдааны салбар-4 мэргэжил	126	18	108	101	31	70	72	6	63	3	1	2
Мэдээллийн технологийн салбар-13 мэргэжил	215	67	148	262	95	167	51	16	38	5	1	4
Шуудан, харилцаа холбооны салбар-1 мэргэжил	22	15	7	20	11	10	21	9	12	0	0	0
Байгаль орчин, аялал жуулчлалын салбар-6 мэргэжил	114	52	62	181	71	110	85	36	49	4	2	2
Барилгын салбар-23 мэргэжил	1,434	1,185	249	734	544	190	235	179	56	24	19	5
Тээврийн салбар-22 мэргэжил	881	752	129	386	317	69	272	207	65	14	10	4
Эрчим хүчний салбар-6 мэргэжил	68	56	12	51	31	20	2	2	0	1	1	0
Уул уурхайн салбар-19 мэргэжил	605	527	78	361	256	105	56	50	6	14	11	3
Хөдөө аж ахуйн салбар-17 мэргэжил	429	257	172	274	125	149	271	101	170	2	1	1
Аж үйлдвэрийн салбар-30 мэргэжил	2,121	1,033	1,088	1,292	566	726	478	165	313	43	26	17
Хот байгуулалт, тохижилтын салбар-1 мэргэжил	44	26	18	23	6	17	8	2	6	0	0	0
Үйлчилгээний салбар-7 мэргэжил	367	83	284	313	29	284	84	7	79	7	1	6
Эрүүл мэндийн салбар-2 мэргэжил	66	4	62	20	4	16	3	0	3	2	2	0

Салбар, мэргэжлээр	Дараагийн боловсролын түвшинд элссэн төгсөгч											
	Бүгд	Эр	Эм	Дээд боловсрол			Техникийн боловсрол			Гадаадын улсад суралцаж байгаа төгсөгч		
				Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
<b>БҮГД-196 мэргэжил</b>	<b>1,424</b>	<b>753</b>	<b>671</b>	<b>827</b>	<b>406</b>	<b>421</b>	<b>493</b>	<b>306</b>	<b>187</b>	<b>104</b>	<b>41</b>	<b>63</b>
Боловсролын салбар-1 мэргэжил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Соёл, урлагийн салбар-25 мэргэжил	167	78	89	125	55	70	18	11	7	24	12	12
Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдлын салбар-19 мэргэжил	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүү, бизнес, худалдааны салбар-4 мэргэжил	34	6	28	19	2	17	14	4	10	1	0	1
Мэдээллийн технологийн салбар-13 мэргэжил	131	37	94	105	28	77	21	8	13	5	1	4
Шуудан, харилцаа холбооны салбар-1 мэргэжил	7	6	1	6	5	1	0	0	0	1	1	0
Байгаль орчин, аялал жуулчлалын салбар-6 мэргэжил	37	4	33	25	4	21	3	0	3	9	0	9
Барилгын салбар-23 мэргэжил	293	219	74	148	111	37	134	101	33	11	7	4
Тээврийн салбар-22 мэргэжил	117	97	20	58	49	9	48	45	3	11	3	8
Эрчим хүчний салбар-6 мэргэжил	2	0	2	2	0	2	0	0	0	0	0	0
Уул уурхайн салбар-19 мэргэжил	74	68	6	37	31	6	32	32	0	5	5	0
Хөдөө аж ахуйн салбар-17 мэргэжил	22	15	7	13	7	6	9	8	1	0	0	0
Аж үйлдвэрийн салбар-30 мэргэжил	424	209	215	217	107	110	177	92	85	30	10	20
Хот байгуулалт, тохилтын салбар-1 мэргэжил	3	1	2	2	1	1	1	0	1	0	0	0
Үйлчилгээний салбар-7 мэргэжил	96	11	85	54	5	49	36	5	31	6	1	5
Эрүүл мэндийн салбар-2 мэргэжил	17	2	15	16	1	15	0	0	0	1	1	0

## 5.4 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2022-2023 оны хичээлийн жилд нийт **4,094** багш, ажиллагчид байгаагаас төрийн өмчийн сургалтын байгууллагад **3,334**, хувийн өмчийн сургалтын байгууллагад **760** багш, ажиллагчид ажиллаж байна.

**Хүснэгт 5.9 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажиллагчид, хүйс, албан тушаалаар**

Үзүүлэлт	2018/ 2019	2019/ 2020	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023
<b>Нийт ажиллагчид</b>	<b>4,624</b>	<b>4,403</b>	<b>4,061</b>	<b>3,944</b>	<b>4,094</b>
эмэгтэй	2,985	2,864	2,605	2,559	2,680
эрэгтэй	1,639	1,539	1,456	1,385	1,414
Үндсэн багш	2,469	2,388	2,242	2,124	2,252
Бусад ажиллагчид	1,972	1,835	1,652	1,649	1,686
Захирал болон дэд захирал	103	103	94	97	81
Сургалтын менежер	80	77	73	74	75
Нийт ажиллагчдад үндсэн багшийн эзлэх хувь	53.4	54.2	55.2	53.9	55.0


**Зураг 5.16 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажилтан, хүйс, албан тушаалаар**



Нийт ажиллагчдын **2,680** буюу **65.5** хувь нь эмэгтэй, **1,414** буюу **34.5** хувь нь эрэгтэй ажиллагчид байна. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт ажиллагчдын дотор үндсэн багш **2,252** буюу **55.0** хувь, захирал болон дэд захирал **81** буюу **2.0** хувь, сургалтын менежер **75** буюу **1.8** хувь, бусад ажиллагчид **1,686** буюу **41.2** хувийг тус тус эзэлж байна.



**Зураг 5.17 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш**




2022-2023 оны хичээлийн жилд нийт багш, ажиллагчдын **2,252** буюу **55.0** хувийг үндсэн багш эзэлж байна.

Үндсэн багшийн **1,545** буюу **68.6** хувь нь мэргэжлийн, **707** буюу **31.4** хувь нь ерөнхий эрдмийн багш байна.

Үндсэн багшийн **1,460** буюу **64.8** хувь нь эмэгтэй, **792** буюу **35.2** хувь нь эрэгтэй багш байна.



**Зураг 5.18 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, өмчийн хэлбэрээр**



Нийт үндсэн багшийн **1,806** буюу **80.2** хувь нь төрийн өмчийн, **446** буюу **19.8** хувь нь хувийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш байна.


Үндсэн багшийн **1,566** буюу **69.5** хувь нь төрийн өмчийн, **446** буюу **19.8** хувь нь хувийн өмчийн, **240** буюу **10.7** хувь нь төрийн өмчийн их, дээд сургууль, байгууллагын харьяа сургалтын байгууллагад ажиллаж байна.



### Хүснэгт 5.10 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийг нас, өмчийн хэлбэрээр, 2022/2023

Багшийн нас	Үндсэн багш	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага		
		Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Төрийн өмчийн их, дээд сургууль, байгууллагын харьяа
<b>Сургалтын байгууллага</b>	<b>77</b>	<b>37</b>	<b>29</b>	<b>11</b>
<b>Үндсэн багш</b>	<b>2,252</b>	<b>1,566</b>	<b>446</b>	<b>240</b>
30 хүртэл	365	227	105	33
30-39	959	727	148	84
40-49	562	401	80	81
50-59	293	190	65	38
60, түүнээс дээш	73	21	48	4

### Зураг 5.19 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийг нас, өмчийн хэлбэрээр, 2022/2023



### Хүснэгт 5.11 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн боловсролын түвшин, өмчийн хэлбэрээр, 2022/2023

Багшийн нас	Үндсэн багш	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага		
		Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Төрийн өмчийн их, дээд сургууль, байгууллагын харьяа
<b>Сургалтын байгууллага</b>	<b>77</b>	<b>37</b>	<b>29</b>	<b>11</b>
<b>Үндсэн багш</b>	<b>2,252</b>	<b>1,566</b>	<b>446</b>	<b>240</b>
Доктор	17	2	8	7
Магистр	984	657	164	163
Бакалавр	1,082	797	226	59
Диплом	151	99	41	11
Бусад *	18	11	7	-
Багшлах эрхтэй багш	1,868	1,376	295	197

\* Бусад гэсэн хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан "Багшлах эрх олгох, хасах журам"-ын 3.1.2-д "Үйлдвэрлэлийн зохих дадлага, туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй" багшийг оруулан тооцсон.



**Зураг 5.20 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн боловсролын түвшин**





Үндсэн багшийн **1,082** буюу **48.0** хувь нь бакалавр, **984** буюу **43.7** хувь нь магистр, **151** буюу **6.7** хувь нь диплом, **18** буюу **0.8** хувь нь бусад, **17** буюу **0.8** хувь нь докторын зэрэгтэй байна.

Нийт үндсэн багшийн **1,868** буюу **82.9** хувь нь багшлах эрхтэй байна.



**Зураг 5.21 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт багш, ажилтан, албан тушаалаар, 2022/2023**





06

ДЭЭД БОЛОВСРОЛ

---

## САЛБАРЫН ОНЦЛОГ: ДЭЭД БОЛОВСРОЛ

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хөдөө орон нутагт мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж орон нутагт төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлснээр Дархан-Уул, Орхон болон бусад аймгуудад төрийн өмчийн их, дээд сургуулиудыг өөрчлөн Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг байгуулаад байна.

Дээд боловсролын салбарт өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа зарим арга хэмжээнээс дурдвал:

- Дээд боловсролын тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулах, холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэх;
- Их, дээд сургуулийн эрэмбэ чансаа тогтоох аргачлал боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур боловсруулах, туршилтын эрэмбэ, чансаа тогтоох, чанарын үнэлгээ хийх;
- Боловсролын олон улсын ангилалын дагуу боловсруулсан хөтөлбөрийн индексд өмнөх индексийг дүйцүүлэх, үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтыг ажлын байрны ур чадвартай уялдуулах;
- Эрэлттэй тэргүүлэх мэргэжлийг тодорхойлох, эрэмбэлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зээл, тэтгэлэг олгох, квот тогтоох, элсэлтийн шалгуур, шаардлагыг тогтоох;
- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг үнэлэх шалгуур, шаардлага боловсруулах, шалгуурт суурилсан хөндлөнгийн үнэлгээний арга зүйг боловсруулах;
- Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлж дотоод чанарыг хянах баталгаажуулах гүйцэтгэлийн үзүүлэлтийг тогтоох зэрэг ажлуудыг онцолж байна.



## Хүснэгт 6.1 Дээд боловсролын салбарын үндсэн үзүүлэлт, 2022/2023


Үзүүлэлт	Бүгд	Нийслэл	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Олон нийтийн/ шашны өмчийн
<b>СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА</b>						
<b>Нийт их, дээд сургууль, коллеж</b>	<b>69</b>	<b>64</b>	<b>5</b>	<b>16</b>	<b>50</b>	<b>3</b>
Үүнд: Коллеж	1	-	1	1	-	-
Дээд сургууль	35	31	4	5	28	2
Их сургууль	33	33	-	10	22	1
<b>Магадлан итгэмжлэгдсэн сургууль</b>	<b>59</b>	<b>57</b>	<b>2</b>	<b>12</b>	<b>44</b>	<b>3</b>
Үүнд: Коллеж	-	-	-	-	-	-
Дээд сургууль	29	27	2	2	25	2
Их сургууль	30	30	-	10	19	1
<b>СУРАЛЦАГЧ</b>						
<b>Нийт суралцагч</b>	<b>145,267</b>	<b>135,993</b>	<b>9,274</b>	<b>79,718</b>	<b>58,828</b>	<b>6,721</b>
Үүнээс: эрэгтэй	56,444	53,504	2,940	32,395	21,431	2,618
эмэгтэй	88,823	82,489	6,334	47,323	37,397	4,103
<b>Диплом</b>	<b>2,799</b>	<b>1,784</b>	<b>1,015</b>	<b>2,298</b>	<b>501</b>	<b>-</b>
Үүнээс: эрэгтэй	578	459	119	413	165	-
эмэгтэй	2,221	1,325	896	1,885	336	-
<b>Бакалавр</b>	<b>112,451</b>	<b>105,424</b>	<b>7,027</b>	<b>59,808</b>	<b>47,964</b>	<b>4,679</b>
Үүнээс: эрэгтэй	45,193	42,733	2,460	25,282	18,046	1,865
эмэгтэй	67,258	62,691	4,567	34,526	29,918	2,814
<b>Магистр</b>	<b>25,509</b>	<b>24,301</b>	<b>1,208</b>	<b>14,335</b>	<b>9,242</b>	<b>1,932</b>
Үүнээс: эрэгтэй	8,767	8,409	358	5,288	2,773	706
эмэгтэй	16,742	15,892	850	9,047	6,469	1,226
<b>Доктор</b>	<b>4,508</b>	<b>4,484</b>	<b>24</b>	<b>3,277</b>	<b>1,121</b>	<b>110</b>
Үүнээс: эрэгтэй	1,906	1,903	3	1,412	447	47
эмэгтэй	2,602	2,581	21	1,865	674	63
<b>ШИНЭЭР ЭЛСЭГЧ</b>						
<b>Нийт шинээр элсэгч</b>	<b>26,316</b>	<b>25,915</b>	<b>401</b>	<b>17,220</b>	<b>8,991</b>	<b>105</b>
Үүнээс: эрэгтэй	9,767	9,553	214	6,661	3,055	51
эмэгтэй	16,549	16,362	187	10,559	5,936	54
Диплом	346	346	-	210	136	-
Бакалавр	22,246	21,886	360	14,841	7,325	80
Магистр	3,367	3,326	41	1,884	1,458	25
Доктор	357	357	-	285	72	-
Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс шинээр элсэгч	19,835	19,532	303	14,096	5,683	56
Тухайн жилд мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс шинээр элсэгч	127	126	1	20	106	1

Үзүүлэлт	Бүгд	Нийслэл	Орон нутаг	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Олон нийтийн/шашны өмчийн
Тухайн жилд дипломын боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс шинээр элсэгч	196	194	2	96	99	1
Тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс шинээр элсэгч	5,076	4,982	94	2,137	2,893	46
Тухайн жилд магистрын боловсрол эзэмшсэн төгсөгчдөөс шинээр элсэгч	427	426	1	290	136	1
Бусад шинээр элсэгч	655	655	-	581	74	-
<b>БАГШ, АЖИЛЛАГЧИД</b>						
<b>Нийт багш, ажилтан</b>	<b>11,923</b>	<b>11,652</b>	<b>271</b>	<b>7,473</b>	<b>4,108</b>	<b>342</b>
Үүнээс: эрэгтэй	4,350	4,260	90	2,743	1,490	117
эмэгтэй	7,573	7,392	181	4,730	2,618	225
<b>Үндсэн багш</b>	<b>5,169</b>	<b>5,063</b>	<b>106</b>	<b>3,366</b>	<b>1,647</b>	<b>156</b>
Үүнээс: эрэгтэй	2,000	1,972	28	1,316	620	64
эмэгтэй	3,169	3,091	78	2,050	1,027	92

## 6.1 | ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын **69\*** байгууллагад **145,267** оюутан суралцаж, **11,923** багш, ажиллагчид ажиллаж байна.

**Зураг 6.1 Дээд боловсролын сургалтын байгууллага, хэв шинжээр**




Дээд боловсролын сургалтын **69** байгууллагаас **33** буюу **47.8** хувь нь их сургууль, **34** буюу **49.3** хувь нь дээд сургууль, **1** буюу **1.4** хувь нь коллеж, **1** буюу **1.4** хувь нь гадаадын их сургуулийн салбар сургууль байна.

\*Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн дээд сургуулийг шинээр, төрийн өмчийн 8 их, дээд сургууль, коллежийн ангилалыг өөрчлөн, нэгтгэн зохион байгуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн А/296 дугаар тушаалаар хувийн өмчийн 15 их, дээд сургууль, коллежийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.



**Зураг 6.2 Дээд боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэрээр**



Их дээд сургууль, коллежийн **50** буюу **72.5** хувь нь хувийн өмчийн, **16** буюу **23.2** хувь нь төрийн өмчийн, **3** буюу **4.3** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургууль байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын **64** буюу **92.8** хувь нь Улаанбаатар хотод, **5** буюу **7.2** хувь нь орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

**Хүснэгт 6.2 Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор шинээр байгуулагдсан, харьяалал, ангилал нь өөрчлөгдсөн, их сургуулиудын бүрэлдэхүүнд нэгтгэсэн сургалтын байгууллагууд**

Сургалтын байгууллагын нэр	Өөрчлөлт
Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн дээд сургууль /Өмнөговь аймаг/	Шинээр байгуулагдсан
Ховд Их сургууль	Монгол Улсын Их Сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль
Дорнод их сургууль	Монгол Улсын Их Сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургууль
Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль
Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль
Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургууль	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль
Улаанбаатарын Их Сургууль	Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн сургууль
Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн сургууль
"Дүрслэх урлагийн академи" дээд сургууль	Соёл Урлагийн Их Сургуулийн бүрэлдэхүүн сургууль
Соёл урлагийн их сургуулийн Завхан аймаг дахь салбар сургууль	Монгол Улсын консерваторийн харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж
Монгол Улсын их сургуулийн Орхон аймаг дахь салбар сургууль	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургуульд нэгтгэсэн.

**Хүснэгт 6.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагууд, өмчийн хэлбэрээр**

Төрийн өмчийн	Хувийн өмчийн
1. Монгол Улсын консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж	1. Дархан дээд сургууль (Дархан-Уул)
2. ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль	
3. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль	

**Хүснэгт 6.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын салбар болон бүрэлдэхүүн сургуулиуд, аймгаар, 2022/2023**

Аймаг	№	Салбар сургууль
Архангай аймаг	1	МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар
Баян-Өлгий аймаг	2	МУБИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль
Баянхонгор аймаг	3	ХААИС-ийн Баянхонгор аймаг дахь салбар сургууль
Говь-Алтай аймаг	4	АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар
Дархан-Уул аймаг	5	АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар
	6	ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар
	7	ХААИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургууль
	8	Их засаг олон улсын их сургуулийн салбар
	9	Мандах их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар
	10	Дархан дээд сургууль
Дорноговь аймаг	11	АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар
Дорнод аймаг	12	МУИС-ийн Дорнод аймаг дахь салбар сургууль
Завхан аймаг	13	МУИС-ийн Завхан аймаг дахь салбар
Орхон аймаг	14	Улаанбаатар Эрдэм их сургуулийн Орхон аймаг дахь салбар сургууль / Маргад/
	15	Этүгэн их сургуулийн Орхон аймаг дахь салбар
Увс аймаг	16	Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн Увс аймаг дахь Хөдөлмөрийн дээд сургууль
Ховд аймаг	17	МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургууль

**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨР 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БАЙДЛААР**

Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж буй нийт их, дээд сургууль, коллежийн **59** буюу **85.5** хувь нь магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 2022 онд хувийн өмчийн **6** сургууль шинээр магадлан итгэмжлэлд хамрагдсан байна. Нийт магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын **30** буюу **43.5** хувь нь их сургууль, **29** буюу **42.0** хувь нь дээд сургууль байна.

• **Олон улсын магадлан итгэмжлэлд:**


**16** сургуулийн **108** хөтөлбөр, 2022 онд шинээр нэмэгдсэн **1** сургуулийн **3** хөтөлбөр;

• **Дотоодын магадлан итгэмжлэлд:**

**34** сургуулийн **283** хөтөлбөр, 2022 онд шинээр нэмэгдсэн **12** сургуулийн **40** хөтөлбөр;

• **Урьдчилсан магадлан итгэмжлэлд:**

**40** сургуулийн **182** хөтөлбөр, 2022 онд шинээр **16** сургуулийн **24** хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна.



## 6.2 | ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД

### Хүснэгт 6.5 Нийт суралцагчид, боловсролын зэрэг, хүйсээр


Үзүүлэлт	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
<b>Нийт суралцагч</b>	<b>148,446</b>	<b>147,293</b>	<b>148,954</b>	<b>145,267</b>
Үүнээс: Эмэгтэй	90,573	89,463	91,034	88,823
Эрэгтэй	57,873	57,830	57,920	56,444
<b>Диплом</b>	<b>98</b>	<b>124</b>	<b>3,155</b>	<b>2,799</b>
Үүнээс: Эмэгтэй	14	17	2,519	578
Эрэгтэй	84	107	636	2,221
<b>Бакалавр</b>	<b>119,203</b>	<b>119,108</b>	<b>117,037</b>	<b>112,451</b>
Үүнээс: Эмэгтэй	71,622	71,375	69,803	67,258
Эрэгтэй	47,581	47,733	47,234	45,193
<b>Магистр</b>	<b>25,753</b>	<b>24,813</b>	<b>25,300</b>	<b>25,509</b>
Үүнээс: Эмэгтэй	17,066	16,291	16,717	16,742
Эрэгтэй	8,687	8,522	8,583	8,767
<b>Доктор</b>	<b>3,392</b>	<b>3,248</b>	<b>3,462</b>	<b>4,508</b>
Үүнээс: Эмэгтэй	1,871	1,780	1,995	2,602
Эрэгтэй	1,521	1,468	1,467	1,906

Дээд боловсролын сургалтын байгууллагад нийт **145,267** оюутан суралцаж байгаа нь өмнөх оны хичээлийн жилээс **3,687** буюу **2.5** хувиар буурсан байна.

Суралцагчдыг өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад дипломын боловсролд суралцагчид **356**-аар, бакалаврын зэрэгт суралцагчид **4,586**-аар буурсан бол магистрантурт суралцагчдын тоо **209**-өөр, докторантурт суралцагчдын тоо **1,046**-аар тус тус өссөн байна.



### Зураг 6.3 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, боловсролын түвшнээр






## 6. ДЭЭД БОЛОВСРОЛ

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, нийт суралцагчдын **2,799** буюу **1.9** хувь нь диплом, **112,451** буюу **77.4** хувь нь бакалавр, **25,509** буюу **17.6** хувь нь магистр, **4,508** буюу **3.1** хувь нь докторын хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байна.

Засгийн Газрын 2022 оны 293 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/296 дугаар тушаалаар төрийн өмчийн зарим их, дээд сургууль, коллежийн ангилалыг өөрчлөн, нэгтгэн зохион байгуулах, хувийн өмчийн их, дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор нийт суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилийн нийт суралцагчдын тооноос **3,687**-оор буурсан байна.




**Зураг 6.4 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйсээр**



Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын **88,823** буюу **61.1** хувь нь эмэгтэй, **56,444** буюу **38.9** хувь нь эрэгтэй байна.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй суралцагч тутам ногдох эмэгтэй суралцагчийн тоо **157** буюу өнгөрсөн хичээлийн жилээс уг индекс өөрчлөгдөөгүй байна.

**Зураг 6.5 Дээд боловсролын салбарт суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлын индекс, хувиар**




### Хүснэгт 6.6 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, сургуулийн хэв шинжээр



	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
Дээд сургууль	20,412	16,408	15,688	12,528
Коллеж	289	141	224	33
Их сургууль	127,555	130,510	132,808	132,595
Гадаад салбар сургууль	190	234	234	111
<b>Нийт суралцагч</b>	<b>148,446</b>	<b>147,293</b>	<b>148,954</b>	<b>145,267</b>

Нийт суралцагчдын **132,595** буюу **91.3** хувь нь их сургуульд, **12,528** буюу **8.6** хувь нь дээд сургуульд, **33** нь коллежид суралцаж байгаа бол **111** нь буюу **0.1** хувь нь гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцаж байна.

### Зураг 6.6 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, өмчийн хэлбэрээр




Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2022-2023 оны хичээлийн жилд нийт суралцагчдын **79,718** буюу **54.9** хувь төрийн өмчийн, **58,828** буюу **40.5** хувь нь хувийн өмчийн, **6,721** буюу **4.6** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын **135,993** буюу **93.6** хувь нь Улаанбаатар хотод, **9,274** буюу **6.4** хувь нь орон нутагт суралцаж байна.

Аймгаар авч үзвэл, 2022-2023 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай нь Дархан-Уул аймаг **3,653** буюу нийт суралцагчдын **2.5** хувийг, хамгийн цөөн суралцагчтай нь Хэнтий аймаг **30** суралцагчтай байна.



Зураг 6.7 Нийт суралцагчид, сургуулийн байршлаар /салбар сургууль/ 2022/2023



Монгол Улсын хүн амын 18-24 насны нийт хүн ам **317,376** байгаагийн **112,451** буюу **35.4** хувь нь бакалаврын боловсролд суралцагчид байна.

Тайлбар: ҮСХ-ны 2021 оны суурин хүн амын тоог нас дэвшүүлэх аргачлалаар тооцсон. Олон улсад бакалаврын зэргийн боловсрол олгох насны бүлгийг 18-24 нас гэж үздэг.

**Эх үүсвэр:** Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтоос, OECD iLibrary (oecd-ilibrary.org)

Хүснэгт 6.7 Нийт суралцагчид, боловсролын түвшин, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, 2022/2023

Мэргэжлийн ерөнхий чиглэл	Нийт суралцагчид	Дипломын боловсрол	Бакалаврын боловсрол	Магистрын боловсрол	Докторын боловсрол
<b>Нийт суралцагчид</b>	<b>145,267</b>	<b>2,799</b>	<b>112,451</b>	<b>25,509</b>	<b>4,508</b>
Боловсрол	18,053	-	12,431	4,816	806
Урлаг, хүмүүнлэг	10,950	-	8,903	1,220	827
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	9,001	-	7,319	1,315	367
Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	41,008	-	29,341	10,591	1,076
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3,434	-	2,307	814	313
Мэдээлэл, харилцааны технологи	7,000	-	6,639	337	24
Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт	18,184	191	16,050	1,738	205
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	2,229	-	1,208	824	197
Эрүүл мэнд, нийгмийн халамж	26,058	2,608	19,884	3,277	289
Үйлчилгээ	6,252	-	5,271	577	404
Ерөнхий суурь хөтөлбөр	3,098	-	3,098	-	-

**Зураг 6.8 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэл, нийт суралцагчдын тоонд эзлэх хувь, 2022/2023**




● Эрэгтэй ● Эмэгтэй




Нийт суралцагчдыг мэргэжлийн ерөнхий чиглэлээр авч үзвэл 2022-2023 оны хичээлийн жилд **41,008** буюу **28.2** хувийг бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн мэргэжлийн чиглэлд хамгийн олон суралцагч, нийт суралцагчийн **2.229** буюу **1.5** хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгийн салбарын мэргэжлийг хамгийн цөөн тооны суралцагч сонгон суралцаж байна.

**Зураг 6.9 Багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын сургалтын байгууллага, өмчийн хэлбэрээр, 2022/2023**



Нийт **34** сургууль (төрийн өмчийн-**5**, хувийн өмчийн-**29** сургууль) 2022-2023 оны хичээлийн жилд багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж тэдгээрт нийт **13,471** оюутан суралцаж байгаа нь нийт суралцагчдын **9.3** хувийг эзэлж байна.

**Зураг 6.10 Дотуур байранд амьдарч буй нийт суралцагч, хүйс, дотуур байрын хангалтын хувь, 2022/2023**



## 6. ДЭЭД БОЛОВСРОЛ

Дотуур байранд амьдарч байгаа нийт суралцагчдын **6,145** буюу **95.4** хувь нь бакалаврын боловсролын хөтөлбөрөөр суралцагчид, **229** буюу **3.5** хувь нь дипломын боловсролын хөтөлбөрөөр суралцагчид байна.


**Зураг 6.11 Монгол Улсад суралцаж буй нийт гадаад оюутан, улсаар, дүнд эзлэх хувиар, 2022/2023**



Монгол Улсын их, дээд сургууль, коллежид нийт **3,593** гадаад оюутан суралцаж байгаагаас хамгийн их буюу **87.7** хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын оюутнууд эзэлж байна.


## 6.3 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭЛСЭГЧИД

**Зураг 6.12 Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид, хүйсээр**



Элсэгчид 2022-2023 оны хичээлийн жилд **26,316** болж өмнөх оны хичээлийн жилээс **4,229**-өөр буурсан ба шинээр элсэгчдийн **62.9** хувь нь эмэгтэй суралцагч, **37.1** хувийг эрэгтэй суралцагчид эзэлж байна.

**Зураг 6.13 Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид, тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс элссэн байдал**



Элсэгчдийн дотор тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь 2022-2023 оны хичээлийн жилд **75.4** хувь болж, өмнөх жилээс **7.2** пунктээр буурсан байна.

Тухайн жилд буюу 2022 онд бүрэн дунд боловсрол эзэмшигчид **32,908** байгаагийн **60.3** хувь нь дээд боловсролын хөтөлбөрт элсэн суралцаж байна.



#### **Хүснэгт 6.8 Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчид, 2022/2023 он**


	Элсэгчид	Эзлэх хувь
Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс	19,835	75.4
Тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшигчдээс	5,076	19.3
Тухайн жилд мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшигчдээс	127	0.5
Ажиллагчдаас	537	2.0
Ажилгүй иргэдээс	2	0.07
Бусад	739	2.8

2022-2023 оны хичээлийн жилд элсэгчдийн **19,835** буюу **75.4** хувь нь тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс, **5,076** буюу **19.3** хувь нь тухайн жилд бакалаврын боловсрол эзэмшигчдээс, **537** буюу **2.0** хувь нь ажиллагчдаас, **127** буюу **0.5** хувь нь тухайн жилд мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшигчдээс тус тус элссэн байна.



## 6.4 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧИД

Зураг 6.14 Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид, хүйсээр



Их, дээд сургуулийг 2021-2022 оны хичээлийн жилд **32,925** суралцагч төгсөж өмнөх оны хичээлийн жилээс **1,764** буюу **5.6** хувиар өссөн бөгөөд нийт төгсөгчдийн **21,122** буюу **64.2** хувь нь эмэгтэй, **11,803** буюу **35.8** хувь нь эрэгтэй төгсөгчид байна.

Хүснэгт 6.9 Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид, боловсролын зэргээр, 2019-2022 он

	2019/2020	2020/2021	2021/2022
<b>Нийт төгсөгч</b>	<b>28,045</b>	<b>31,161</b>	<b>32,925</b>
Дипломын дээд	268	117	627
Бакалавр	23,081	25,727	26,240
Магистр	4,531	5,273	5,954
Доктор	165	44	104

Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2021-2022 оны хичээлийн жилд **26,240** буюу **79.7** хувь нь бакалавр, **5,954** буюу **18.1** хувь нь магистр, **627** буюу **1.9** хувь нь диплом, **104** буюу **0.3** хувь нь докторын зэрэг эзэмшсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн 2022 оны III улирлын тойм мэдээнээс харахад ажил хайж байгаа иргэдийн тоо **19.8** мянга байгаагийн **2.8** мянга нь буюу **14.1** хувь нь 15-24 насны, **7.4** мянга буюу **37.3** хувь нь 25-34 насны, **5.5** мянга буюу **27.9** хувь нь 35-44 насны, **4.0** мянга буюу **20.7** хувь нь 45, түүнээс дээш насныхан тус тус эзэлж байгаагаас эдгээр ажил хайгчдын **5.6** хувь нь Мэргэжлийн болон техникийн, **29.3** дипломын дээд болон бакалавр, **1.0** хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.\*

**Эх үүсвэр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтууд эрхлэн гаргасан "Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал" 37 дугаар нүүр хуудас




**Зураг 6.15 Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, 2021/2022**



Дээд боловсролын сургалтын байгууллагыг 2021-2022 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн хамгийн их нь буюу **10,506** буюу **31.9** хувь нь бизнес, удирдлага, эрх зүйн салбарын мэргэжлүүдээр, хамгийн бага нь буюу **348** буюу **1.1** хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй салбарын мэргэжлүүдээр төгссөн байна.

Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, Мэдээлэл, харилцаа холбооны технологи, үйлчилгээний салбарын мэргэжлүүдээр эрэгтэйчүүд илүү төгссөн бол Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй, урлаг, хүмүүнлэг, соёл урлаг болон бусад мэргэжлээр эмэгтэйчүүд илүү төгссөн байна.

**Зураг 6.16 Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт төгсөгчдийн хүйс, мэргэжлийн ерөнхий чиглэл, дүнд эзлэх хувиар, 2021/2022**





## 6.5 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ, АЖИЛЛАГЧИД


Хүснэгт 6.10 Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш, ажиллагчид, хүйсээр

	2019/2020	2020/2021	2021/2022	2022/2023
<b>Нийт ажиллагчид</b>	<b>11,306</b>	<b>11,970</b>	<b>12,175</b>	<b>11,923</b>
Үүнээс: Эмэгтэй	7,061	7,505	7,688	7,573
Эрэгтэй	4,245	4,465	4,487	4,350
<b>Үндсэн багш</b>	<b>7,315</b>	<b>7,143</b>	<b>6,102</b>	<b>5,169</b>
Үүнээс: Эмэгтэй	4,482	4,314	3,740	3,169
Эрэгтэй	2,833	2,829	2,362	2,000
<b>Нийт ажиллагчдын дүнд үндсэн багшийн эзлэх хувь</b>	<b>64.7</b>	<b>59.7</b>	<b>50.1</b>	<b>43.4</b>




Их, дээд сургууль, коллежийн ажиллагчид 2022-2023 оны хичээлийн жилд **11,923** болж өмнөх оны хичээлийн жилээс **252** буюу **2.1** хувиар буурсан байна. 2022-2023 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагын нийт ажилтны **7,573** буюу **63.5** хувь нь эмэгтэй, **4,350** буюу **36.5** хувь нь эрэгтэй байна.

Зураг 6.17 Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, ажиллагчид, өмчийн хэлбэрээр, 2022/2023



● Төрийн өмчийн

● Хувийн өмчийн




● Олон нийтийн/шашны өмчийн

Өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2022-2023 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт ажиллагчдын **7,473** буюу **62.7** хувь нь төрийн өмчийн сургуульд, **4,108** буюу **34.5** хувь нь хувийн өмчийн сургуульд, **342** буюу **2.9** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.


Өмчийн хэлбэрээр авч үзвэл харахад, 2022-2023 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт үндсэн багшийн **3,366** буюу **65.1** хувь нь төрийн өмчийн сургуульд, **1,647** буюу **31.9** хувь нь хувийн өмчийн сургуульд, **156** буюу **3.0** хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд ажиллаж байна.

**Зураг 6.18 Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, боловсролын түвшнээр, 2022/2023**



Их, дээд сургууль, коллежид ажиллаж буй үндсэн багшийн **2,570** буюу **49.7** хувь нь магистр, **2,257** буюу **43.7** хувь нь доктор, **339** буюу **6.6** хувь нь бакалавр, **3** буюу **0.1** хувь нь дипломын боловсролтой байна.

**Зураг 6.19 Дээд боловсролын сургалтын байгууллагын нийт үндсэн багш, нас хүйсийн суварга, дүнд эзлэх хувь**



Нийт **5,169** үндсэн багш ажиллаж байгаагийн **3,169** буюу **61.3** хувь нь эмэгтэй, **2,000** буюу **38.7** хувь нь эрэгтэй байна.

Насны хувьд үндсэн багшийн **352** буюу **6.8** хувь нь **30** хүртэлх насны, **1,658** буюу **32.1** хувь нь 30-40 насны, **1,731** буюу **33.5** хувь нь 40-50 насны, **963** буюу **18.6** хувь нь 50-60 насны, **465** буюу **9.0** хувь нь **60** ба түүнээс дээш насны багш нар тус тус эзэлж байна.

Улсад ажилласан жилээр нь үндсэн багш нарыг ангилж үзэхэд **38.9** хувь нь 1-5 жил, **17.0** хувь нь 6-10 жил, **15.1** хувь нь 11-15 жил, **13.6** хувь нь 16-20 жил, **15.4** хувь нь **21** болон түүнээс дээш жил ажиллаж байгаа үндсэн багш нар байна.



Их, дээд сургууль, коллежид ажиллаж буй үндсэн багш 2022-2023 оны хичээлийн жилд **5,169** болж өмнөх хичээлийн жилээс **933** буюу **15.3** хувиар буурсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор төрийн өмчийн **1** сургууль шинээр байгуулагдаж, **10** их, дээд сургууль, коллежийн ангилалыг өөрчлөн, нэгтгэн зохион байгуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/296 дугаар тушаалаар хувийн өмчийн **15** их, дээд сургууль, коллежийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн багш **403**, хувийн өмчийн их, дээд сургуулийн багш **530**-аар буурсан байна.






**07**

## **ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР**

---



## САЛБАРЫН ОНЦЛОГ: ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР

**“Алсын хараа-2050”** хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор шинжлэх ухаан, технологийн салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх, орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал:

- Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлж, тогтмол санхүүжилт олгох, төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцох замаар өрсөлдөөнт санхүүжилтэд хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр судалгааны чанар, хүртээмж нэмэгдэж, улмаар эдийн засгийн үр ашиг дээшлэх нөхцөл бүрдсэн.
- Олон улсын стандартад нийцсэн судалгааны орчин бүхий дэд бүтцийг бүрдүүлэх ажлын хүрээнд Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, Шинжлэх ухаан, технологийн парк, салбар дундын ашиглалтын нээлттэй лаборатори байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.
- Шинжлэх ухаан, технологийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр MORI нээлттэй цахим платформыг бий болгох ажлыг эхлүүлж, шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан иргэд, олон нийтэд салбарын тоо, баримтад түшиглэсэн үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэх зэрэг томоохон арга хэмжээг 2023 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөд байна.



# 7.1 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГЫН ТОО, АЖИЛЛАГЧИД


## Хүснэгт 7.1 Шинжлэх ухаан, технологийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021 <sup>2</sup>	2021/2017 Өсөлт, бууралт, /дахин их, бага/
Шинжлэх ухааны байгууллагын тоо	60	59	62	68	69	1.2▲
Нийт ажиллагчид	4,534	4,277	4,254	6,926	7,072	1.6▲
Үүнээс: Эмэгтэй	2,430	2,240	2,126	3,973	4,150	1.7▲
Эрэгтэй	2,104	2,037	2,128	2,953	2,922	1.4▲
Шинжлэх ухааны байгууллагын эрдмийн зэрэг, цолтой нийт үндсэн ажиллагчид	3,482	3,246	3,352	6,109	5,907	1.7▲
Үүнээс: Эмэгтэй	1,932	1,565	1,700	3,573	3,570	1.8▲
Эрэгтэй	1,550	1,681	1,652	2,536	2,337	1.5▲
Шинжлэх ухааны доктор	130	109	136	153	133	1.0▲
Боловсролын доктор	797	706	657	1,697	2,000	2.5▲
Академич	46	56	38	64	57	1.2▲
Профессор	221	157	136	369	436	2.0▲
Дэд профессор	239	187	166	564	666	2.8▲
Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил	276	320	309	353	456	1.7▲
Суурь судалгааны ажил	94	131	94	265	393	4.2▲
Хэрэглээний судалгааны ажил	169	189	215	78	47	-0.3▼
Туршилт, хөгжүүлэлтийн ажил	13	-	-	10	16	1.2▲

<sup>2</sup>Шинжлэх ухаан, технологийн салбарын 2021 оны захиргааны статистик мэдээгээр гарсан үр дүн

Шинжлэх ухаан, технологийн салбарт 2017 онд **60** байгууллагын **4,534** ажиллагч ажиллаж байсан бол 2021 онд нийт байгууллага **69** болж, ажиллагчид **2,538 (1.6 дахин)**-аар нэмэгдэж, **7,072** болсон байна.

### Зураг 7.1 Шинжлэх ухаан, технологийн салбарын байгууллага, ажиллагчид



2021 оны байдлаар шинжлэх ухаан технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм, шинжилгээний **69** байгууллагын **55 (79.7%)** нь төрийн өмчийн, **14 (20.3%)** нь хувийн өмчийн байгууллага байна.

Харин эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага **37 (53.6%)** байна.

## 7. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР

Шинжлэх ухаан, технологийн салбарын ажиллагчид 2021 оны байдлаар нийт **7,072** байгаагийн **4,150 (58.7%)** нь эмэгтэй, **5,907 (83.5%)** нь үндсэн, **5,085 (71.9%)** нь судлаачид байна. Нийт судлаачдын **1,865 (36.7%)** нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Нийт ажиллагчдад шинжлэх ухааны доктор **133**, боловсролын доктор **2,000**, академич **57**, профессор **436**, дэд профессор **666** байна.





### Хүснэгт 7.2 Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Шинжлэх ухааны доктор	130	109	136	153	133
Боловсролын доктор	797	706	657	1,697	2,000
Академич	46	56	38	64	57
Профессор	221	157	136	369	436
Дэд профессор	239	187	166	564	666



2017 онд нийт ажиллагчдын **17.6** хувь нь боловсролын доктор зэрэгтэй ажиллагчид байсан бол 2021 онд **28.3** хувь болж өссөн байна.

### Зураг 7.2 Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчдын нийт ажиллагчдад эзлэх хувь /2017, 2021 оны харьцуулалт/



● Дэд профессор ● Профессор ● Академич ● Боловсролын доктор ● Шинжлэх ухааны доктор

**Тайлбар:** ШУТ-ийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт, аргачлал 2020 онд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Шинжлэх ухааны байгууллагын эрдмийн зэрэг, цолтой нийт ажиллагчид гэсэн үзүүлэлтээр мэдээллийг цуглуулсан.

Шинжлэх ухааны доктор зэрэгтэй ажиллагчдын эзлэх хувь 2017 оноос 2021 онд **1** пунктээр, академич зэрэгтэй ажиллагчдын эзлэх хувь **0.2** пунктээр тус тус буурчээ. Харин профессор, дэд профессор, боловсролын доктор зэрэгтэй ажиллагчдын эзлэх хувь **1.3-10.7** пунктээр нэмэгдсэн байна.



## 7.2 ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ


Шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардал 2020 онд **50.8<sup>3</sup>** тэрбум төгрөг байсан бол 2021 онд **48.2<sup>4</sup>** тэрбум төгрөг болж, 2.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2019 оноос өмнө Шинжлэх ухааны салбарын нийт зардал нь зөвхөн улсын төсвөөс зарцуулсан зардлыг илэрхийлэх бөгөөд урсгал зардал орсон дүн болно. Харин ШУТ-ийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт, аргачлал 2020 онд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардал нь судалгаа хөгжүүлэлтийн ажлын, судалгаа хөгжүүлэлтийн ажилд шууд хамааралгүй шинжлэх ухаан, технологийн үйлчилгээний ажлын болон шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны нийт дүнгийн нийлбэрээр тодорхойлогдох болсон.

<sup>3</sup> Шинжлэх ухаан, технологийн салбарын 2020 оны захиргааны статистик мэдээгээр гарсан үр дүн

<sup>4</sup> Шинжлэх ухаан, технологийн салбарын 2021 оны захиргааны статистик мэдээгээр гарсан үр дүн



**Зураг 7.3 Шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардал, зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар**



Шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардалд байгалийн шинжлэх ухааны салбарын зардал 2020 онд **20.8** хувийг эзэлж байсан бол 2021 онд хамгийн өндөр буюу **40.1** хувийг, инженерчлэл болон технологийн шинжлэх ухаан 2020 онд хамгийн өндөр буюу **33.3** хувийг эзэлж байсан бол 2021 онд **7.0** хувийг эзэлж байна. Гол мөрөн, нуур цөөрөм, загасны чиглэлийн судалгааны чиглэлээр 2020 онд нийт зардлын **0.1** хувийг зарцуулж байсан бол 2021 онд уг салбарт чиглэсэн ажил хийгдээгүй байна.

2021 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардлын **19.3 (40.1%)** тэрбум төгрөг нь байгалийн, **15.7 (32.6%)** тэрбум төгрөг нь нийгмийн, **4.6 (9.6%)** тэрбум төгрөг нь анагаах ухааны, **3.5 (7.3%)** тэрбум төгрөг нь хөдөө аж ахуйн, **3.4 (7.0%)** тэрбум төгрөг нь инженерчлэл болон технологийн, **1.7 (3.5%)** тэрбум төгрөг нь хүмүүнлэг болон урлагийн шинжлэх ухааны салбарт тус тус ногдож байна.



## 7.3 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын нийт үр дүн 2017 онд **10,980** байсан бол 2021 онд **469 (4.3%)**-иар өсөж, **11,449** болсон байна. Үр дүнг харахад хэрэглэгч, захиалагчид хүлээлгэн өгсөн нийт үр дүн 2017 онд **769** байсан бол 2021 онд **957** болж **188**-аар өсөж, нийт хэвлүүлсэн бүтээл 2016 онд **9,972** байсан бол 2021 онд **10,089** болж **117**-оор өсч, патент 2017 онд **88** байсан бол 2021 онд **123** болж **35**-аар өссөн байна. Харин зохиогчийн эрхийн гэрчилгээ 2017 онд **151** байсан бол 2021 онд **256** болж **105**-аар өссөн байна. 2021 онд лицензийн гэрээ, гарааны компани байгуулагдаагүй байна.




**Хүснэгт 7.3 Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүн**

Үзүүлэлт		2017	2018	2019	2020	2021
<b>Нийт</b>		<b>10,980</b>	<b>9,543</b>	<b>8,524</b>	<b>13,325</b>	<b>11,449</b>
Хэрэглэгч, захиалагчид хүлээлгэн өгсөн үр дүнгээр	<b>Бүгд</b>	<b>769</b>	<b>936</b>	<b>716</b>	<b>1,858</b>	<b>957</b>
	Шинэ технологи	62	37	33	64	35
	Шинэ биет бүтээгдэхүүн	223	33	83	84	76
	Шинэ онол теором	-	-	-	1	2
	Зураг, каталоги	116	338	218	191	90
	Аргачлал, заавар, зөвлөмж	106	232	180	741	239
	Жор, үнэлгээ	8	4	8	46	22
	Стандарт	75	71	70	193	118
	Тоног төхөөрөмжийн туршилтын загвар	-	-	-	24	9
	Үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг	-	-	-	39	41
Бусад /тайлан, диссертац/	179	221	124	475	325	
Нийт хэвлүүлсэн бүтээлээр	<b>Бүгд</b>	<b>9,972</b>	<b>8,468</b>	<b>7,661</b>	<b>11,033</b>	<b>10,089</b>
	Ном, монограф буюу нэг сэдэвт бүтээл	961	835	891	907	712
	Эрдэм шинжилгээний өгүүлэл	4,517	3,858	3,344	5,517	4,773
	Дотоодод хэвлүүлсэн	7,657	6,638	6,227	3,978	3,200
	Импакт фактор өндөртэй эрдэм, шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн	-	-	-	334	510
	Бусад	-	-	-	3,644	2,690
	Гадаадад хэвлүүлсэн	2,315	1,830	1,434	1,539	1,573
	Импакт фактор өндөртэй эрдэм, шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн	-	-	-	693	743
	Бусад	-	-	-	846	830
	Хэлэлцүүлсэн илтгэл	4,494	3,775	3,426	3,982	3,919
<b>Бусад</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>627</b>	<b>685</b>	
Патентаар	Бүгд	88	48	60	133	123
	Шинэ бүтээл	22	10	23	46	73
	Бүтээгдэхүүний загвар	-	-	-	3	14
	Ашигтай загвар	66	38	37	84	36
Оюуны өмчийн гэрчилгээ	<b>Бүгд</b>	<b>151</b>	<b>91</b>	<b>87</b>	<b>301</b>	<b>280</b>
	Барааны тэмдэгийн эрхийн хамгаалалт	-	-	-	57	23
	Зохиогчийн эрхийн гэрчилгээ	151	91	87	243	256
	Газарзүйн заалтын эрхийн хамгаалалт	-	-	-	1	1
Лицензийн гэрээ	-	-	-	2	-	
Үүсгэн байгуулсан гарааны компани	-	-	-	4	-	


# 7.4 | МОНГОЛ ЭРДЭМТДИЙН БҮТЭЭЛ ОЛОН УЛСАД

**Зураг 7.4** Импакт фактор өндөртэй олон улсын сэтгүүлд монгол эрдэмтдийн хэвлүүлсэн бүтээлийн тоо, сонгогдсон оноор



Импакт фактор өндөртэй олон улсын сэтгүүл, "Nature", "Cell", "Science" зэрэг эрдэм, шинжилгээний сэтгүүлд **681** бүтээл, "Scopus" мэдээллийн санд Монгол Улсын бүртгэлтэй нийт **887** бүтээл тус тус хэвлүүлж, Монголын эрдэмтдийн бүтээл "Dimensions" мэдээллийн санд 2022 онд нийт **20,424** удаа эшлэгдсэн.

**Зураг 7.5** "Web of Science" мэдээллийн санд Шинжлэх ухааны академи, төрийн өмчийн их, дээд сургуулийн эрдэмтдийн хэвлүүлсэн бүтээлийн тоо, сонгогдсон оноор



АНУ-ын Clarivate Analytics компанийн Web of Science группийн мэдээллийн санд 1967 онд Монгол улсаас анхны эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгдэж байсан бол 2022 оны 11-р сарын байдлаар Монгол улсаас 7282 бүтээл нийтлэгдэж тэдгээрээс 108572 удаа эшлэл авч, h-индекс нь 118 хүрээд байна. Монгол улсаас тус мэдээллийн санд бүртгэлтэй шинжлэх ухааны үндсэн 6-н байгууллагаас хэвлэгдэж байгаа бүтээлүүд **70-88** хувийг эзэлж байна.


**Хүснэгт 7.4 "Scopus" мэдээллийн санд бүртгэлтэй эшлэлийн тоо, байгууллагаар**

	<2018	2018	2019	2020	2021	2022	>2022	Дүн
Монгол	55,642	10,077	11,740	13,959	17,698	16,997	164	126,277
ШУА	2,219	3,715	4,150	4,719	5,964	5,167	41	25,975
МУИС	6,258	1,394	1,763	2,303	3,043	3,001	46	17,808
АШУУИС	3,969	1,208	1,438	1,754	2,278	2,366	13	13,026
ШУТИС	2,218	560	650	795	1,067	1,170	25	6,485
ХААИС	1,698	345	417	483	637	568	10	4,158
МУБИС	235	61	73	123	227	243	2	964

1957 онд Монгол улсаас анхны эрдэм шинжилгээний бүтээл нь тус дэлхийн хүлээн зөвшөөрөгдсөн Scopus мэдээллийн санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгдэж байсан. 2022 оны 11-р сарын байдлаар манай улсаас хэвлэгдсэн нийт бүтээлийн тоо 8028-д хүрсэн байна. Үүнийг байгууллагаар нь гаргавал **ШУА - 1961, МУИС - 1795, АШУУИС - 717, ШУТИС - 820, ХААИС - 318, МУБИС - 162**, үүнээс авсан нийт эшлэлийн тоо 126277, h-индекс - 126 тус бүр хүрээд байна.

Байгууллагуудын h-индекс нь ШУА - 88, МУИС - 53, АШУУИС - 46, ШУТИС - 40, ХААИС - 32, МУБИС – 15 тус бүр хүрсэн байна.

**Зураг 7.6 Дижитал шинжлэх ухаан, технологийн "Digital Dimension" компанийн мэдээллийн сан, улс орнуудаар**



Дижитал шинжлэх ухаан, технологийн компанийн "**Dimensions**" мэдээллийн сан нь эрдэм шинжилгээний бүтээл, эмнэл зүйн туршилт, патент, бодлогын баримт бичиг, судалгааны төсөл зэрэг төрөл бүрээр анализ хийх боломжтой.

Тус мэдээллийн санд Монгол улсаас эрдэм шинжилгээний **бүтээл-8770, патент-258, эмнэл зүйн туршилт-36, дата өгөгдөл-952, төсөл-97** тус бүр бүртгэлтэй байна.

### СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ - СОНИРХОЛТОЙ БАРИМТ

1. ЭЗХАХБ (ОЕСД)-ын гишүүн 21 орны 1990-2010 оны өгөгдлийг ашигласан дүн шинжилгээний үр дүнд судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг **1%**-иар нэмэгдүүлэхэд **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ 0.77%**-аар нэмэгдэнэ гэсэн тооцоолол гаргасан байна.
2. Судалгаа, хөгжүүлэлтийн зардал **ДНБ-д** богино ба урт хугацаанд эергээр нөлөөлнө. Урт хугацааны нөлөө нь богино хугацааны нөлөөнөөсөө их байна. 1 хүнд ногдох судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг **1%**-иар өсгөхөд ДНБ богино хугацаанд **0.44%**-иар, урт хугацаанд **0.98%**-иар өснө.
3. Судалгаа, хөгжүүлэлтийн зардал **ДНБ-ийн** өсөлтөд эерэг хамааралтай ба тухайн улс орны хөгжлийн түвшингөөс үл хамааран ойролцоогоор **1** ба **1**-ийн харьцаатай байна. Гэхдээ богино хугацаанд тухайн улсын хөгжлийн түвшингөөс хамаараад өөр өөр үр дүн үзүүлнэ.
4. Судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулж буй **ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ 10%**-иар нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт **4%**-иар нэмэгддэг байна. Өсөлтийн хувь улс орнуудын хувьд харилцан адилгүй боловч улсын хөрөнгө оруулалт хувийн хөрөнгө оруулалт хоёр шууд, эерэг хамааралтай.
5. Бизнесийн байгууллагууд богино хугацаанд их ашиг өгөх судалгаа, хөгжүүлэлтийн төслүүдэд хөрөнгө оруулах сонирхолтой байдаг. Иймд суурь судалгаа болон хэрэглээний судалгаа орхигдох хандлагатай байдаг тул **төр хөрөнгө оруулалтаар дэмжих шаардлагатай.**
6. Судалгаа, хөгжүүлэлтийн нийгмийн үр өгөөж нь судалгаа, хөгжүүлэлтийн хувийн ашгийн үр өгөөжөөс өндөр байдаг. Суурь судалгааны бүтээмж, нийгмийн үр өгөөж нь хэрэглээний болоод туршилт хөгжүүлэлтийн үр өгөөжөөс **илүү өндөр** байсан.




## 7.5 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Монгол Улсын засгийн газраас Шинжлэх ухаан, технологийн салбарт "Шинжлэх ухаан, Инновацийн төвийн цогцолбор" байгуулах түүхэн том бүтээн байгуулалтыг хийж байна.

Цогцолбор байгуулахад 2020-2022 онд нийт **42** тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, 2022 оны гүйцэтгэлээр **10** тэрбум төгрөг нэмж санхүүжүүлсэн. 2023 онд **25.7** тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсвийн төсөлд тусгасан.


**Зураг 7.7 Шинжлэх ухаан, инновацийн төвийн цогцолборт зарцуулж буй хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг**





# 7.6 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зураг 7.8 Шинжлэх ухаан, технологи, инновацийн шалгуур үзүүлэлтүүд




\*Тайлбар: 2022 оны ШУТ-ийн салбарын статистикийн мэдээ 2023 оны 3 сарын 25-нд гарна.


БШУЯ-аас Монгол Улсын хэмжээнд анх удаа хувийн хэвшлийн инновац, судалгаа хөгжүүлэлтийн мэдээллийг цуглуулах ажлыг санаачилан Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан “Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого”-д нэмэлт асуулга оруулж, хамтран ажиллалаа.

Зураг 7.9 Аж ахуйн нэгжийн инновац нэвтрүүлэлт

Аж ахуйн нэгжийн тоо, тооллого явагдсан оноор



Инновац нэвтрүүлсэн болон нэвтрүүлээгүй аж ахуйн нэгж, хувиар, 2018-2021



Эх үүсвэр: УСХ, БШУЯ, Инновац судалгаа хөгжүүлэлт, сэдэвчилсэн судалгааны тайлангаас

2021 оны ААН-ийн улсын тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн **57.6** мянга (**38.0%**) нь 2018-2021 онд үйл ажиллагаа явуулж, тэдгээрийн **17.1** мянга (**29.6%**) нь инновацийн аль нэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн эсвэл инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бол **40.6** мянга (**70.4%**) нь инновацийн чиглэлээр ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн **93.0** хувийг компани, **0.3** хувийг ТӨҮГ/ОНӨҮГ, **0.9** хувийг бусад төрлийн нэгж эзэлж байна. Инновац хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжийн **93.5** хувийг компани, **0.9** хувийг ТӨҮГ/ОНӨҮГ, **1.5** хувийг бусад төрлийн нэгж эзэлж байгаа нь нийт аж ахуйн нэгжийн эзлэх хувийн жингээс **0.5-0.7** нэгж хувиар их байгаа нь энэ төрлийн нэгжүүд инновац хэрэгжүүлж байгаа нь их байгааг илэрхийлж байна.



**Зураг 7.10 Инновац нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэр, 2018-2021 он**



Эх үүсвэр: УСХ, БШУЯ, Инновац судалгаа хөгжүүлэлт, сэдэвчилсэн судалгааны тайлангаас

**Хүснэгт 7.7 Инновацийн хэрэгжүүлэлт, үйл ажиллагааны чиглэлээр**

Үйл ажиллагааны чиглэл	Тооллогод хамрагдсан		Инновац хэрэгжүүлсэн		Инновац хэрэгжүүлэлт
	Тоо	%	Тоо	%	
<b>БҮГД</b>	<b>151,557</b>	<b>100.0</b>	<b>17,053</b>	<b>100.0</b>	<b>-</b>
Хөдөө аж ахуй	8,230	5.4	584	3.4	-2.0
Уул уурхай	2,582	1.7	255	1.5	-0.2
Боловсруулах	12,996	8.6	1,862	10.9	2.3
Барилга, дэд бүтэц	14,570	9.6	1,763	10.3	0.7
Худалдаа	62,299	41.1	5,690	33.4	-7.7
Бөөний худалдаа	39,210	25.9	2,670	15.7	-10.2
Жижиглэнгийн худалдаа	23,089	15.2	3,020	17.7	2.5
Үйлчилгээ	50,880	33.6	6,899	40.5	6.9
Тээврийн хэрэгсэлийн засвар, худалдаа	3,548	2.3	335	2.0	-0.4
Боловсрол	2,517	1.7	475	2.8	1.1

Үйл ажиллагааны чиглэл	Тоологод хамрагдсан		Инновац хэрэгжүүлсэн		Инновац хэрэгжүүлэлт
	Тоо	%	Тоо	%	
Зочид буудал, зоогийн газар	4,791	3.2	642	3.8	0.6
Санхүү, даатгал	4,167	2.7	646	3.8	1.0
Тээвэр, агуулах	5,071	3.3	605	3.5	0.2
Удирдлага	9,613	6.3	875	5.1	-1.2
Урлаг, үзвэр	673	0.4	57	0.3	-0.1
Үл хөдлөх хөрөнгө	2,022	1.3	315	1.8	0.5
Шинжлэх ухаан	9,706	6.4	1,304	7.6	1.2
Эрүүл мэнд	2,547	1.7	742	4.4	2.7
Бусад	6,225	4.1	903	5.3	1.2


Эх үүсвэр: УСХ, БШУЯ, Инновац судалгаа хөгжүүлэлт, сэдэвчилсэн судалгааны тайлангаас

**Зураг 7.11 2020 онд үйл ажиллагаа явуулсан болон инновац хэрэгжүүлсэн ААН-ийн тоон тархалтын гистограм, орлогын дүнгээр**



Эх үүсвэр: УСХ, БШУЯ, Инновац судалгаа хөгжүүлэлт, сэдэвчилсэн судалгааны тайлангаас

**Зураг 7.12 Судалгаа, хөгжлийн салбарын зардлын ДНБ-д эзлэх хувь, 2015-2021 он**



Эх үүсвэр: УСХ, БШУЯ, Инновац судалгаа хөгжүүлэлт, сэдэвчилсэн судалгааны тайлангаас




## 7. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР



БШУЯ-с тооцсон шинжлэх ухааны салбарын зардлаас харахад 2021 онд шинжлэх ухааны салбарын зардал нь **48.2** тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий **0.1** хувийг эзэлж байгаа бол ҮСХ-ноос тооцсон судалгаа, шинжилгээний зардал нь 2021 онд **301.7** тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий **0.7** хувийг эзэлж байна. Харин ДНБ-д эзлэх судалгаа хөгжүүлэлтийн зардал Европ, Хойд Америк, Зүүн болон Зүүн өмнөд Азид **2.31-2.629** байна. Тус үзүүлэлт нь улс орон шинжлэх ухааны хөгжилдөө хэрхэн анхаарч байгаа, цаашлаад улс орны эдийн засгийн хөгжлийн ялгааг илтгэх гол үзүүлэлт болдог тул илүү их хөрөнгийг зарцуулах бодлого, чиглэл чухал байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарт тухайн улс хэрхэн анхаарал тавьж буйг дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хичнээн хувийг судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буйгаар хэмжих нь түгээмэл байдаг бөгөөд ТХЗ-ын **9.5.1** дүгээр шалгуур үзүүлэлтээр тооцдог. Монгол Улсын эдийн засаг 2020 онд **4.6** хувиар буурч, дотоодын нийт бүтээгдэхүүн **37.5** их наяд төгрөгт хүрсэн. Харин төрийн байгууллагын шинжлэх ухааны зардал 2020 онд **50.8** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **0.1** хувийг эзэлж байгаа бол хувийн хэвшлийн байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн зардлыг нэмснээр **61.2** тэрбум төгрөг болж, ДНБ-ий **0.2** хувь болсон байна. Энэ нь манай улс дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх судалгаа хөгжүүлэлтийн ажлын нийт зардлын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Зураг 7.13** Зарим улс орны нэг сая хүн амд ногдох судлаачдын тоо, 2020 он



Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын 9.5.2 дугаар шалгуур үзүүлэлт нь 2030 он хүртэл 1 сая хүн амд ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон судлаачийн тоог нэмэгдүүлэх зорилготой. Энэ удаагийн тооллогын дүнгээр 2020 оны байдлаар 1 сая хүн амд ногдох судалгаа хөгжүүлэлтийн ажилд оролцсон судлаачийн тоо **10,286** байна. 2020 оны байдлаар зарим улс орны **1 сая** хүн амд ногдох судлаачийн тоог авч үзвэл, Бүгд Найрамдах Хятад Ард Улс **1585**, Япон улс **5455**, Казакстан улс **689**, Бүгд найрамдах Солонгос улс **8714** байна.



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГ	ТАЙЛБАР
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>АОД</b>	Анхны онооны дундаж
<b>АХС</b>	Ажиллах хүчний судалгаа
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЖТБ</b>	Жендэрийн тэнцвэрт байдал
<b>МСҮТ</b>	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв
<b>МБТБ</b>	Мэргэжлийн болон техникийн боловсрол
<b>НУБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол
<b>ТӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилго
<b>ХСЦЖ</b>	Хамран сургалтын цэвэр жин
<b>ХОД</b>	Хэмжээст онооны дундаж
<b>ҮНО</b>	Үндэсний нийт орлого
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ШУТИС</b>	Шинжлэх Ухаан Технологийн их сургууль
<b>ШШГЕГ</b>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар











